



МОНГОЛБАНК



ЖИЛИЙН ТАЙЛАН 2009

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ҮГ



Эрхэмсэг хатагтай, ноёд оо!

Монголбанкны хувьд 2009 он банк, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг макро түвшинд хангах хүндхэн сорилтыг даван туулсан он жил болон өнгөрч байна. Монголбанк мөнгөний бодлогын тулгамдсан хэд хэдэн асуудлыг цаг алдалгүй зоримог шийдвэрлэсэн нь эдийн засгийн гүн гүнзгий хямралаас зайлсхийхэд чухал хувь нэмэр оруулсан билээ. Мөнгөний бодлогыг юуны өмнө банкны системийн тогтвортой байдлыг хангах, хадгаламж эзэмшигчдийн дунд хүндрэл, үймээн үүсгэхгүй байх, инфляцийг хяналтанд оруулах, төгрөгийн ханшийг тогтворжуулах, валютын албан нөөцийг сэргээхэд чиглүүллээ.

Оны эхний хагас жилд Монголбанкнаас хэрэгжүүлсэн мөнгөний хатуу бодлого нь хүнд хэцүү ч зайлшгүй авах ёстой арга хэмжээ байв. Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийг

хамгаалахын тулд бодлогын хүүг өсгөн, валютын дуудлага худалдааг зохион байгуулдаг болсноор төгрөгт итгэх итгэл сэргэж, төгрөгийн ханш тогтворжин, банкны системээс харилцах, хадгаламж зугтах явдлыг таслан зогсоож, улмаар мөнгөний бодлогоо зөөлрүүлэх боломжийг бүрдүүлэн энэ оны 5, 6 болон 9 дүгээр саруудад Монголбанкны бодлогын хүүг нийт 3 удаа бууруулав. Бодлогын хүүг даган банкуудын богино хугацаатай эх үүсвэр татах репо санхүүжилт, овернайт зээл зэрэг төв банкны санхүүжилтийн хүү мөн 2.5-3.5 нэгж хувиар буурсан билээ.

Банкуудын зээлжих чадварыг нэмэгдүүлэх үүднээс Монголбанкнаас банк хоорондын захын илүүдэл нөөцийг тууштай өсгөх бодлого баримталсны үр дүнд 2009 оны 1 дүгээр улирлын эцэст -42.0 тэрбум төгрөг байсан банкны системийн цэвэр бэлэн нөөц 4 дүгээр улирлын эцэст 376.9 тэрбум төгрөг болж өсөв. Банк хоорондын захын хүүг бууруулахын тулд Монголбанк төгрөгийн ЗБН-ийн тогтоосон хэмжээнд бодлогын хүүний ¼-тэй тэнцүү хэмжээгээр урамшуулал олгох, төгрөг болон валютын ЗБН-ийн 50 хувиас доошгүй хувийг өдрөөр хангуулах арга хэмжээг авлаа.

Бодит цагийн горим хэмээн нэрлэгддэг банк хоорондын төлбөр тооцоо хийгдсэн тухайн мөчдөө явагддаг системийг 2009 оны 2 дугаар улиралд нэвтрүүлсэнээр Монгол улсын төлбөр тооцооны найдвартай байдал дээшлэн, чанарын шинэ түвшинд очоод байна.

Монголбанкнаас 2009 онд авч хэрэгжүүлсэн олон талт арга хэмжээнээс цөөн хэдийг дурьдахад ийм байна. Үүний үр дүнд инфляцийн түвшин тууштай буурч, улсын хэмжээнд 4.2 хувь, Улаанбаатар хотын түвшинд 1.9 хувь болж, гадаад валютын нийт албан нөөц 1.3 тэрбум ам.доллар болж, үндэсний мөнгөн тэмдэгтийн ханш тогтворжив. Ийнхүү макро түвшний тогтворжилтын үндсэн зорилт хангагдаж, цаашид эдийн засгийн өсөлтийг сэргээх, урт хугацаанд хадгалах хөрс суурь тавигдаж байна.

Харин 2010 онд Монголбанкны өмнө тулгамдаж буй үндсэн зорилт нь микро түвшний хүндрэл бэрхшээлийг даван туулахад оршиж байна. Монголбанк бодлогоо банкуудын чанаргүй зээлийг шийдвэрлэхэд, улмаар зээлийн тасалдлыг зогсоход чиглүүлэх болно. Банкуудын зээлийн багцад олон улсын хөндлөнгийн аудитын байгууллагаар үнэлгээ дүгнэлт хийлгэж, банкны салбарын хүндрэл бэрхшээлийг даван туулах арга замыг иж бүрэн тодорхойлон хэрэгжүүлэх ажлыг эхлүүлэх болно. Үүний сацуу зээлийн хүүг бууруулах стратеги төлөвлөгөөг боловсруулан зээлийн олдоц, хүртээмжийг нэмэгдүүлэх тал дээр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Л.Пүрэвдорж
Монголбанкны Ерөнхийлөгч



1. МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ҮНДСЭН ЗОРИЛТ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ
 - 1.1. Мөнгөний бодлогын хэрэгжилт
 - 1.2. Мөнгөний үзүүлэлтүүдийн байдал
 - 1.3. Валютын ханшийн бодлого
 - 1.4. Улсын валютын нөөцийн удирдлага
 - 1.5. Эрсдэлийн удирдлага
2. БАНКНЫ САЛБАРЫН ХӨГЖИЛ
 - 2.1. Банкны салбарын өнөөгийн байдал, учирч буй бэрхшээл
 - 2.2. Банкны хяналт шалгалтын үйл ажиллагаа
3. ТӨВ БАНКНЫ БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА
4. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ
 - 4.1. Бодит эдийн засгийн хөгжил
 - 4.2. Төлбөрийн тэнцэл
 - 4.3. Үнэ
 - 4.4. Засгийн газрын санхүү
 - 4.5. Хөрөнгийн зах зээлийн хөгжил
5. МОНГОЛБАНКНААС 2009 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДЛОГЫН БА ТЕХНИКИЙН ШИНЖ ЧАНАРТАЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУРААНГУЙ
6. АУДИТОРЫН ТАЙЛАН
7. СТАТИСТИКИЙН ХАВСРАЛТУУД

1.1. Мөнгөний бодлогын хэрэгжилт

Монголбанк 2009 оны эхэнд санхүүгийн тогтворгүй байдлыг арилгах бодлогын хэд хэдэн шийдвэрийг цаг алдалгүй гаргасан нь макро эдийн засгийн гүнзгий хямралаас зайлсхийх боломжийг бүрдүүлсэн билээ. Тухайлбал үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийг хамгаалахын тулд бодлогын хүүг тухайн үед 14.0 хувь хүртэл өсгөн, валютын дуудлага худалдааг зохион байгуулснаар төгрөгт итгэх итгэл сэргэж, төгрөгийн ханш тогтворжин, банкны салбараас хадгаламж дайжих хандлага зогсч, улмаар мөнгөний бодлогоо зөөлрүүлэх боломжийг бүрдүүлэн 2009 оны 5, 6 дугаар сард бодлогын хүүгээ тус бүр 1.25 нэгж хувиар, 9 дүгээр сард дахин 1.5 нэгж хувиар бууруулж 10.0 хувьд хүргэж буулгаад байна. Мөнгөний бодлогын хүрээнд төгрөгийн ханшийг тогтворжуулах, макро эдийн засгийн тогтворгүй байдлаас урьдчилан сэргийлэх, инфляцийг шат дараатай бууруулах зорилгоор 2009 оны эхний хагас жилд дараах арга хэмжээг Монголбанкнаас авлаа. Үүнд:

1. 2009 оны эхэнд төгрөгийн хямрал өрнөж болзошгүй нөхцөл байдал үүссэн тул Монголбанк мөнгөний бодлогын хүүг 4.25 нэгж хувиар нэмэгдүүлсэн төдийгүй валютын дуудлага худалдааг 7 хоногт 2 удаа тогтмол зохион байгуулдаг болсноор валютын ханшийн хэт хөөрөгдлөөс зайлсхийх боломжийг бүрдүүлж валютын захын тогтвортой байдлыг ханган ажиллав. Үүний зэрэгцээ банкуудын активын өгөөжийг нэмэгдүүлэх, хадгаламжийн хүү өсөх боломжийг бүрдүүлэх, мөнгөний зах дээрх төгрөгийн өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор харьцангуй урт буюу 12 долоо хоногтой ТБҮЦ-ны хүүний дээд хязгаарыг 20 хувь болгож нэмэгдүүлэв.
2. Банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадвар доройтох хүндрэлийг арилгах, Анод болон Зоос банкны асуудлыг шийдвэрлэх үүднээс Монголбанк 2008 оны эцсээс банкуудад барьцаат зээл олгосон бөгөөд 2009 оны эцэс хүртэл нийт 304.2 тэрбум төгрөгийн зээлийг олгожээ. Уг зээлийн 124.3 тэрбум төгрөг нь эргэн төлөгдөж, үлдэгдэл нь 179.9 тэрбум төгрөг байна.
3. Мөнгөний бодлогын үр ашгийг дээшлүүлэх үүднээс төв банкны хэрэгслүүдийн хүүний бүтцийг шинэчлэв. Үүний дүнд бодлогын хүүнээс репо санхүүжилтийн хүүг 6 нэгж хувиар өндөр, байнгын бус санхүүжилтийн хүүг 9 нэгж хувиар, овернайт зээлийн хүүг 10 нэгж хувиар тус тус өндөр тогтоов.
4. Хүүний зөрүүг багасгах, активын өгөөжийг нэмэгдүүлэх, банк хоорондын захын нөөцийн хэлбэлзлийг бууруулан үйл ажиллагааг нь идэвхжүүлэх үүднээс Монголбанк “Заавал байлгах нөөц тооцож, хяналт тавих журам”-д өөрчлөлт оруулан 2009 оны 3 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн мөрдөж эхлэв. Үүнд: Монголбанкнаас тогтоосон төгрөгийн заавал байлгах нөөцийн хэмжээнд бодлогын хүүний $\frac{1}{4}$ -тэй тэнцүү хэмжээгээр урамшуулал олгох, төгрөг болон гадаад валютын заавал байлгах нөөцийн 50-иас доошгүй хувийг өдрөөр хангуулах, ЗБН тооцох татан төвлөрүүлсэн хөрөнгийн жагсаалтаас дотоодын банк, санхүүгийн байгууллагаас татсан харилцах, хадгаламжийн дансдыг хасч тооцох болов.
5. Банкуудын актив пассивын хугацааны зөрүүг багасгах зорилгоор Монголбанк 28 долоо хоногтой ТБҮЦ-ыг 12 долоо хоногийн хугацаатай ТБҮЦ-тай нэгтгэх ажлыг хийв. Үүний зэрэгцээ 4 долоо хоногт нэг удаа зохиогддог байсан 12 долоо хоногтой ТБҮЦ-ны арилжааг 2 долоо хоног тутам явуулах зарчим руу шилжив.

6. Монголбанк барилгын салбарт зээл олгосон банкуудын үйл ажиллагааг эрсдэлд оруулахгүй байх, эдийн засгийн бодит салбарыг дэмжих үүднээс 2 банкинд нийт 55.7 тэрбум төгрөгийн зээлийн санхүүжилт олгосон байв. Гэвч тухайн зээлийг зориулалтаар нь ашиглаагүй, зээлийн 1/3 хувь нь л зээлдэгчдэд хүрсэн нь шалгалтаар илрэв. Мөн тус санхүүжилтийг авсан цөөн хэдэн компани нь зээлээр барьж буй барилгаа дуусгахад бус харин өмнө авсан банкны зээлийн өрийг төлөх, бусдаас авсан барилгын материалын төлбөрийг барагдуулах зэрэгт ашигласан байв. Ийм учраас тус төрлийн зээлийг Монголбанк эргүүлэн төлүүлэв.

Монголбанк 2009 оны эхний хагаст мөнгөний хатуу бодлогыг цаг алдалгүй хэрэгжүүлснээр мөнгөний зах дээр тогтвортой байдал бий болгон, төгрөгт итгэх итгэлийг сэргээж, ханшийн огцом савлалтаас зайлсхийж чадсан төдийгүй Монголбанкны зарласан болон Найман шарга валютын захын ханшийн зөрүү багассан юм. Монголбанк 2009 оны 2 дугаар хагаст мөнгөний бодлогыг тууштай зөөлрүүлэх замаар 2010 оны эдийн засгийн бодит өсөлтийг тэтгэх суурийг нэгэнт бүрдүүлж эхлээд байна. Мөнгөний бодлогыг зөөлрүүлэх зорилгоор Монголбанк дараах арга хэмжээ аваад байна. Үүнд:

1. Валютын ханш тогтворжиж, банкуудын төлбөр тооцоо түргэн гүйцэтгэх чадвар сайжирч, бодлогын хэрэгслүүдэд зохих өөрчлөлт орсноор Монголбанк бодлогын хүүг 5 дугаар сард 1.25 нэгж хувиар бууруулж 12.75 хувь, 6 дугаар сард дахин 1.25 нэгж хувиар бууруулж 11.5 хувьд хүргэв. Мөн хугацаанд инфляци хурдацтай буурснаар бодлогын хүү бодит илэрхийллээр эерэг болов. Монголбанкнаас зөвхөн бодлогын хүүг бууруулаад зогсохгүй банкуудын зээл олгох сонирхлыг хөхүүлэн Төв банкны үнэт цаасны хэмжээг хязгаарлав.
2. Мөнгөний захын тогтвортой байдал 2009 оны 3 дугаар улиралд улам бэхжиж эдийн засгийн зарим салбарт сэргэлт ажиглагдаж эхэлсэн нь бодлогын хүүг дахин 9 дүгээр сарын 30-ны өдрөөс эхлэн 1.5 нэгж хувиар бууруулан 10 хувь болгох таатай боломжийг олгов. Бодлогын хүүг 10 хувь болгохын сацуу банкуудын богино хугацаатай эх үүсвэр татах өртгийг бууруулах зорилгоор Төв банкны хүүний бүтцийг дараах байдлаар өөрчлөв. Үүнд, бодлогын хүүнээс репо санхүүжилтийн хүүг 4 нэгж хувиар өндөр буюу 14 хувь, овернайт зээлийн хүүг 9 нэгж хувиар өндөр буюу 19 хувь, байнгын бус санхүүжилтийн хүүг 8 нэгж хувиар өндөр буюу 18 хувь байхаар тогтоов. Ингэснээр өмнөх бүтэцтэй харьцуулахад репо санхүүжилтийн хүү 3.5 нэгж хувиар, байнгын бус санхүүжилтийн хүү 2.5 нэгж хувиар, овернайт зээлийн хүү 2.5 нэгж хувиар тус тус буурав.
3. Алт олборлох үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор Сангийн яам бонд гаргаж 89.5 сая ам.долларын эх үүсвэр татаж банкуудад дамжуулан олгохоор шийдвэрлэв. Дээрх зээлийн ашиглалтын талаар Сангийн яам, Монголбанк, банкууд гурвалсан гэрээ байгуулж, 2009 оны 5, 6 дугаар сард эхний ээлжийн 66.25 сая ам.долларыг жилийн 13 хувийн хүүтэй, нэг жилийн хугацаатайгаар банкуудад зээлдүүлэв. Банкуудаар дамжуулан алт олборлох үйл ажиллагаа эрхэлж буй 23 компанид 44.9 сая ам.долларын зээл олгосон байна.
4. 2009 оны 11 дүгээр сарын 6-нд ЗБН-ийн хэмжээнд бодлогын хүүний 1/4-тэй тэнцүү хэмжээгээр урамшуулал олгохыг зогсоов. Банк хоорондын захын жигнэсэн

дундаж хүү 1 дүгээр улирлын эцэст 17.9 хувь байсан бол 2 дугаар улирлын эцэст 15.1 хувь, 3 дугаар улирлын эцэст 11.5 хувь, 4 дүгээр улирлын эцэст 8.6 хувь болон тус тус буурав.

5. Банкуудын зээлжих чадварыг нэмэгдүүлэх үүднээс Монголбанкнаас банк хоорондын захын илүүдэл нөөцийг тууштай өсгөх бодлого баримтласны үр дүнд 2009 оны 1 дүгээр улирлын эцэст -42.0 тэрбум төгрөг байсан банкны салбарын цэвэр бэлэн нөөц 2009 оны эцэст 376.9 тэрбум төгрөг болж өсөв.
6. Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор Монголбанк Засгийн газрын нэг жилийн хугацаатай 170 тэрбум төгрөгийн 3 багц үнэт цаасыг худалдаж авав. Үүний 60 тэрбум төгрөг нь 5 хувийн, 55 тэрбум нь 7.5 хувийн, үлдсэн 55 тэрбум нь 10 хувийн хүүтэй үнэт цаас юм.

Монголбанкнаас 2009 онд хэрэгжүүлсэн мөнгөний бодлогын үр дүнд инфляцийн түвшин буурч Улаанбаатар хотын түвшинд оны эцэст 1.9 хувьтай, улсын түвшинд 4.9 хувьтай гарав. Гадаад валютын нийт албан нөөц 1.3 тэрбум ам.долларыг давж, ам.доллартай харьцах төгрөгийн ханш харьцангуй тогтворжив.

Нөөц мөнгө

Нөөц мөнгөний хэмжээ 2009 онд 15.7 хувиар өсч 733.1 тэрбум төгрөгт хүрлээ. Төв банк 2007-2008 онд эдийн засгийн хэт халалтыг саармагжуулах, инфляцийг бууруулах, банк хоорондын захыг идэвхжүүлэх, нөөц мөнгөний хэлбэлзлийг бууруулах зорилгоор банкны салбарын илүүдэл нөөцийг бууруулах бодлого баримталж байсан бол 2009 онд банк хоорондын захын хүүг бууруулах, банкуудын зээл олголтыг нэмэгдүүлэх зорилгоор нөөц мөнгөний удирдлагадаа өөрчлөлт оруулж, илүүдэл нөөцийг нэмэгдүүлэх бодлогыг 6 дугаар сараас хэрэгжүүлсэн билээ. Ингэснээр банкуудын Төв банкин дахь харилцах, хадгаламжийн хэмжээ оны эхнээс нөөц мөнгөний өөрчлөлтийн 135.5¹ хувьтай тэнцэх хэмжээгээр буюу 134.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, нөөц мөнгөний өсөлтөд нөлөөлсөн байна. Манай улсын эдийн засгийн төлөв байдал муудаж, мөнгө болон зээлийн эрэлт буурснаар гүйлгээнд байгаа мөнгөний хэмжээ 43.7 тэрбум төгрөгөөр буюу нөөц мөнгөний өөрчлөлтийн 44.0² хувьтай тэнцэх хэмжээгээр буурсан байна.


Тайлант онд Төв банкин дахь харилцах, хадгаламжийн нөөц мөнгөнд эзлэх хувь өсч, банкнаас гадуурх мөнгө, банкуудын кассын эзлэх хувь буурсан. Тухайлбал, банкуудын Төв банкин дахь харилцах, хадгаламжийн нөөц мөнгөнд эзлэх хувь 2009 онд 49.3 хувь болж, өнгөрсөн оноос 13.6 нэгж хувиар нэмэгдсэн байна. Харин банкнаас гадуурх мөнгө болон банкуудын кассын нөөц мөнгөнд эзлэх хувь тус бүр 38.9 болон 11.8 хувь болж, өнгөрсөн онтой харьцуулахад харгалзан 13.0 болон 0.6 нэгж хувиар тус тус буураад байна.

¹ 2008 онтой харьцуулахад 79.3 нэгж хувиар нэмэгдсэн

² 2008 онтой харьцуулахад 90.0 нэгж хувиар буурсан

Зураг 1

Нөөц мөнгөний
бүрэлдэхүүн
хэсгүүд



Зураг 2

Нөөц мөнгөний
бүтцийн
өөрчлөлт



Зураг 3

Нөөц мөнгө ба
түүний бүрэлдэхүүн
хэсгүүдийн өөрчлөлт
/пассив тал/



Нөөц мөнгөний актив талын бүтцийг авч үзвэл Төв банкны гадаад цэвэр актив тайлант онд 733.9 тэрбум төгрөгөөр буюу 91.2 хувиар өссөн нь нөөц мөнгөний өсөлтөд хүчтэй нөлөөлсөн. Төв банкны гадаад валютын цэвэр албан нөөц 2009 онд 508 сая ам.доллараар буюу 79.7 хувиар өссөн нь Төв банкны гадаад цэвэр активын өсөлтийг бий болгосон.

Тайлант онд Төв банкны дотоод цэвэр актив /ДЦА/-ын хэмжээ 634.0 тэрбум төгрөгөөр буюу 3.7 дахин буурсан нь ТБҮЦ-ны өсөлттэй холбоотой. Монгол улсаас болон банкны салбараас мөнгөн хөрөнгө зугатах үзэгдэл зогсч, гадаад валютын дотогшлох урсгал нэмэгдсэн нь банкны салбарын мөнгөн хөрөнгийн нөөцийг ихээхэн нэмэгдүүлсэн. Эдийн засгийн хямрал, зээлийн тасалдал нь банкуудын ашиг, өөрийн хөрөнгийг бууруулж, улмаар банкуудын төлбөрийн чадварыг доройтуулж байв. Мөн банкуудын ихээхэн хэмжээний сул мөнгөн хөрөнгийн нөөц валютын ханшийн савалгааг үүсгэх эрсдэлийг нэмэгдүүлж байсан нь Төв банкны хувьд банк хоорондын зах дээрх илүүдэл нөөц болон нөөц мөнгөний удирдлагад нэлээдгүй хүндрэлийг бий болгож байлаа. Банкууд төлбөр түргэн гүйцэтгэх чадварын хүндрэлд орсон үед Төв банкнаас банкуудад олгосон барьцаат зээл болон дахин санхүүжилтийн зээл 44.6 тэрбум төгрөгөөр эргэн төлөгдсөн нь ДЦА-ыг 7 хувиар бууруулсан байна. Мөн ЗГЦЗ 82.5 тэрбум төгрөгөөр, бусад цэвэр актив 234.6 тэрбум төгрөгөөр буурсан нь Төв банкны ДЦА-ын бууралтад нөлөөлсөн байна.

Хүснэгт 1. Банкны салбарын нөөцийн өөрчлөлт /хүчин зүйлээр/


	Нийлүүлэгдсэн (Н)	Татагдсан (Т)	Цэвэр дүн (Н-Т)
Төв банкны бодлогын хэрэгсэл			
Байнгын санхүүжилт	476.5	486.0	-9.5
Байнгын бус санхүүжилт	148.2	182.0	-33.8
ТБҮЦ		272.7	-272.7
Дүн (а)	624.7	940.8	-316.1
Төв банкнаас үл хамаарах хүчин зүйлс			
Гадаад цэвэр активын өөрчлөлт ³	733.9		733.9
ЗГЦЗ-ийн өөрчлөлт		82.5	-82.5
Бусад дотоод цэвэр активын өөрчлөлт		235.4	-235.4
Гүйлгээнд байгаа мөнгөний өөрчлөлт	35.4		35.4
Дүн (b)	733.9	353.3	451.3
Банкуудын нөөц			
ЗБН (с)			28.3
Төгрөгийн			16.1
Гадаад валютын			12.3
Илүүдэл нөөц (d)			106.9
Төгрөгийн			165.0
Гадаад валютын			-58.1
Дүн (а)+(b) буюу (с)+(d)			135.2

Банкны салбарын нөөцийн өөрчлөлтийн хүснэгтээс харвал тайлант онд Төв банкнаас үл хамаарах хүчин зүйлсийн нөлөөгөөр банк хоорондын захад 451.3 тэрбум төгрөгийн нөөц нийлүүлэгдсэнээс Төв банк бодлогын хэрэгслүүдээрээ дамжуулан нийт

³ Гадаадын харилцагч банкууд дээр байршиж буй Төв банкны ГЦА нь эдийн засгийн агентуудын Төв банкаар дамжуулан гүйцэтгэж байгаа гадаад төлбөр тооцооноос хамааран өөрчлөгддөг тул Төв банкнаас үл хамаарах хүчин зүйлс /autonomous factor/-д хамааруулдаг. Төв банкны мөнгөний бодлого нь экспорт, импорт, хөрөнгийн орох, гарах урсгал зэрэг эдийн засгийн үйл хөдлөлд нөлөөлдөг тул дам утгаараа ГЦА нь Төв банкнаас хамаардаг хүчин зүйл юм.


Зураг 4

Нөөц мөнгө ба
түүний бүрэлдэхүүн
хэсгүүдийн өөрчлөлт
/актив тал/



Зураг 5

Төвбанкны
дотоод цэвэр
активын бүтэц



нийлүүлэгдсэн нөөцийн 70 хувь болох 316.1 тэрбум төгрөгийн нөөцийг эргүүлэн татаж банк хоорондын захын илүүдэл нөөцийг 135.2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Нөөцийн нийлүүлэлтийн бүтцийг авч үзвэл Төв банкны ГЦА-ын өсөлтөөр 733.9 тэрбум төгрөг, гүйлгээнд байгаа мөнгөний бууралтаар 35.4 тэрбум төгрөгийн нөөц нийлүүлэгдсэн байна. Олон улсын валютын сан, Монгол Улсын Засгийн газар, Төв банк хамтран хямралын эсрэг Стэнд-бай хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлснээр Монгол улсын гадаад валютын дотогшлох урсгал нэмэгдсэн нь Төв банкны гадаад цэвэр актив, гадаад валютын цэвэр албан нөөц их хэмжээгээр өсөхөд нөлөөлсөн байна. Харин ЗГЦЗ-ийн болон бусад ДЦА-ын бууралтаар 317.9 тэрбум төгрөгийн нөөц банк хоорондын захаас татагдсан байна.

Манай улсын эдийн засгийн улирлын шинж чанартай хэлбэлзлүүд нь нөөц мөнгө болон түүний бүрэлдэхүүн хэсгүүдийг өөрчилдэг билээ. Сүүлийн жилүүдэд ажиглагдсан нөөц мөнгөний улирлын хэлбэлзэл өсөх хандлага тайлант онд давтагдсан бөгөөд энэ нь банкуудын харилцах, хадгаламжийн улирлын хэлбэлзэл нэмэгдэх байдлаар илэрлээ. Харин бэлэн мөнгөний эрэлтийг тодорхойлдог банкнаас гадуурх мөнгөний улирлын хэлбэлзэл сүүлийн жилүүдийн хандлагыг даган буурсан байна. Банкнаас гадуурх мөнгө 2008 оны 12 дугаар сараас 2009 оны 2 дугаар сарын хооронд огцом хэлбэлзсэн нь иргэд, ААН байгууллагууд Анод банкин дахь харилцах, хадгаламжаа авч, тухайн үед банкны салбарт үүсээд байсан тодорхой бус байдалтай холбоотойгоор бий болсон бэлэн мөнгөний эрэлтийн хэлбэлзэл байлаа.

Мөнгөний бодлогын хүү

Монгол улсын нийгэм, эдийн засгийн байдал 2009 оныг нэн төвөгтэй хүнд нөхцөлд угтсан юм. Гадаад худалдааны тэнцлийн алдагдал нэмэгдэхийн хэрээр гадаад валютын албан нөөц буурч улмаар төгрөгийн ханш богино хугацаанд огцом үнэгүйдэх нөхцөл бүрдсэн байв. Төрийн албан хаагчдын цалин, нийгмийн халамжийн зарлага, мөнгөний нийлүүлэлт, банкны зээлийн хурдацтай өсөлт, хүнс болон нефтийн бүтээгдэхүүний үнийн огцом өсөлт, дэд бүтэцтэй холбоотой хүндрэлүүд үнийн дарамтыг ихээхэн нэмэгдүүлснээс инфляци 2008 оны эцэст 22.1 хувьтай гарсан. Банкууд бэлэн нөөцийн хомсдолд орж, зээл олголт, эргэн төлөлтөд хүндрэл үүссэн байлаа. Ийм нөхцөлд Төв банкнаас бодлогын түвшинд шуурхай, хүчтэй нөлөөлөх арга хэмжээ авах шаардлага зүй ёсоор тавигдсан юм.

Мөнгөний бодлогын хэрэгслүүд дотроос бодлогын хүү бодлогын чиг хандлагыг тодорхойлогч нь болдог. Монголбанк бодлогын хүүг эдийн засгийн өнөөгийн байдал, хэтийн төлөвт нийцүүлэн тогтоодог билээ. Өмнө тайлбарласан хямралыг даван туулах, Монгол улс ОУВС-тай хамтран хэрэгжүүлж байгаа Стэнд-бай /Stand-by/ хөтөлбөрөөр хүлээсэн үүргийн дагуу Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар 2009 оны 3 дугаар сард Монголбанкны хүүний бүтцийг шинэчилж, 7 хоногийн хугацаатай Төв банкны үнэт цаасны хүү буюу мөнгөний бодлогын хүүг 4.25 нэгж хувиар өсгөж, жилийн 14 хувь болгосон.


Тус арга хэмжээ нь Төв банкны санхүүжилтийн хүүнүүдийг бодлогын хүүтэй уях замаар банк хоорондын захын хүүний хэлбэлзэх хүрээг тодорхойлж, банк хоорондын захын

Зураг 6

Нөөц мөнгө болон
түүний бүрэлдэхүүн
хэсгүүдийн улирлын
хэлбэлзлийн хандлага




Улирлын хэлбэлзлийн индекс (банкаас гадуурх мөнгө)



Банкуудын харилцах, хадгаламжийн бодит ба засварлагдсан утга




Улирлын хэлбэлзлийн индекс



хүүг удирдах боломжийг нэмэгдүүлсэн. Түүнчлэн, бодлогын хүүг нэмэгдүүлснээрээ банкуудын ТБҮЦ-аас олох хүүний орлогыг өсгөх замаар валютын захын гол оролцогсад болох банкуудын төгрөгийн эх үүсвэрийн өгөөжийг нэмэгдүүлэхийг зорьсон. Энэ тохиолдолд валютын эрэлт буурч, төгрөгийн ханшид үзүүлэх дарамт сулрах ёстой байв. Гэхдээ дан ганц бодлогын хүү өссөнөөр ханшийн хэлбэлзэл тогтворжсон гэж үзэж болохгүй юм. Үүнээс гадна, тус бодлогын арга хэмжээтэй зэрэгцээд ОУВС-тай тохирсон хөтөлбөрийн дагуу Монгол улсад олгосон зээлийн хөрөнгө, бусад олон улсын байгууллагууд, Монголд хөрөнгө оруулдаг орнуудын Засгийн газрын дэмжлэг, санхүүжилтийн үр дүнд зах зээл дээрх гадаад валютын ханш сулрах хүлээлт арилж, валютын ханш харьцангуй тогтворжиж ирсэн юм.

2009 оны 2 дугаар улирлаас эхлэн санхүүгийн зах тогтворжиж, инфляци буурсан боловч, “зээлийн тасалдал” үргэлжилж, эдийн засаг мөнгөний дутагдалд орсон хэвээр байсан тул Монголбанкнаас нөхцөл байдлыг дүгнэн үзээд, банкуудын зээл олгох нөхцлийг бүрдүүлэх, бодит секторыг дэмжих үүднээс бодлогын хүүг 5 болон 6 дугаар саруудад тус бүр 1.25 нэгж хувиар бууруулж жилийн 11.5 хувьд хүргэсэн.

Зураг 7
Төв банкны
хүүний бүтэц



Дээрх бодлогын арга хэмжээг хэрэгжүүлсний дараа ч мөнгөний зах, бодлогын хүүний түвшин өндөр байгааг харуулж эхэлсэн буюу хүүгээр өрсөлддөг ТБҮЦ-ны хүү болон банк хоорондын захын хэлцлийн хүүний түвшин бодлогын хүүнээс доошоо орлоо гэсэн хэдий ч эдийн засагт хүүг бууруулах шаардлага оршин байсаар байв. Тухайлбал, хүүний түвшинг буулгах болсон үндсэн нөхцөл нь банкны системийн хэмжээгээр зээлийн тасалдал үргэлжилж байсан нь эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлж, ажилгүйдэл өсөх, эдийн засгийн зарим салбарыг гүнзгий хямралд оруулж байв. Мөн түүнчлэн, тайлант оны 8-р сард ХҮИ-ийн жилийн өөрчлөлт хасах гарсан нь эдийн засагт бодит хүүний дарамтыг өсгөөд зогсохгүй түүнээс үүдэн санхүүжилтийн зардал өсч улмаар зээлдэгчдийн эргэн төлөлтөд сөргөөр нөлөөлөх, банкуудын мөнгөн урсгалыг муутгах сөрөг үр дагаварыг үзүүлэх болов. Дээр үүссэн нөхцөл байдлаас үүдэн Монголбанкнаас 2009 оны 9 дүгээр сард мөнгөний бодлогын хүүгээ 1.5 хувиар бууруулж жилийн 10.0 хувьд хүргэв. Тус бодлогын арга хэмжээний хамтаар бодлогын хүүний бүтцийг өөрчилж, илүү нарийн болгосон. Өөрөөр хэлбэл, бодлогын хүүг бууруулахын зэрэгцээ, хүүний коридорын дээд хүүг бууруулж, нарийсгасан.

Төв банкны үнэт цаас

Тайлант онд Монголбанк төгрөгийн өгөөжийг нэмэгдүүлэх, төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг тогтворжуулах, макро эдийн засгийн болон санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, инфляцийг зорилтот түвшинд байлгах, эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгоход дэмжлэг үзүүлэхэд мөнгөний бодлогыг чиглүүлэн ажиллав. Макро эдийн засаг болон банк санхүүгийн зах зээлийн нөхцөл байдлаас шалтгаалан мөнгөний бодлогын гол хэрэгсэл болох Төв банкны үнэт цаас (ТБҮЦ)-аар дамжуулан мөнгөний бодлогыг хэрэгжүүлсэн бөгөөд мөнгөний бодлогын үр ашгийг сайжруулахад чиглэгдсэн арга хэмжээнүүдийг авч ажиллалаа.

ТБҮЦ-ны арилжааг тогтмол хүүтэй болон хүүгээр өрсөлдөх хоёр төрлөөр явуулав. Долоо хоногийн хугацаатай үнэт цаасны арилжааг тайлант оны эхний хагас жилд тогтмол хүүтэй буюу арилжааны хүүг Монголбанкнаас зарлах зарчмаар явуулж, хоёрдугаар хагасаас эхлэн хэмжээг хязгаарлан арилжаалав. Энэ нь нөөц мөнгөний зорилтыг хангах, мөнгөний бодлогыг зөөлрүүлэх үүднээс хийсэн бодлогын арга хэмжээний нэг байв. Харин 12, 28 долоо хоногийн хугацаатай үнэт цаасыг хүүгээр өрсөлдүүлэх зарчмаар тус тус арилжааллаа.

Тайлант онд Монголбанк нийт 77 удаа ТБҮЦ-ны арилжаа зарлаж, өссөн дүнгээр 6628.7 тэрбум төгрөгийн үнэт цаасыг борлуулсан байна. Тайлант оны эцсийн байдлаар ТБҮЦ-ны үлдэгдэл 396 тэрбум төгрөгт хүрчээ. Энэ нь өмнөх улиралтай харьцуулахад 13.2 хувиар буурсан үзүүлэлт боловч өмнөх оны мөн үеэс 3.3 дахин өссөн үзүүлэлт юм. Ийнхүү өссөн шалтгаан нь зах зээлийн болон зээлийн эрсдэл нэмэгдсэнээс банкуудын зээлийн бодлого өмнөхөөс илүү болгоомжтой болж шинээр олгох зээлийн хэмжээ багассанаас тайлант оны сүүлийн хагасаас эхлэн банкуудын илүүдэл нөөцийн хэмжээ өссөнтэй холбоотой байна. Монголбанк төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн тогтвортой байдлыг хангах үүднээс ТБҮЦ-ны хэмжээг нэмэгдүүлэн, зарим арилжааг хэмжээ хязгаарлалгүй банкуудын эрэлтэнд үндэслэн явуулж байв. Монголбанк оны туршид өдөрт дунджаар 218.4 тэрбум төгрөгийн ТБҮЦ-ыг банкуудад байршуулж байсан нь 2008 оныхоос 3.2 дахин өссөн үзүүлэлт юм.

ТБҮЦ-ны жигнэсэн дундаж хүү 2009 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 10.82 хувь байгаа нь өмнөх улирлынхаас 1.13 нэгж хувиар, 2008 оны эцсээс 3.88 нэгж хувиар тус тус доогуур байна. Тайлант онд Монголбанк ТБҮЦ-ны хүүний зардалд 27 тэрбум төгрөг төлөв. Энэ нь өмнөх оныхоос 19.2 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлт юм.

2009 оны 3 дугаар сараас 28 долоо хоногтой ТБҮЦ-ны арилжааг зогсоож, 12 долоо хоногтой үнэт цаасыг хоёр долоо хоног тутам банкуудад арилжаалав. Ингэж хоёр төрлийн үнэт цаасыг нэгтгэснээр ТБҮЦ-ны хугацаа банкуудын эх үүсвэрийн дундаж хугацаатай ойртож, актив, пассивын хугацааны зөрүү багасах юм. 12 долоо хоногтой ТБҮЦ-ны арилжааг 14 хоног тутамд зохион байгуулах болсноор санхүүгийн зах зээл хэтэрхий хурдан өөрчлөгдөж байгаа үед банкуудад эх үүсвэрээ илүү уян хатан удирдах боломжийг олгож байна.

Тайлант оны эхний улиралд 28 долоо хоногтой ТБҮЦ-ны арилжааг гурван удаа зохион байгуулсан байна. Харин 12 долоо хоногтой ТБҮЦ-ны арилжааг 22 удаа явуулж, 2009 оны эцсийн байдлаар 216 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна. Тэдгээрийн жигнэсэн дундаж хүү нь 10.92 хувь байлаа.

Заавал байлгах нөөцийн шаардлага

Монголбанкнаас банкуудад тогтоодог Заавал байлгах нөөц(ЗБН)-ийн хувь хэмжээ нь мөнгөний нийлүүлэлтийг хянах, банк хоорондын захын хөрвөх чадварыг зохицуулах нэг хэрэгсэл юм. Тайлант оны эхний улиралд Монголбанк зээл, хадгаламжийн хүүний зөрүүг багасгах, активын өгөөжийг нэмэгдүүлэх, Банк хоорондын зах(БХЗ)-ын нөөцийн хэлбэлзлийг бууруулах зорилгоор “Заавал байлгах нөөц тооцож, хяналт тавих журам”-д нэмэлт өөрчлөлт оруулж мөн оны 3 дугаар сараас эхлэн хэрэгжүүлсэн. Журамд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дүнд ЗБН тооцох татан төвлөрүүлсэн хөрөнгийн жагсаалтаас дотоодын банк, санхүүгийн байгууллагаас татсан харилцах, хадгаламжийн дансыг хасч тооцох, банкууд өдөр бүр төгрөг, валютын заавал байлгах нөөцийн 50-аас доошгүй хувийг хангах шаардлагатай болсон. Үүний зэрэгцээ тайлант оны эхний улиралд төгрөгийн ханш огцом суларч байсантай холбогдуулан банкуудын төгрөгийн заавал байлгах нөөцөд урамшуулал олгох болсон. 2009 оны 4 дүгээр улиралд төгрөгийн ханш тогтворжиж, банкууд илүүдэл нөөц ихтэй болж, банк хоорондын захын хөрвөх чадвар эрс сайжирсан тул мөн оны 11 дүгээр сарын 6-ны өдрөөс эхлэн төгрөгийн заавал байлгах нөөцөд урамшуулал тооцохыг зогсоосон. Түүнчлэн, банкуудын гадаад валютын нөөцийн хэмжээг урамшуулах зорилгоор 2008 оны эцэст авсан арга хэмжээ болох гадаад валютын Төв банк дахь хугацаатай хадгаламжийг валютын заавал байлгах нөөцийн хангалтад тооцох зохицуулалтыг ач холбогдол нь үгүй болсон гэж үзэж тайлант оны 4 дүгээр улиралд зогсоолоо.

Тайлант хугацаанд нийт 27 удаа заавал байлгах нөөцийн хэмжээг төгрөгөөр болон валютаар банк тус бүрээр тогтоож, түүний хангалтыг тооцож холбогдох арга хэмжээ авч ирлээ. Нөөцөө хангаагүй банк 2009 онд цөөхөн байсан бөгөөд оны эцэст салбарын хэмжээгээр нийт 210.8 тэрбум төгрөгийн нөөцийн илүүдэлтэй байв. Энэ нь өнгөрсөн онтой харьцуулахад 93.9 тэрбум төгрөг буюу 80.3 хувиар өссөн дүн юм.

Банкинд олгосон санхүүжилт

Тайлант онд Монголбанк мөнгөний бодлогын үр ашгийг нэмэгдүүлэх, банкуудын нөөцийн удирдлагад дэмжлэг үзүүлэх зорилгоор 2003 онд батлагдсан “Банкинд олгох санхүүжилтийн журам”-ыг хүчингүй болгож, дараах журам, гэрээг шинээр боловсруулан батлав. Үүнд:

- Төв банкны репо санхүүжилтийн журам
- Монголбанкнаас олгох овернайт зээлийн журамд нэмэлт өөрчлөлт оруулах
- Үнэт цаас буцаан худалдан авах нөхцөлтэй зарах Ерөнхий гэрээ
- Төв банкны өдрийн зээлийн түр журам


Өдрийн зээл

Монголбанк 2009 онд банк хоорондын төлбөр тооцоонд гардаг олон төрлийн эрсдэлийг багасгах, төлбөр тооцоог шуурхай хийж гүйцэтгэх зорилгоор Бодит цагийн төлбөрийн горимыг амжилттай нэвтрүүлээ. Төлбөр тооцооны бодит цагийн системийг ашиглах болсонтой холбоотойгоор төлбөрийн системд оролцогч банкуудын



Зураг 8

Банкуудын
төгрөгийн
илүүдэл нөөц ба
ЗБН /2009 он/



Зураг 9

Банкуудын
валютын
илүүдэл нөөц ба
ЗБН /2009 он/

хөрөнгийн удирдлагыг сайжруулах, үр ашигтай болгох, харилцагчийн төлбөр тооцоог саадгүй явуулах хариуцлага улам бүр нэмэгдсэн билээ. Иймээс Монголбанк төлбөрийн системийн хэвийн тасралтгүй ажиллагааг хангах үүднээс өдрийн зээлийн хэрэгслийг шинээр нэвтрүүлэв.

Өдрийн зээлийн хоёр төрлийг бий болгосон бөгөөд эхнийх нь банкуудад өдөрт зээлж болох зээлийн дээд хязгаарыг тогтоож тодорхой хэмжээний төлбөр авах, удаах нь барьцааны активаар бүрэн баталгаажсан өдрийн репо хэлцэл хийх юм. Банкуудын эзэмшиж буй үнэт цаасны төрөл, банкуудын хөрөнгийн удирдлага, програм хангамжийн дэд бүтэц зэргээс хамааран Монголбанк өдрийн зээлийн бодлогыг тодорхойлсон. Монголбанк хүүтэй, барьцаагүй өдрийн зээл, хүүгүй, барьцаатай өдрийн зээл буюу өдрийн репо хэлцэл гэсэн хоёр төрлөөр банкинд өдрийн зээл олгох боллоо. Эхний тохиолдолд Монголбанк тухайн банкинд өдрийн зээлийн дээд хязгаарыг тогтоож, зээлийн эрсдэл хүлээж байгаагийн хувьд тодорхой хэмжээний хүүний төлбөр авдаг бол удаах тохиолдолд Монголбанкнаас хүлээн зөвшөөрсөн үнэт цаас эзэмшиж буй банкинд өдрийн зээл авах боломжийг олгох үүднээс өдрийн репо хэлцэл хийж, хүүгүй өдрийн зээл олгосон байна. Одоогийн байдлаар өдрийн репо хэлцэлд хэрэглэх үнэт цаасны жагсаалтанд зөвхөн ТБҮЦ орж байна.

Түүнчлэн Монголбанк тухайн банкинд Заавал байлгах нөөцөө өдрийн турш төлбөр тооцоонд хэрэглэх боломжийг олгосон юм. Тайлант онд Монголбанк нийт гурван банкинд хүүтэй 7.9 тэрбум төгрөгийн өдрийн зээлийг барьцаагүйгээр, харин нэг банкинд хүүгүй 15.2 тэрбум төгрөгийн өдрийн зээлийг барьцаатайгаар тус тус олгов. Монголбанк өдрийн зээлийн хүүг бодлогын хүүтэй тэнцүү түвшинд байхаар баталсан бөгөөд тайлант онд олгосон өдрийн зээлийн жигнэсэн дундаж хүү 10.84 хувь байна.

Барьцаат зээл

Монголбанк Төв банкны тухай хуульд нийцүүлэн 2008 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар баталсан “Банкинд олгох барьцаат зээлийн журам”-ын дагуу эцсийн зээлдүүлэгчийн хувьд төлбөрийн чадвартай боловч үйл ажиллагаанд нь түр зуурын санхүүгийн хүндрэл гарсан банкинд барьцаат зээл олгодог. Монголбанк тухайн банкиг өөрийн үйл ажиллагааны үр дүнд хүндрэлээс богино хугацаанд гарч чадна гэж үзсэн, зээлийн барьцаа нь Монголбанкны шаардлагыг хангасан тохиолдолд 90 хүртэл хоногийн хугацаатай барьцаат зээл олгодог. Тайлант онд Монголбанк барьцаат зээлийн хүүг бодлогын хүүтэй уялдуулсан хүүний бүтцийг баталсан бөгөөд 2009 оны эцсийн байдлаар барьцаат зээлийн хүү бодлогын хүү дээр нэмэх нь 8 нэгж хувь байна.

Тайлант онд Монголбанк 103.4 тэрбум төгрөгийн барьцаат зээл олгосон бөгөөд үүний 95.6 тэрбум төгрөг нь “Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай хууль”-ийн дагуу олгосон барьцаат зээл, үлдэх 7.8 тэрбум төгрөг нь “Банкинд олгох барьцаат зээлийн журам”-ын дагуу олгосон барьцаат зээл байна. Монголбанкнаас олгосон барьцаат зээлийн үлдэгдэл 2009 оны эцсийн байдлаар 179.9 тэрбум төгрөг байна.

Repo санхүүжилт

Банк санхүүгийн салбарт бий болсон хөрөнгийн дутагдал, банкны салбарын төлбөр түргэн гүйцэтгэх чадвар муудсан зэргээс шалтгаалан тайлант онд Монголбанк зээл, санхүүжилтийн гол журмуудад өөрчлөлт хийв. Тайлант онд Төв банкны репо санхүүжилтийн журмыг шинэчлэн баталж, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2008 онд баталсан Төв банкны зарласан урвуу репо арилжааны журмыг энэхүү шинэ журамд нэгтгэн батлав.

Монголбанк банкны хүсэлтээр олгох репо санхүүжилт, репо арилжаагаар олгох репо санхүүжилт гэсэн хоёр төрлөөр банкттай репо хэлцэл хийдэг боллоо. Эдгээр нь зөвхөн хэн репо хэлцлийг санаачлан хийж байгаа, ямар хэлбэрээр явагдаж байгаа гэдгээрээ өөр бөгөөд банкны хүсэлтээр олгох репо санхүүжилт нь Төв банкны санхүүжилтийн байнгын хэрэгсэлд, харин репо арилжаагаар олгох санхүүжилт нь байнгын бус хэрэгсэлд хамаарна.

Банкны хүсэлтээр олгох репо санхүүжилтийн хүүг Төв банкны бодлогын хүү дээр үндэслэн мөнгөний бодлогод нийцүүлэн Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар баталж тогтоох бөгөөд тайлант оны эцсийн байдлаар бодлогын хүү дээр нэмэх нь 4 нэгж хувийг нэмсэнтэй тэнцүү байна. Харин репо арилжааны хувьд хоёр хэлбэрээр явагдаж болох ба эхнийх нь Монголбанк арилжааны хэмжээ болон хүүг зарлаж, банкууд авах саналаа ирүүлдэг бол удаах нь Монголбанк арилжааны хэмжээг зарлаж, банкууд хэмжээ болон хүүний саналаа ирүүлэх зарчмаар явагдахаар шинэчлэв.

Тайлант онд Монголбанк репо санхүүжилтийн хугацааг 90 хүртэл хоног болгон сунгасан, репо хэлцэлд хэрэглэх үнэт цаасны төрлийг нэмэгдүүлсэн, репо санхүүжилтийн хүүг бодлогын хүүтэй уялдуулсан зэрэг өөрчлөлтүүдийг хийв. Монголын Ипотекийн Корпораци (МИК)-ийн үнэт цаасыг Төв банкны репо санхүүжилтийн барьцааны жагсаалтанд оруулсан нь Монголбанкнаас МИК-ийн үйл ажиллагааг дэмжих зорилготой нийцэхээс гадна банкуудын хөрвөх чадвар сайтай активын төрөл нэмэгдэж, хөрөнгийн удирдлагад дэмжлэг болох юм.

Тайлант онд Монголбанк өссөн дүнгээр 453.8 тэрбум төгрөгийн репо санхүүжилтийг банкны хүсэлтээр олгосон байна. Нийт олгосон репо санхүүжилтийн жигнэсэн дундаж хүү 16.84 хувь байна.

Дамжуулан олгосон төслийн зээлүүд

Хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх хөтөлбөр /ХААСХХ/

Азийн хөгжлийн банкны ХААСХ (1822-МОН) төсөл 2001 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд уг төслийн зорилго нь илүү үр ашигтай, зах зээлд чиглэсэн, хөдөө аж ахуйн салбарын тогтвортой санхүүжилтийг хөгжүүлж, бүтээмж, ашигт ажиллагааг сайжруулснаар орлогын түвшинг нэмэгдүүлэн ядуурлыг бууруулах явдал юм. ХААСХ төсөл нь Завхан, Увс, Ховд, Говь-Алтай, Дархан-Уул, Сэлэнгэ, Баянхонгор, Баян-Өлгий аймгуудад Анод, ХААН, Зоос, Монгол шуудан, Хадгаламж, ХАС зэрэг банкаар дамжин амжилттай хэрэгжин дууссан бөгөөд тайлант онд банкуудад уг төслийн хүрээнд шинээр зээл олгоогүй.

Ажлын байр нэмэгдүүлэх төслийн зээл

Азийн хөгжлийн банкны “Ажлын байр нэмэгдүүлэх 1290-МОН төсөл” амжилттай хэрэгжиж дууссан бөгөөд Монголбанкны Ерөнхийлөгч, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2000 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 157 дугаар тушаалаар батлагдсан “Азийн хөгжлийн банкны Ажлын байр нэмэгдүүлэх төслийн хүрээнд эргэн төлөгдөх эх үүсвэрээс зээл олгох журам”-ын дагуу төслийн эх үүсвэрээс тайлант онд банкуудад зээл олгон ажиллав. Уг төслийн хүрээнд Голомт, Эрэл, Хас, Улаанбаатар банкуудад зээл олгов. Монголбанк ажлын байр нэмэгдүүлэх төслийн эргэлтийн сангийн эх үүсвэрээс 2009 онд нийт 921.4 сая төгрөгийн зээлийг төсөлд оролцогч банкуудад дамжуулан олгож, банкуудын зээлийн өрийн үлдэгдэл оны эцсийн байдлаар 1.2 тэрбум төгрөг байв.

Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх ХБНГУ-ын Сэргээн босголт, хөгжлийн банкны эх үүсвэрээр хэрэгжүүлж буй төслийн зээл

Монгол Улс, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу экспортын чиглэлийн жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, санхүүгийн секторыг дэмжих зорилго бүхий хоёр хөтөлбөр амжилттай хэрэгжиж байна. Монгол Улс 1 дүгээр хөтөлбөрийн хүрээнд анх 5.1 сая евро, 2 дугаар хөтөлбөрийн хүрээнд 3.6 сая евро, нийт 8.7 сая еврогийн зээлийг авсан. Тайлант онд тус хөтөлбөрт Капитрон, Монгол Шуудан, Худалдаа хөгжлийн банкууд оролцлоо.

Төслийн үндсэн эх үүсвэрийг бүрэн ашиглаж дууссан бөгөөд банкуудаас эргэн төлөгдсөн зээлийн эх үүсвэрээр төслийн зориулалтын дагуу дахин зээл олгож ирэв. 2009 онд төсөлд оролцогч банкуудад 650.0 мянган еврогийн зээлийг дамжуулан олгож, банкуудын төслийн зээлийн өрийн үлдэгдэл тайлант оны эцсийн байдлаар 4.3 сая еврод хүрсэн байна. Түүнчлэн, уг төслийн үйл ажиллагааг цаашид үргэлжлүүлэх талаар Монголбанкнаас Сангийн яаманд албан ёсоор хүсэлт тавьсан.

Засгийн газрын цэвэр зээл


Тайлант оны эцэст банкны салбарын нэгдсэн дүнгээр Засгийн газраас авах авлага 422.2 тэрбум төгрөг, төвлөрсөн болон орон нутгийн төсвийн хөрөнгө 1159.2 тэрбум төгрөг болж, Засгийн газрын цэвэр зээлийн хэмжээ -737.0 тэрбум төгрөгт хүрэв. Энэ дүнг 2008 оны мөн үетэй харьцуулбал төвлөрсөн болон орон нутгийн төсвийн хадгаламж 656.9 тэрбум төгрөгөөр, Засгийн газраас авах авлага 419.7 тэрбум төгрөгөөр тус тус өсчээ.

Засгийн газраас авах авлагын талаар

Засгийн газраас авах авлага Монголбанк болон банкуудын тэнцлийн нэгдсэн дүнгээр тайлант улирлын эцэст 422.2 тэрбум төгрөг болсон нь өмнөх улирлаас бараг 2 дахин их байна. Тайлант улиралд Сангийн яамнаас Монгол улсын их хурлын 77 дугаар тогтоолоор батлагдсан 250 тэрбум төгрөг хүртэлх үнэт цаас гаргах эрхийн хүрээнд Засгийн газрын үнэт цаасыг Төв банкинд худалдах саналаа ирүүлсний дагуу Монголбанк нэг жилийн хугацаатай 170.0 тэрбум төгрөгийн ЗГҮЦ-ыг 2009 оны 12

Зураг 10

Банкны салбар дахь засгийн газрын цэвэр зээл (тэрбум төгрөгөөр)



дугаар сарын 31-ний өдөр худалдан авсан байна. Мөн 2009 оны 2 дугаар сарын 19-ний өдөр улсын төсвийн улирлын чанартай орлогын дутагдлыг нөхөх зориулалтаар Төвбанк Сангийн яамтай байгуулсан гэрээг үндэслэн жилийн 3 хувийн хүүтэй, 9 сарын хугацаатай 60.0 тэрбум төгрөгийн ЗГҮЦ-ыг худалдан авсан болно. Улсын төсвийн орлогын биелэлттэй холбоотойгоор Сангийн яам тус үнэт цаасны үндсэн болон хүүний төлбөрийг хугацаанаас нь өмнө төлөх санал гаргасны дагуу 2009 оны 9 дүгээр 19-ний өдөр гэрээг дуусгавар болгож төлбөрийг шилжүүлсэн байна.

Засгийн газраас авах банкуудын авлагын 17.3 хувь нь банкуудаас улсын төсөвт урьдчилж төлсөн ба хойшлогдсон татвар эзэлж байгаа бол үлдсэн 82.7 хувийг Засгийн газрын богино хугацаатай үнэт цаас эзэлж байна. Тус богино хугацаат үнэт цаас нь 100 хувь Голомт банкинд байршиж байна.


Засгийн газрын нэгдсэн төсвийн талаар

Банкны систем дэх улсын төсвийн хөрөнгө болон харилцах, хадгаламж тайлант улирлын эцэст 1159.2 тэрбум төгрөг болсон нь өмнөх улирлаас 24.2 хувиар өссөн байна. Нийт үлдэгдлийн 60.2 хувь нь Монголбанкинд, 39.8 хувь нь банкуудад байршиж байна. Нийт төсвийн хөрөнгийн 76.1 хувь нь Төрийн сангийн нэгдсэн данс болон Засгийн газрын харилцах дансны хөрөнгө, 9.3 хувь нь хугацаагүй болон хугацаатай хадгаламж, 14 хувь нь Засгийн газрын санхүүжилтийн хөрөнгө, 0.7 хувь нь орон нутгийн төсвийн хөрөнгө тус тус байна. Монгол Улсыг хөгжүүлэх сангийн дансны үлдэгдэл оны сүүлд 31.4 тэрбум төгрөг байгаа бөгөөд энэ нь Засгийн газрын харилцах дансны нийт үлдэгдлийн 5.2 хувийг эзэлж байна. Тус дансны нийт үлдэгдэлийн 77.0 хувь нь төгрөгийн, 23.0 хувь нь валютын дансны үлдэгдэл байна.

1.2. Мөнгөний үзүүлэлтүүдийн байдал

Эдийн засаг дахь мөнгөний нийлүүлэлтийн хэмжээ 2009 онд 26.9 хувиар буюу 610 тэрбум төгрөгөөр өсч 2.8 их наяд төгрөгт хүрлээ. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт нь голчлон Бараг мөнгөний өсөлтөөс шалтгаалжээ. Харин M1 мөнгөний хэмжээ өнгөрсөн оны мөн үеийн үзүүлэлттэй бараг ижил түвшинд байлаа. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт өмнөх оны -4.8 хувийн бууралттай харьцуулахад 32.3 нэгж хувиар өндөр гарлаа. Монголбанкнаас эдийн засаг болон санхүүгийн захыг тогтворжуулах бодлогын арга хэмжээний үр дүнд иргэдийн банкинд итгэх итгэл сэргэснээр Монголбанк бодлогын хүүгээ бууруулж мөнгөний хумих бодлогоос тэлэх бодлого руу аажмаар шилжсэн нь 2009 оны 3 дугаар улиралд мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэв.

Зураг 11
M2 мөнгөний
бүтэц



Мөнгөний нийлүүлэлтийг бүтцээр нь авч үзвэл, Бараг мөнгө 77.4 хувь (үүнд төгрөгийн хадгаламж 42.9 хувь, гадаад валютын хадгаламж 21.6 хувь, гадаад валютын харилцах 12.9 хувь), M1 мөнгө 22.6 хувийг тус тус эзэлж байна. Мөнгөний нийлүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн өөрчлөлтийн хандлагыг авч үзвэл M1 мөнгөний жилийн өсөлтийн хурдац тайлант оны эхний хагаст буурч байсан бол хоёрдугаар хагасаас эргээд өссөн ч, оны эцэст 0.6 хувьд хүрч буурав. M1 мөнгөний жилийн өсөлт 2009 оны эхний хагаст их хэмжээгээр буурсан нь 2008 оны 4 дүгээр улирлаас банкны системийн харилцах буурч, банкнаас гадуурх мөнгө өсч байсанаас шалтгаалав.

Харин 2009 оны эхний улиралд Бараг мөнгө M1 мөнгөтэй ижил хувиар буурч байсан бол 2 дугаар улирлаас эхлэн өсч, оны эцэст 37.4 хувьд хүрээд байна. Энэхүү өсөлтийн 55.2 хувийг төгрөгийн хадгаламж, 44.8 хувийг валютын харилцах, хадгаламжийн өсөлт эзэлж байна. Монголбанкнаас хэрэгжүүлсэн инфляцийг бууруулах, төгрөгийн ханшийн сулралтыг тогтворжуулах бодлогын болон харилцах, хадгаламжид баталгаа гарах тухай хуулийг УИХ-аас баталсаны үр дүнд иргэдийн банкинд итгэх итгэл сэргэж Бараг мөнгийг их хэмжээгээр өсгөлөө.

Хүснэгт 2. Мөнгөний үзүүлэлт

(жилийн эцсийн байдлаар, тэрбум төг, сүүлийн 12 сарын өөрчлөлт, %)

	М2 мөнгөнд эзлэх хувь	2005	2006	2007	2008	2009
<i>Нийт мөнгө-М2</i>		1140.1	1536.4	2401.2	2270.0	2880.03
		34.6%	34.8%	56.3%	-2.5%	26.9%
<i>Бага мөнгө -М1</i>		269.1	331.9	590.4	647.3	651.2
	28.2%	21.6%	23.3%	77.9%	9.6%	0.6%
Банкнаас гадуурх мөнгө		152.3	185.1	283.3	328.7	284.9
	14%	6.2%	21.5%	53.0%	16%	-13.3%
Төгрөгийн харилцах		116.5	146.7	307.1	331.8	366.2
	14.2%	50.0%	25.7%	109.3%	8.1%	15%
Бараг мөнгө		871.0	1204.5	1810.7	1621.8	2228.7
	71.8%	39.2%	38.3%	50.3%	-10.4%	37.4%
<i>Нийт хадгаламж</i>		671.7	995.4	1489.7	1338.8	1856.4
	59.6%	29.8%	48.2%	49.7%	-10.1%	38.7%
Төгрөгийн хадгаламж		426	692.4	1113.7	898	1234.2
	40.3%	41.6%	62.5%	60.8%	-19.3%	37.3%
Валютын хадгаламж		245.6	302.9	375.9	440.1	622.3
	19.3%	13.5%	23.3%	24.1%	17.1%	41.3%
<i>Валютын харилцах</i>		199.3	209.1	321	283.7	372.3
	12.1%	84%	5.0%	53.5%	-11.6%	31.2%

Эх үүсвэр: Монголбанк, сарын статистикийн мэдээлэл


М1 мөнгө

Тайлант оны эцэст М1 мөнгө өмнөх оны мөн үеэс 0.6 хувь буюу 3.9 тэрбум төгрөгөөр өсч 651.2 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт мөнгөний 22.6 хувь байна. Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө өмнөх оны мөн үеэс 35.4 тэрбум төгрөг буюу 8.7 хувиар буурч 371.8 тэрбум төгрөгт хүрсэн дүн гарлаа. Банкнаас гадуурх мөнгө гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний 76.6 хувийг эзэлж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 4.1 нэгж хувиар бага юм. Мөн банкнаас гадуурх мөнгө М2-ийн харьцаа 9.9 хувь болж, өмнөх оны мөн үеэс 4.6 нэгжээр хувиар буурчээ.

Бага мөнгө тайлант онд өнгөрсөн оны мөн үеэс бараг өөрчлөгдөөгүй боловч түүний бүтцийг харвал төгрөгийн харилцах 47.6 тэрбум төгрөг буюу 15.0 хувиар өссөн бол банкнаас гадуурх мөнгө 43.7 тэрбум төгрөг буюу 13.3 хувиар буурчээ.

Зураг 12

M2 мөнгө,
түүний бүтэц
(M2 мөнгөнд
эзлэх хувь)



Эх үүсвэр: Монголбанк

Зураг 13


Мөнгөний
нийлүүлэлтийн
өөрчлөлт, өмнөх
оны мөн үе=100%



Эх үүсвэр: Монголбанк

Зураг 14

ГЦА, ДЦА,
M2-ийн жилийн
өсөлт, хувиар



Эх үүсвэр: Монголбанк

Гадаад болон дотоод цэвэр актив

Мөнгөний нийлүүлэлтийг актив талаас нь харвал, 2009 оны эхний хагаст 2008 оны адил дотоод цэвэр активын өсөлт гадаад цэвэр активын өсөлтөөс давсан байна. Гэхдээ энэхүү дүр зураг нь тайлант оны сүүлийн хагас жилд эсрэгээр өөрчлөгдөв. Дэлхийн эдийн засгийн хямралаас шалтгаалж хөрөнгийн гадагшлах урсгал явагдсанаас 2008 онд гадаад цэвэр актив буурч байсан бол 2009 онд дэлхийн зах дээрх зэсийн үнийн өсөлт болон Оюу толгойн гэрээ байгуулагдсан зэрэг нь хөрөнгийн дотогшлох урсгалыг бий болгож тайлант онд өмнөх оны мөн үетэй харьцуулахад ГЦА 2.2 дахин буюу 849.8 тэрбум төгрөгөөр өсч 1.5 их наяд төгрөг болжээ.

Бараг мөнгө

2008 онд Бараг мөнгө буурч байсан бол 2009 онд 606.1 тэрбум төгрөг буюу 37.4 хувиар өсч 2.2 их наяд төгрөгт хүрсэн нь нийт мөнгөний 77.4 хувийг эзэлж байна. Бараг мөнгөний бүтцээс харахад төгрөгийн хадгаламж оны эхнээс 37.3 хувь буюу 335.6 тэрбум төгрөгөөр, гадаад валютын харилцах хадгаламж 41.3 хувь буюу 181.9 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Тайлант онд төгрөгийн хадгаламжийн нийт хадгаламжид эзлэх хувь тайлант онд 66.5 хувь болж өмнөх оны мөн үеэс 0.6 нэгжээр буурчээ. Дэлхийн эдийн засгийн хямрлын манай эдийн засагт үзүүлэх нөлөө 2008 оны хоёрдугаар хагаст идэвхжиж төгрөгийн гадаад валюттай харьцах ханш огцом суларснаар төгрөгийн хадгаламж буурч, гадаад валютын хадгаламж өсч эхэлсэн. Харин 2009 онд эдийн засагт ажиглагдсан нааштай өөрчлөлтийн үр дүнд тайлант оны сүүлийн хагаст төгрөгийн хадгаламжийн өсөлт валютын хадгаламжийн өсөлтөөс илүү гарав.

Мөнгөний үржүүлэгч ба мөнгөний эргэлтийн хурд


Мөнгөний эргэлтийн хурд гэдэг нь эдийн засагт нийлүүлэгдэж буй мөнгө жилд хэдэн удаа эргэлтэнд орж байгааг илэрхийлдэг үзүүлэлт юм. Тайлант оны эцсийн байдлаар мөнгөний эргэлтийн хурд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.5 нэгжээр буурч 2.1 боллоо. Мөнгөний эргэлтийн хурд ингэж буурах болсон шалтгаан нь мөнгөний нийлүүлэлтийн өсөлт нэрлэсэн ДНБ-ий өсөлтөөс их байсантай холбоотой.

Тайлант онд мөнгөний үржүүлэгч дунджаар 3.9 гарсан бөгөөд энэ нь өмнөх оны дундажтай харьцуулбал 1 нэгжээр буурсан байна.

Энэ нь нөөц мөнгө 3.9 дахин үржигдэж эдийн засагт нийлүүлэгдэж байгааг илэрхийлж байгаа юм. Мөнгөний үржүүлэгчийн бууралт болон банкуудын нөөц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн харьцааны өсөлт нь банкны салбарын зээлийн тасалдалтай холбоотой байлаа.

Зураг 15

Бараг мөнгө,
түүний бүтэц
(жилийн
өөрчлөлт)



Эх үүсвэр: Монголбанк

Зураг 16

Төгрөг, валютын
хадгаламж
(сарын өөрчлөлт)




Эх үүсвэр: Монголбанк



Зураг 17

Мөнгөний
эргэлтийн хурд
болон мөнгөний
үржүүлэгч



Зураг 18

Мөнгөний
үржүүлэгчид
нөлөөлөх хүчин
зүйл (жилийн
өөрчлөлт)

Эх үүсвэр: Монголбанк

ШИГТГЭЭ 1. Мөнгө санхүүгийн статистикийн хөгжил

Монголбанк Олон улсын валютын сан (ОУВС)-гаас эрхлэн гаргасан Мөнгө ба санхүүгийн статистикийн гарын авлага⁴ын заалтыг үндэслэн мөнгөний статистикийг нэгтгэн боловсруулж, олон нийтэд тархаадаг билээ. Энэ аргачлалаар бэлтгэсэн статистик үзүүлэлтүүд нь мөнгөний бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, бодлогын үр нөлөөг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтойгоос гадна санхүүгийн салбарын байдлыг үнэлэн дүгнэхэд шаардлагатай статистик үндэслэл болдог.

Мөнгө санхүүгийн статистикийг сайжруулах зорилгоор Мөнгөний бодлого, судалгааны газар статистик мэдээллийг баяжуулах, чанарыг нь сайжруулах, үнэн зөв мэдээллийг цаг хугацаанд нь олон нийтэд тархах, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Статистикийн мэдээллийг баяжуулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Бодлого боловсруулах, судалгаа шинжилгээ хийхэд шаардлагатай статистик үзүүлэлтийн санг бүрдүүлэх зорилгоор сарын статистикийн бюллетенд хүснэгт, үзүүлэлтийг нэмж оруулах, зарим үзүүлэлтийг задаргаагаар харуулах, Олон улсын санхүүгийн статистикийн эмхэтгэлд нийтлүүлдэг мэдээллийг илүү дэлгэрэнгүй болгох, санхүүгийн хэрэгслийн ангиллыг боловсронгуй болгох, бусад орны туршлагыг судалж нэвтрүүлэх зэрэг ажлыг гүйцэтгэж байна.

Сүүлийн гурван жилийн хугацаанд Сарын статистикийн бюллетенд Засгийн газрын үнэт цаасны хүү, банк хоорондын захын хүү, зээлийн бодитоор төлөгдсөн хүү, харилцах, хадгаламжийн жигнэсэн дундаж хүү, хэрэглээний үнийн улсын индекс⁵, үндсэн зарим үзүүлэлтийн жилийн өөрчлөлтийг тооцсон хүснэгтийг нэмж оруулсан билээ. Төв банкны үнэт цаасны хүүг үнэт цаасны төрөл тус бүрээр, банк хоорондын захын хүүг арилжаа тус бүрээр, Монголын хөрөнгийн бирж дэх нийт үнэт цаасны гүйлгээний дүнг Засгийн газрын бонд, компанийн бонд болон хувьцааны гүйлгээгээр задалж мэдээллийн хамрах хүрээг өргөтгөсөн.

Статистик мэдээллийн хамрах хүрээг өргөтгөж, шаардлагатай үзүүлэлтийг нэмэхдээ тухайн үеийн үзүүлэлтээс гадна өмнөх хугацааны боломжит мэдээллийг хамруулах зарчмыг баримтлан ажилладаг. Тухайлбал, ТБҮЦ-ны хүүний үзүүлэлтийг үнэт цаасны төрөл тус бүрээр задалж, 2009 оны 5 дугаар сарын статистикийн бюллетенд нэмсэн боловч тус үзүүлэлтийг 2000 оны 10 дугаар сараас эхлэн нөхөж оруулсан.

⁴ IMF, 2000. *Monetary and Financial Statistics Manual*

⁵ Үндэсний статистикийн хорооноос сар тутам гаргадаг Статистикийн бюллетенд нийтэлдэг хэрэглээний үнийн индексээр тооцсон инфляцийн үзүүлэлтийг Монголбанк авч хэрэглэдэг бөгөөд эх сурвалжийг нь заадаг болно.

Статистик үзүүлэлтийн чанарыг нь сайжруулах арга хэмжээ

ОУВС-гаас 2007 онд манай улсын макро эдийн засгийн статистик үзүүлэлтэд үнэлгээ өгсөн болно⁶. Энэ ажлын хүрээнд ОУВС-гийн төлөөлөгчид манай орны статистик үзүүлэлтийг үнэлэхдээ олон улсын тэргүүн туршлагатай харьцуулж, статистикийн чанарыг хангах угтвар нөхцөл, мэдээллийн нэгдмэл байдал, аргачлалын хэрэгжилт, чанар, хэрэглэх боломж, нээлттэй байдал зэрэг шалгуур үзүүлэлт тус бүрээр үнэлгээ өгсөн. Мөнгөний статистикт өгсөн үнэлгээний 91 хувь нь “Олон улсын туршлагад нийцсэн” болон “Олон улсын туршлагад нийцсэн, их хэмжээний зөрүүгүй” гэсэн үнэлгээ байна.

Статистикийн чанарын асуудлыг шийдвэрлэхдээ тухайн мэдээллийн үнэн зөв байдалд хяналт тавихаас гадна бусад төрлийн статистиктай харьцуулан шинжилдэг билээ. Тухайлбал мөнгөний статистик (Засгийн газрын цэвэр зээл) болон Засгийн газрын санхүүгийн статистик (улсын нэгдсэн төсвийн банкны салбараас авсан дотоодын санхүүжилт) хоорондын зөрүүг тооцох, шалтгааныг нь тодруулах, арилгах асуудлаар Сангийн яамтай хамтран ажиллаж байна.

Мөнгө санхүүгийн статистикийн чанарыг сайжруулах нь зөвхөн эдгээр үзүүлэлтийг үнэн зөв нэгтгэхтэй холбоотой бус юм. Чанарыг сайжруулах асуудлын хүрээнд мөн статистикийг нэгтгэх аргачлалыг боловсронгуй болгох, олон улсын стандартыг нэвтрүүлэх, хамрах хүрээг өргөтгөх ажил багтана. Олон улсын аргачлалын дагуу статистик үзүүлэлтийг санхүүгийн хэрэгслээр ангилахаас гадна сектороор ангилдаг тул санхүүгийн хэрэгслийн секторын ангилалд хяналт тавьж ажилладаг. Мөн мөнгө болон санхүүгийн статистикийн гарын авлага дахь нөөц мөнгөний тодорхойлолтыг үндэслэн түүний тооцоог нарийвчлах, мөнгөний нийлүүлэлт, гадаад цэвэр актив, Засгийн газраас авах цэвэр авлага зэрэг мөнгөний тоймын үзүүлэлтийн тооцоог боловсронгуй болгох зэрэг арга хэмжээ авснаар олон улсын стандарт аргачлалын хэрэгжилтийг сайжруулж байна.

Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын олон улсын ангилал өөрчлөгдсөн, санхүүгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтэрч байгаагай холбоотойгоор статистик мэдээллийн бүрдлийг шинэчлэх шаардлагатай болсон тул 2008 онд зээлийн тайлангийн маягыг шинэчлэн мөрдөж байна. 2007 онд баталсан Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн заалтыг баримтлан ЖДҮ-ийг тодорхойлж, тэдгээрт олгосон зээлийн үзүүлэлтийг Иргэд, жижиг дунд үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгжид олгосон зээлийн тайланд нэгтгэж эхэлснээр зээлийн мэдээллийн санг баяжуулсан. Банкуудын зээлийн тайлангийн чанарыг сайжруулах, мэдээллийн үнэн зөв байдлыг хангах зорилгоор зээлийн тайлангийн маягыг нөхөх зааврыг шинээр боловсруулан мөрдөж байна.

Эдийн засаг, санхүүгийн зах зээл хөгжин санхүүгийн шинэ хэрэгсэл, бүтээгдэхүүн байнга нэмэгдэж байна. Банкуудын зээлийн тайланд иргэдэд олгосон зээлийг цалин, тэтгэвэр, хэрэглээний зээл гэх зэрэг задаргаагаар нэмж

⁶ Report on the Observance of Standards and Codes

орууллаа. Мөнгөний нийлүүлэлтэд цэвэршүүлсэн алтны харилцах, хадгаламж, хадгаламжийн сертификатыг нэмж тооцдог болсон.

Үнэн зөв мэдээллийг цаг хугацаанд нь олон нийтэд тархаах

Монгол улс 2000 онд ОУВС-ийн Мэдээлэл тархаах ерөнхий системд⁷ нэгдэн орсон билээ. Тус систем нь статистикийн чанарыг сайжруулах, нийгэм, эдийн засаг, санхүүгийн мэдээллийг цаг хугацаанд нь олон нийтэд түгээх, цаашид авах арга хэмжээг тодорхойлж статистикийг боловсронгуй болгох, олон улсын аргачлалыг нэвтрүүлэхэд чиглэгджээ. Мэдээлэл тархаах ерөнхий системийн хүрээнд Монголбанк банк санхүүгийн салбартай холбоотой мэдээллийг хариуцан гаргадаг. Тухайлбал мөнгө, зээлийн үзүүлэлт, мөнгөний тойм, төв банкны үзүүлэлт, хөрөнгийн зах зээлийн зарим үзүүлэлт, хүү, төлбөрийн тэнцэл, гадаад нөөц, гадаад валютын ханш зэрэг үзүүлэлтийг тооцдог аргачлал, олон нийтэд түгээдэг хугацаа, давтамж, хэлбэр, статистикийг боловсронгуй болгох ажлын төлөвлөгөө зэрэг мэдээллийг бэлтгэж ОУВС-д хүргүүлдэг⁸.

Мэдээлэл тархаах ерөнхий системд мөнгөний үзүүлэлтүүдийг 1-3 сарын хугацаанд боловсруулах стандарт байдаг, харин Монголбанк мөнгөний үзүүлэлтүүдийг тайлант хугацааны дараа сарын 21-ний өдрийн дотор гаргадаг билээ. Олон улсын туршлагыг үндэслэн статистик мэдээлэл, тойм гаргах хугацааг 2008 оноос эхлэн Монголбанкны цахим хуудсанд байршуулан олон нийтэд мэдээлдэг болсон. Тус хуанлиг улирал бүр шинэчлэн гаргаж байна.

Мөнгө, мөнгөний тойм, зээлийн үзүүлэлтийг 2007 оноос өмнө ҮСХ-ны Статистикийн бюллетенд нэг сарын хоцрогдолтой нийтэлж байсан бол одоо тухайн сард нь урьдчилсан байдлаар харуулдаг болсон. Богино хугацаанд мэдээлэл боловсруулахад тус мэдээллийн чанарт сөрөг нөлөө үзүүлэх нь гарцаагүй юм. Олон улсын туршлагаас харахад аливаа мэдээллийг урьдчилсан байдлаар нийтлүүлж, шалгаж нягталсны дараа эцсийн байдлаар боловсруулан дараагийн тайлант үед нь өмнөх мэдээллийг шинэчлэн харуулдаг байна. Энэ зарчмын дагуу мөнгө, зээлийн үзүүлэлтийг ҮСХ-ны Статистикийн бюллетенд гаргаж байна.

Мэдээллийн ил тод байдлыг сайжруулах

Мөнгөний тоймын үзүүлэлтийг нэгтгэх арга, эх сурвалжид өөрчлөлт оруулах бүрт урьдчилан мэдээлэл бэлтгэж, Монголбанкны цахим хуудсанд байршуулж байгаа нь мэдээллийн ил тод байдлыг сайжруулах том алхам боллоо. Тухайлбал, Монголбанк болон Сангийн яамны хамтарсан ажлын хэсгийн шалгалтаар банкууд дахь Засгийн газрын дансдын үлдэгдлийг шалгаж, зарим дансдын ангиллыг өөрчлөн Мөнгөний тоймд өөрчлөлт оруулсан тухай, цэвэршүүлсэн алтны харилцах, хадгаламжийг мөнгөний нийлүүлэлтэд оруулж тооцох болсон тухай зэрэг мэдээллийг Монголбанкны цахим хуудаст байршуулан олон нийтэд танилцуулсан болно.

⁷ General Data Dissemination System - GDDS

⁸ <http://dsbb.imf.org> цахим хаягаар дэлгэрэнгүй мэдээлэл авна уу.

Мөнгөний бодлого, судалгааны газраас нэгтгэн гаргадаг бүх мэдээлэл, тодруулбал банкуудын нэгдсэн тайлан тэнцэл, сарын статистикийн бюллетень, улирлын зээлийн нэгдсэн тайлан, орон нутагт үйл ажиллагаа явуулдаг банкуудын мэдээ, мөнгөний тоймыг хуанлийн дагуу Монголбанкны цахим хуудсанд байршуулан олон нийтэд танилцуулж байна. Мэдээлэл гаргах хугацааг Монголбанкны цахим хуудсанд урьдчилан байршуулдаг бөгөөд улирал бүр шинэчлэн гаргадаг.

ОУВС-гаас сар бүр гаргадаг Олон улсын санхүүгийн статистикийн (ОУСС) эмхэтгэлд ханш, төлбөрийн тэнцэл, хүү, мөнгө санхүү, үйлдвэрлэл, гадаад худалдаа, төсөв, үндэсний тооцоо болон хүн амын динамик үзүүлэлтийг харуулдаг тул олон улсын болон тодорхой улс орнуудын санхүүгийн статистикийн эх сурвалж болдог байна. Мөнгөний бодлого, судалгааны газар 2009 оны 10 дугаар сард ОУВС-гийн мөнгөний статистикийн тайлангийн стандарт маягтыг бүрэн гүйцэд нэвтрүүлж, ОУСС эмхэтгэлийн 11 дүгээр сарын дугаарт нийтлүүлсэн болно. Стандарт маягтыг нэвтрүүлэхдээ өмнөх хугацааны, тодруулбал 2005 оны 12 дугаар сараас эхэлсэн мэдээллийг шалгаж, ангиллыг нь сайжруулан шинэчилж оруулсан. Мөнгөний статистикийн тайлангийн стандарт маягтыг нэвтрүүлэх нь Мөнгө, санхүүгийн статистикийн гарын авлага дахь олон улсын аргачлалыг хэрэгжүүлэх, манай мөнгө санхүүгийн статистикийг бусад орны зохих үзүүлэлттэй харьцуулах боломжтой болгох, бодлого боловсруулах болон дүн шинжилгээ хийхэд шаардлагатай мэдээллийг сайжруулахад чухал ач холбогдолтой юм.

Олон улсын аргачлалын хэрэгжилтийг цаашид боловсронгуй болгох талаар

Эдийн засаг, мөнгө санхүүгийн зах зээл хөгжихийн хэрээр статистикийн хамрах хүрээ өргөжиж, ач холбогдол нь өсч байна. Чанартай статистикийг хугацаа алдалгүй гаргах нь бодлого боловсруулалт, хэрэгжилтийн үр нөлөөг нэмэгдүүлнэ. Мөнгөний статистикийг сайжруулах ажлын хүрээнд эхний ээлжинд хадгаламж, зээлийн хоршоодын тайлангийн үзүүлэлтийг банкуудын зохих үзүүлэлттэй нэгтгэж хадгаламжийн байгууллагын тоймыг гаргана. Мөнгөний нийлүүлэлтийн тооцоонд ордог харилцах, хадгаламж хэлбэрээр бусдаас хөрөнгө татан төвлөрүүлдэг санхүүгийн бүх байгууллагын үзүүлэлтийг нэгтгэснээр мөнгөний нийлүүлэлтийн тооцоог сайжруулах юм. Дараагийн шатанд санхүүгийн бусад байгууллага (банк бус санхүүгийн байгууллага)-ын үзүүлэлтүүдийг нэгтгэж санхүүгийн байгууллагын тоймыг бэлтгэхээр төлөвлөөд байна.

Мөнгөний статистикийг нэгтгэх, хамрах хүрээг тэлэх явцад олон төрлийн байгууллага тэдний шууд бүтээгдэхүүн бус мэдээллийг нэгтгэн гаргах шаардлагатай тулгарснаар анхан шатны мэдээллийн хяналт сул байх, гар ажиллагаа их, хугацаа алдах, техник алдаа гарах магадлал өндөр юм. Цаашид энэ ажиллагааг мэдээллийн технологийн шийдэлд тулгуурлан хөгжүүлэх нь энэ хүндрэлийг даван туулах хамгийн зохимжтой арга болоод байна. Ийм шийдэлд хүрч чадвал богино хугацаанд мэдээллийн өгөгдлийг шинжлэх бололцоо мөн адил өргөсөх билээ. Мэдээллийн чанарыг сайжруулах угтвар нөхцөлийг хангах ажлын хүрээнд банкуудаас мэдээлэл хүлээн авах, нэгтгэх программ хангамж бий болгох ажлыг эхлээд байна.

1.3. Валютын ханшийн бодлого

Дэлхийн санхүү, эдийн засгийн хямрал 2008 оны сүүлийн хагасаас эхлэн Монгол улсын эдийн засаг, бизнесийн орчинд хүчтэй нөлөөлөн, төлбөрийн тэнцэл, улсын төсөв аль аль нь алдагдалтай болж ДНБ-ий 13.1, 4.8 хувьд тус тус хүрч, банкны салбараас мөнгөн хөрөнгө их хэмжээгээр гадагшлан, гадаад валютын орох урсгал үндсэндээ зогссоноор гадаад валютын дотоодын зах тогтворгүйжсэн билээ. Энэ нөхцөлд ханшийг тогтворжуулах зорилгоор Монголбанкнаас интервенц хийхдээ гадаад валютын улсын нөөцийг олон улсад хүлээн зөвшөөрөх доод хэмжээнээс бууруулахгүй байх зарчмыг баримталсан. Олон нийтийн сэтгэл зүй, ханшийн талаарх хүлээлт өөрчлөгдсөнөөс шалтгаалан зохиомол хэт эрэлт үүссэн, ОУВС, Засгийн газар хоорондын зээл, тусламжийн хэмжээ, хуваарь тодорхойгүй байсан зэргээс төгрөгийн ханшийг цаашид хамгаалах боломжгүй болж, улмаар ханшийн тохиргоо хийхээс өөр сонголтгүй болсон юм. Нөгөө талаар гадаад валютын үлэмж хэмжээний хомсдолтой, банкны салбарын зээлийн гуравны нэг нь гадаад валютаар олгогдсон үед төгрөгийн ханшийг хэт, огцом сулруулах нь чухал хэрэгцээтэй импортын бүтээгдэхүүний нийлүүлэлт тасалдаж, инфляцийг хөөрөгдөх, эдийн засаг зогсонги байдалд орох, улмаар валютын хямрал, банкны салбарын тогтворгүй байдлыг ч өдөөж болзошгүй нөхцөл бүрэлдсэн байв.

Эдийн засагт олон жилийн турш байсан “Зохиомол эрэлт”-ийн улмаас төгрөгийн ханш бодитой тогтох боломжгүй болж, зах зээл дэх богино хугацааны гажуудлыг хурдацтай арилгах, ОУВС-тай хөтөлбөр тохирох, хөтөлбөрийг 2009 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжүүлж эхлэх хүртэл хугацаанд банк хоорондын зах дээр үүссэн гадаад валютын хомсдолыг Монголбанкнаас тодорхой хэмжээгээр тэнцвэржүүлэх, ингэхдээ улсын хэмжээний ач холбогдол бүхий гадаад төлбөр тооцоог хугацаа хожимдуулахгүй хийх, стратегийн чухал барааны импортын тасалдлыг бий болгохгүй байх үүднээс “валютын зохистой хуваарилалт” (import rationing)-ын зарчимд шилжсэн.

Дээрх бодлогын хүрээнд банкуудын захиалгыг үндэслэн Монголбанк арилжаа хийхдээ Монголбанкнаас худалдан авсан ханшийг таван төгрөгөөс илүү өсгөхгүйгээр, зөвхөн зориулалтын дагуу ашиглах хатуу нөхцөлтэй хэлцэл байгуулснаар банкуудад 2009 оны нэгдүгээр улиралд 107.1 сая ам.долларыг худалдсанаас 45.2 сая ам.доллар буюу 42.2 хувийг зөвхөн нефтийн бүтээгдэхүүний импортод зориулагдсан байна. Ингэснээр Монгол улсыг нефтийн бүтээгдэхүүнээр таслаагүйгээс гадна үүнээс шалтгаалж эрчим хүчний нийлүүлэлт зогсоогүй, нэн яаралтай эм, хүнсний импортын барааны хомсдолд оруулаагүй болно.

ОУВС-тай “Стэнд-бай” хөтөлбөр тохирон, хандивлагч улс орнуудаас өгөх зээл, тусламжийн хэмжээ, хуваарийг тодорхой болгож, төгрөгийн ханшид нэмэлт дарамт учруулж байсан төгрөгийн илүүдэл эх үүсвэрийг мөнгөний бодлогыг урьдчилан хатууруулах замаар буцаан татах, зохиомол эрэлтийг бууруулах арга хэмжээг Монголбанкнаас үе шаттайгаар хэрэгжүүлсний зэрэгцээ Монголбанкны гадаад валютын арилжааг 3 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн зөвхөн дуудлага худалдаагаар хийхээр шийдвэрлэснээр төгрөгийн ханш чөлөөтэй тогтож байх зарчим үндсэндээ хангагдсан юм.

Төгрөгийн ханш бодитой тогтож байх зарчмыг хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлж байсан дараах хүчин зүйлсийн эсрэг Монголбанкнаас зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэн тодорхой үр дүнд хүрсэн.

Хүснэгт 3. Монголбанкнаас гадаад валютын зохиомол эрэлтийг бууруулах зорилгоор хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн

Гадаад валютын “Зохиомол эрэлт”-ийг бий болгосон хүчин зүйлс	Монголбанкнаас хэрэгжүүлсэн арга хэмжээ	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн
<p>Аж ахуйн нэгж байгууллага, иргэд нь үнийн санал, тариф, зар сурталчилгааг гадаад валютаар илэрхийлж, төлбөр тооцоог гүйцэтгэж байна.</p>	<p>“Валютын зохицуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”, “Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль”-ийн төслүүдийг боловсруулан УИХ-аар хэлэлцүүлж, 2009 оны 7 дугаар сарын 9-ний өдөр батлуулав.</p>	<p>Гадаад валютын зохиомол эрэлтийг хязгаарлах, Эрдэнэт зэрэг УҮГ-ууд төсөвтэй хийх аливаа тооцоог зөвхөн төгрөгөөр гүйцэтгэх, татвар, гаалийн хураамж, шимтгэл зэргийг Монгол Улсын хуулинд зөвхөн төгрөгөөр илэрхийлж байх зэрэг эрх зүйн орчинг бүрдүүлэв. Мөн эдгээр хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг чангатгав. Ингэснээр гадаад валютын дотоодын зах дээрх эрэлт, нийлүүлэлт тэнцвэржих, төгрөгийн ханш нь Монгол Улсын эдийн засаг, гадаад худалдааны тэнцэлтэй уялдан байдлаар бодитой тогтох боломжтой болсон.</p>
<p>Эрдэнэт зэрэг УҮГ-ууд төсөвтэй хийх тооцоог ам.доллараар гүйцэтгэдэг.</p>	<p>Олон нийтээс өгсөн мэдээллийн дагуу 207 аж ахуйн нэгж, байгууллагын хууль тогтоомжийн хэрэгжилтэд газар дээрх шалгалтуудыг зохион байгуулж, зөрчил дутагдлыг арилгуулах чиглэлээр ажилласан.</p>	<p>Санхүүгийн зохицуулах хороо нь барилгын салбарын 12 компанийн орон сууцны захиалгын 97 гэрээний 2.1 сая, боловсролын салбарын 20 сургууль, цэцэрлэгийн сургалтын төлбөрийн үлдэгдэл 1.2 сая, нийт 3.3 сая ам.долларыг үндэсний мөнгөн тэмдэгтэд шилжүүлсэн нь эдийн засаг дахь долларжих үзэгдлийг саармагжуулан гадаад валютын дотоодын зах дээр ам.долларын зохиомол эрэлт буурахад эергээр нөлөөлжээ.</p>
<p>ГЕГ-ын эмхэтгэдэг “Гадаад худалдааны тайлан” алдаатай гарсны улмаас 2008 оны эхний хагас жилийн гадаад худалдааны тэнцлийн алдагдал огцом өссөн мэтээр олон нийтэд мэдээлсэн нь зах зээлийн хүлээлтийг өөрчилсөн.</p>	<p>Монголбанкны дуудлага худалдаа бүрийн үр дүнгийн мэдээллийг цахим хуудсаар дамжуулан тухай бүр олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлдэг болсон.</p>	<p>Үнийн сурталчилгаа, цалин хөлс, орон сууц, барилгын талбайн түрээсийн үнийг ам.доллараар илэрхийлж, түүгээр төлбөр гүйцэтгэхийг шаардаж байгааг таслан зогсоох, Монгол Улсын хууль тогтоомжид шимтгэл, хураамжийг ам.доллараар илэрхийлснийг хуульд нийцүүлэн өөрчлөх зэрэг шаардлагыг төрийн холбогдох байгууллагуудад албан тоогоор хүргүүлсэн.</p>
<p>Татвар, гаалийн хураамж, шимтгэл ам.доллараар илэрхийлэгдэж төлөгддөг.</p>	<p>ОУВС-ийн зөвлөхийг ажиллуулан бие даасан, мэргэжлийн дүгнэлт гаргуулж холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. Олон улсын стандарт, аргачлалын дагуу 2009 оны эхний 3 улирлын төлбөрийн тэнцэлд залруулга хийснээр урсгал тэнцлийн алдагдал 5.9 сая ам.доллараар, хөрөнгө ба санхүүгийн тэнцэл 106.1 сая ам.доллараар өсч, алдаа ба орхигдуулга 26.5 сая ам.доллараар сайжран, нийт төлбөрийн тэнцэл 293.5 сая ам.долларын ашигтай гарсан. Залруулга хийсэн төлбөрийн тэнцлийг цахим хуудсаар мэдээлсэн. Монголбанк, Сангийн яам, ГХЯ, ҮСХ, ГЕГазрын төлөөлөлтэй ажлын хэсэг байгуулагдаж, аргачлалыг боловсруулж батлуулсан.</p>	<p>Гадаад худалдааны статистикийн чанар, үнэн зөв байдлыг сайжруулах, төгрөгийн ханшийн талаарх захын оролцогчдын хүлээлтэд эерэгээр нөлөөлж, төгрөгийн хадгаламжийг ам.долларт хөрвүүлэх явцыг сааруулахад чухал ач холбогдолтой болсон.</p>
<p>Алтыг хууль бусаар хил дамнуулан худалдах, мөнгө угаах, богино хугацаанд ханшийн зөрүүнээс ашиг олох үйл ажиллагаатай холбоотой их хэмжээний хөрөнгө албан бус зах дээр хяналтгүй, бүртгэлгүйгээр эргэлдэж байна.</p>	<p>Валютын ханшийн тухай олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор Банкны сургалтын төвөөр дамжуулан хот, хөдөөд 200 гаруй хүнд сургалт хийсэн.</p>	<p>Банк хоорондын гадаад валютын захын илүүдэл/дутагдал, Монголбанкны интервенцийн хэмжээ, дуудлага худалдааны хамгийн их, бага, хаалтын, дундаж ханшийн мэдээллийг гадаад валютын захад оролцогчид тухай бүр шуурхай авах боломжтой болсноор мэдээллийн тэгш бус байдлаас хэт их ашиг олох үйл ажиллагааг бууруулж чадсан.</p>
<p>Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй төрийн бусад байгууллагуудтай хамтын ажиллагаагаа сайжруулж байна.</p>	<p>Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй төрийн бусад байгууллагуудтай хамтын ажиллагаагаа сайжруулж байна.</p>	

ОУВС-тай хөтөлбөр хэрэгжүүлж эхэлснээр Монголбанк нь 2009 онд төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг зах зээлийн нөхцөл, зарчмаар бодитой, чөлөөтэй тогтож байх бодлого баримталж, энэхүү бодлогын хүрээнд гадаад валютын дотоодын захын үр ашгийг нэмэгдүүлэх, валютын зохицуулалтын талаарх хууль, эрхзүйн орчныг сайжруулах, хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, гадаад валютын захын үр ашигтай ажиллах дэд бүтцийг бүрдүүлэх, гадаад валютын зохиомол эрэлтийг бууруулах, зах зээлд оролцогчдын ойлголтыг нэмэгдүүлэн, мэдээллийн хүртээмжийг сайжруулах зэрэг цогц арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлсэн юм. Цаашилбал ханшийн бодлогын чиглэлээр судалгааны ажлын цар хүрээг тэлж, чадавхийг сайжруулснаар ханшийн бодлогын оновчтой шийдвэр гаргалт, ханшийн тогтворжилтод чухал нөлөө үзүүлж байна.

Шигтгээ 2. Гадаад валютын дуудлага худалдаа, ханшийн тойм


Дотоодын банк хоорондын гадаад валютын захад Монголбанкнаас оролцох үйл ажиллагааг ил тод, нээлттэй явуулах замаар гадаад валютын дотоодын захын үр ашгийг нэмэгдүүлэх, төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг зах зээлийн зарчмаар тодорхойлох зорилгоор “Гадаад валютын дуудлага худалдааны журам”, “Гадаад валютын дуудлага худалдаа явуулах заавар”-ыг боловсруулж, Монголбанкны гадаад валютын арилжааг 2009 оны 3 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн зөвхөн дуудлага худалдаагаар хийхээр шийдвэрлэсэн.

Монголбанкны дуудлага худалдаанд Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж буй банкууд гадаад валют худалдан авах, худалдах саналаа ирүүлж оролцох бөгөөд дуудлага худалдаа нь бэлэн бус ам.долларын гүйлгээгээр хязгаарлагдана. Иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд нь өөрийн харилцагч банкаар дамжуулан дуудлага худалдаанд оролцох боломжтой.

Монголбанк гадаад валютын дуудлага худалдааг долоо хоног бүрийн Мягмар, Пүрэв гараг бүр зохион байгуулдаг ба дуудлага худалдааны үр дүнгийн талаарх мэдээллийг Монголбанкны цахим хуудсанд тухай бүр байршуулан олон нийтэд мэдээлж байна.


Анхны дуудлага худалдааг явуулснаас эхлэн 2009 оныг дуустал 82 удаагийн дуудлага худалдаагаар 143.2 сая ам.доллар худалдан авч, 78.7 сая ам.доллар худалдсанаар гадаад валютын улсын нөөцийг 64.5 сая ам.доллараар нэмэгдүүлсэн. Энэ нь захын тэнцвэрт байдлыг дэмжих замаар ханшийн хэт хэлбэлзлийг зөөлрүүлэх зорилготой байв.

Төгрөгийн ам.доллартай харьцах албан ханш 2009 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 1442.84 төгрөг байсан нь 2008 оны жилийн эцсээс 13.8 хувиар буюу 175.33 төгрөгөөр суларсан бол 2009 оны оргил түвшингээс 9.3 хувиар буюу 147.86 төгрөгөөр чангарчээ. Төгрөгийн ам.доллартай харьцах ханш банк хоорондын зах дээр 1675 төгрөг, албан бус зах дээр 1740 төгрөг хүрч байсан бол 2009 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар харгалзан 1445.35 төгрөг, 1450 төгрөг болж чангарсан.




Зураг 19

Банкуудын гадаад валютын эрэлт ба Монголбанкны интервенц



Зураг 20

Банк хоорондын зах дахь гадаад валютын шлүүдэл



Зураг 21

Төгрөгийн ханшийн хөдөлгөөн, 2009 он

Эх сурвалж: Монголбанк, ВЭЗГ

1.4 . Улсын валютын нөөцийн удирдлага

Дэлхий нийтийг хамарсан эдийн засгийн уналт, олон улсын санхүүгийн салбарын тогтворгүй байдал үргэлжилж байсан 2009 онд Монголбанк нь гадаад валютын улсын нөөцийг удирдахдаа түүний найдвартай байдлыг хангах, хөрвөх чадварыг алдагдуулахгүй байх, үр өгөөжийг нэмэгдүүлэх зарчмыг үргэлжлүүлэн баримтлан ажиллалаа. Уг ажлын хүрээнд 2009 онд дараах үндсэн гол арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн болно.

1. 2008 оноос Монголбанк гадаад валютын улсын нөөцийг байршуулах валютуудын хувь хэмжээг Монгол улсын гадаад төлбөр тооцоо, импортын болон экспортын төлбөртэй уялдуулан тодорхойлж эхэлсэн бөгөөд 2009 онд энэхүү үйл ажиллагааг илүү боловсронгуй болгож, улмаар гадаад валютын улсын нөөцийн төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг сайжруулж, гадаад төлбөр тооцоог ханшийн эрсдэлгүйгээр гүйцэтгэх боломжийг нэмэгдүүлсэн.
2. Хөрөнгө оруулалтын болон харилцагчийн эрсдэлээс сэргийлэх үүднээс гадаад валютын улсын нөөцийг АНУ-ын Засгийн газрын үнэт цаас, АНУ, Герман, Япон, Их Британи, Швейцарь, Шинэ Зеландын төв банкууд, Олон улсын төлбөр тооцооны банкны үнэт цаас, харилцах, хадгаламж, “АА”-аас дээш зэрэглэл бүхий гадаадын банк, санхүүгийн байгууллагуудын хадгаламжид байршуулав. Үүний үр дүнд Засгийн газрын гадаад орон руу гүйцэтгэх аливаа төлбөр тооцоог тухай бүр саадгүй гүйцэтгэсний зэрэгцээ гадаад валютын улсын нөөцийн найдвартай байдлыг бүрэн хангасан болно.

Гадаад валютын улсын нөөц 2009 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 1,327.4 сая ам.долларт хүрсэн нь түүхэн дээд түвшин бөгөөд Монгол Улсын импортын 27.7 долоо хоногийн төлбөрийг гүйцэтгэх хэмжээнд байв. Гадаад валютын улсын нөөцийг 2008 оны мөн үетэй харьцуулахад 102 хувь буюу 670 сая ам.доллараар нэмэгдэж, зорилтот үзүүлэлт бүрэн биелсэн байна. Энэхүү үр дүнд хүрэхийн тулд дараах эх үүсвэрээр гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлсэн:

- ОУВС-гийн “Стэнд-бай” хөтөлбөрийн зээл, зээлжих тусгай эрхийн хуваарилалтын 239.8 сая ам.доллар,
- Монголбанкнаас 2009 онд мөнгөжүүлсэн 5.2 тонн алт буюу 163.7 сая ам.доллар,
- Хандивлагч орнуудын Засгийн газар, санхүүгийн байгууллагын хөнгөлөлттэй зээлийн 151.3 сая ам.доллар,
- Засгийн газраас “Оюу толгой” төслийн асуудлаар “Айвенхоу Майнз Монголиа Инк” компанитай байгуулсан гэрээний дагуу орж ирсэн 100.0 сая ам.доллар,
- Банкуудын Монголбанк дахь гадаад валютын харилцах, хадгаламжийн үлдэгдлийн өсөлт 81.4 сая ам.доллар,
- Монголбанк олон улсын санхүүгийн зах зээл дээр 7.1 тонн мөнгөжүүлсэн алтыг худалдсаны цэвэр ашиг 6.84 сая, гадаадын банк, санхүүгийн байгууллагуудад байршуулсан валютын хадгаламж, үнэт цаасны хүүний орлого 7.81 сая, гадаад валютын арилжааны ашиг 0.6 сая, нийт 15.25сая ам.доллар байна.



Эх сурвалж: Монголбанк, ВЭЗГ

Зураг 22


Гадаад валютын
улсын нөөцийн
хурьцээтэй
байдал /2009 онд/



Эх сурвалж: Монголбанк, ВЭЗГ

Зураг 23

Монголбанкны
алт худалдан
авалт



Эх сурвалж: Монголбанк, ВЭЗГ

Зураг 24

Монголбанкны алт
цэвэршүүлэлт

Гадаад валютын дээрх өсөлтийн 98.2 хувь нь нөөцийн бодит өөрчлөлт байсан бол 1.8 хувь нь валютын ханшийн өөрчлөлтөөс шалтгаалжээ. Тухайлбал, гадаад валютын цэвэр албан нөөцийн өсөлтийн 88.3 хувийг ам. долларын, 6.4 хувийг еврогийн, 1.2 хувийг иенийн, 1.1 хувийг мөнгөжсөн алтны бодит өөрчлөлт эзэлж байна.

Тайлант онд Монголбанк нь алт олборлогч 125 гаруй аж ахуйн нэгж, давхардсан тоогоор 149 иргэдээс бохир жингээр 5.0 тонн, цэвэрт шилжүүлснээр 4.5 тонн алтыг 198.9 тэрбум төгрөгөөр шууд болон банкуудаар дамжуулан худалдан авсан. Энэхүү худалдан авсан алт нь улсын хэмжээнд олборлосон алтны 51.0 хувь, сорьц тогтоолгосон алтны 97 хувийг эзэлж байна. “Бороо гоулд” компаниас Монгол Улсын Засгийн газартай байгуулсан “Тогтвортой байдлын гэрээ”-ний дагуу тус компаниас бие даан шууд экспортолсон 5.4 тонн алтыг хасч тооцвол Монголбанк нь 2009 онд олборлосон алтыг 100 хувь буюу бүрэн хэмжээгээр худалдан авчээ.

Монголбанк 2009 онд 5.0 тонн алт худалдан авсныг 2008 онтой харьцуулахад 3.2 тонноор буюу 39 хувиар буурсан. Энэ нь Монголбанкинд 2008 онд 2.7 тонн алт худалдаж байсан “Алтан дорнод монгол” компанийн олборлолтын үйл ажиллагаа зогссоны улмаас 2009 онд Монголбанкинд алт тушаагаагүй, “Эм Жи Эйч” компанийн тушаасан алт 2008 оныхоос 1.2 тонноор буюу 68 хувиар буурсантай холбоотой. Эдгээр компанийн нөлөөллийг хасч тооцвол 2009 онд Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ 2008 оныхоос 0.7 тонн буюу 15 хувиар өссөн байна.

Дэлхий нийтийг хамарсан эдийн засгийн уналт, олон улсын санхүүгийн салбарын тогтворгүй байдлаас шалтгаалж 2009 онд голлох валютуудын хүүний түвшин түүхэнд байгаагүйгээр буурсантай холбоотойгоор санхүүгийн хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийн хүүний орлого 7.81 сая ам. доллар болж өнгөрсөн оноос 2.8 дахин буурлаа. Үнэт металлын спот арилжааны орлого өмнөх оны мөн үеэс 2.2 дахин буурч, 4.66 сая ам.долларт хүрчээ. Энэ нь 2009 онд Монголбанкинд алт тушаалт буурсантай холбоотой. Тайлант онд гадаад валютын улсын нөөцийн үр өгөөж 1.95 хувь байлаа.

1.5. Гадаад валютын улсын нөөцийн эрсдэлийн удирдлага

Монголбанк нь гадаад валютын улсын нөөцийн удирдлагад найдвартай байдлыг хангах, хөрвөх чадварыг алдагдуулахгүй байх, үр өгөөжийг нэмэгдүүлэх гэсэн зарчмын дарааллыг хэрэгжүүлж ирлээ. Эдийн засгийн хямралын үед баримтлах эрсдэлийн удирдлагын бодлогын чиглэлийг тодорхойлон, хэрэгжилтэд өдөр тутмын хяналт тавин ажиллаж байна.

Тайлант онд Монголбанкны эрсдэлийн хүлээн зөвшөөрөгдөх түвшинд гадаад валютын улсын нөөцийн бүтцийг баримтлан ажиллалаа. Ерөнхий бүтцийн хүрээнд гадаад валютын улсын нөөцийн активын бүтэц, гадаад валютын бүтэц, багцын бүтэц, урт хугацаат хөрөнгө оруулалтын зохистой хугацаа, хөрөнгө оруулалтын боломжит хэрэгслүүдийг тус тус тодорхойлов. Мөн гадаад валютын улсын нөөцийн хөрөнгө оруулалтуудын зах зээлийн үнэлгээг тогтмол хийж, зах зээлийн эрсдэлүүдийг тооцох, зээлийн эрсдэл болон холбогдох лимитүүдэд хяналт тавих, дэлхийн зах зээлийн байдлыг байнга ажиглан холбогдох мэдээ тайлан бэлтгэх зэрэг ажлуудыг гүйцэтгэлээ.

Дэлхийн санхүүгийн хямрал тайлант онд үргэлжилсээр байсан тул гадаад валютын улсын нөөцийг түүний найдвартай байдал, төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангах зорилгоор Төв банкууд дахь харилцах данс болон хадгаламж, Олон улсын төлбөр тооцооны банкны хадгаламж, богино хугацаат үнэт цаас, АНУ-ын засгийн газрын урт хугацаат үнэт цаас зэрэг эрсдэлгүй хөрөнгө оруулалтанд хийх чиглэлийг үргэлжлүүлэн баримталж ажиллалаа.

2.1. Банкны салбарын өнөөгийн байдал, учирч буй бэрхшээл

Банкны салбарын нийт актив 2009 онд 4.4 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 21.1 хувиар өслөө. Энэхүү өсөлт өмнөх оныхоос 13.3 нэгжээр өссөн байгаа боловч гадаад валютын ханшийн өсөлт ихээхэн нөлөөлжээ. Санхүүгийн салбарын 95 орчим хувийг эзэлж байгаа банкны салбарын нийт активын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь өмнөх оноос бага зэрэг буюу 9.6 нэгжээр өсч 69.9 хувьтай болсон байна. Эдийн засгийн ерөнхий нөхцөл байдал хүндэрсэн, 2009 оны 2 дугаар улирал хүртэл үргэлжилсэн төгрөгийн ханшийн сулралт зэрэг нь банкуудын зээлийн чанар, төлбөр түргэн гүйцэтгэх чадварт сөргөөр нөлөөлж, ханшийн тэгшитгэлийн алдагдал хүлээх хүндрэл үүсгэсэн юм.

Төрөөс банкин дахь мөнгөн хадгаламж, харилцахад баталгаа гаргасны үр дүнд 2008 оны 10 дугаар сард эхэлсэн банкны салбарын хадгаламжийн огцом гадагшлалт аажмаар буурч тайлант оны эхний хагаст нийт хадгаламжийн хэмжээ хямралын өмнөх үетэй эргэн тэнцэж 2.5 их наяд төгрөг болсон байна. Энэ нь банкуудын төлбөрийн чадварт учирч байсан дарамтыг бууруулахад чухал ач холбогдолтой байлаа. Тухайлбал, тайлант оны 11 дүгээр сард нэг зээлдэгчид олгох зээлийн хязгаарлалтыг зөрчсөний улмаас зээлийн багцын чанар нь ихээхэн муудаж, өндөр хэмжээний алдагдалтай ажиллаж, харилцагчдын анхны шаардлагаар төлбөр тооцоог гүйцэтгэх боломжгүй болсон Зоос банкинд Монголбанкнаас эрх хүлээн авагч томилсон боловч энэ нь нийт хадгаламж эзэмшигчдийн банкны салбарт итгэх итгэлд сөрөг нөлөө үзүүлээгүй гэж дүгнэж болохоор байна. Нийт хадгаламж 2009 онд 34.5 хувь буюу 460.7 сая төгрөгөөр өсч 1.8 их наяд төгрөгт хүрчээ. Тайлант онд Монголбанкнаас банкуудын хөрвөх чадварыг дэмжих үүднээс банк хоорондын зах дээр урвуу репо, барьцаат зээл, гадаад валютын своп зэрэг санхүүгийн шинэ бүтээгдэхүүнээр дамжуулан банкуудад нийт 96 тэрбум төгрөгийн зээлийг олгосон байна. Эдгээр арга хэмжээний үр дүнд банкны салбарын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт өмнөх онтой харьцуулахад 2009 онд 16.6 нэгжээр нэмэгдэж 38.3 хувьд хүрсэн байна.⁹ Гэвч банкуудын хөрвөх чадварын эрсдэлийг бууруулах талаар Төв банк болоод банкуудын удирдлагын зүгээс цаашид хийж гүйцэтгэх ажил их байна.


Санхүүгийн тогтвортой байдлыг хамгаалах, банкуудад хөрвөх чадварын дэмжлэг үзүүлэх зорилгоор Монголбанк нь Сангийн яам болон бусад байгууллагуудтай амжилттайгаар хамтран ажилласан болно. Тухайлбал банкны салбарын төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг сайжруулах зорилгоор Монгол улсыг хөгжүүлэх сангийн мөнгөн хөрөнгийг банкуудад байршуулах ажилд Монголбанкнаас Монгол улсын засгийн газар, Сангийн яамтай хамтран ажиллав. Үүнд 3 банкинд нийт 65 тэрбум төгрөгийг хадгаламж хэлбэрээр байршуулсан байна. Эдгээр нь одоогийн байдлаар бүгд эргэн төлөгдөж дууссан байна. Мөн алт олборлох үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор 66.25 сая ам.долларын зээлийн санхүүжилтийг 5 банкинд олгосон. Үүнээс 2009 онд 44.9 сая ам.долларын зээлийг банкуудаар дамжуулан давхардсан тоогоор 23 компанид олгосон байв.

Хэдийгээр 2012 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийг хүртэлх хугацаанд банкинд байршуулсан харилцах, хадгаламжинд төрөөс 100 хувь баталгаа гаргасан нь эерэг

⁹ Банкны үйл ажиллагаанд тавих зохистой харьцаанд заасны дагуу хөрвөх чадвартай активыг нийт пассивт харьцуулсан харьцаа болно


Зураг 25

Банкны салбарын актив ба санхүүгийн зуучлал




Зураг 26

Банкны салбарын нийт зээл ба чанаргүй зээлийн үзүүлэлтүүд



Зураг 27

Банкны салбарын зээлийн багцын эдийн засгийн ангилал




нөлөө үзүүлж байгаа боловч төсөв, Монгол улсын татвар төлөгчдийн нуруун дээр дарамт учруулж болзошгүй байна. Төрөөс баталгаажуулсан харилцах, хадгаламжийн дүн тайлант оны эцэст 3.1 их наяд төгрөг байгаа нь дотоодын нийт бүтээгдэхүүний 51 хувьтай тэнцэж байна.

Эдийн засгийн өсөлт саарч, бизнес эрхлэгчдийн борлуулалтын эргэц удааширсны улмаас зээлдэгчдийн төлбөрийн чадвар буурч, зээлийн эрсдэл өссөн байна. Иймээс банкуудын чанаргүй зээлийн хэмжээ өсч, ашигт ажиллагаа буурч байна. Жишээлбэл 2009 оны байдлаар оны эхнээс чанаргүй зээлийн хэмжээ барилгын салбарт 75.1 тэрбум төгрөг, боловсруулах үйлдвэрт 60.2 тэрбум төгрөг, худалдааны салбарт 41.5 тэрбум төгрөг, уул уурхайн салбарт 35.3 тэрбум төгрөгөөр өссөн байна. Банкны салбарын хэмжээнд нийт чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 2009 онд 2.8 дахин нэмэгдэж 544.1¹⁰ тэрбум төгрөг болжээ. Чанаргүй зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувийн жин 12.8 нэгжээр нэмэгдэж 20 хувьд хүрэв. Ийнхүү зээлийн эрсдэлийн түвшин өссөнөөр банкуудын зээл олголтын хэмжээ буурсан байна. Банкны салбарын нийт зээлдэгчдийн тоо 2008 оноос 2.8 хувиар буурч 502 мянгад хүрчээ.

Зээлийн чанар муудаж, зээлийн активын өсөлтийн хурд буурснаар зээлийн хүүний орлого буурч, зээл төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах сангийн зардал өсч байна. Тайлант оны байдлаар банкууд нийт 204.6 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллалаа. Зээлийн хүүний орлого өмнөх оны мөн үеийн түвшинтэй харьцуулахад 1.1 хувиар буюу 5 тэрбум төгрөгөөр буурч, эрсдэлийн сангийн зардал 87.5 хувь буюу 128.7 тэрбум төгрөгөөр нэмэгджээ. Банкны салбарын зээлийн чанар муудснаар банкуудын ашигт ажиллагаа буурч, зарим банкууд өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтийн байвал зохих доод хэмжээг хангаж ажиллахгүйд хүрээд байна.

Банкны салбарын өөрийн хөрөнгийн нийт дүн 2008 оны эцэстэй харьцуулахад 178.1 тэрбум төгрөг буюу 52.2 хувиар буурсан байна. Монголбанкнаас эрх хүлээн авсан Анод, Зоос банкуудыг хассанаар банкны салбарын өөрийн хөрөнгийн зохистой харьцааны үзүүлэлт 14 хувь байгаа нь өмнөх оноос 1.3 нэгжээр буурсан байна. Банкны салбарын хэмжээнд өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтийг хангахгүй байгаа банкуудад нийтдээ 64.1 тэрбум төгрөгийн нэмэлт өөрийн хөрөнгө шаардлагатай байгаа нь дотоодын нийт бүтээгдэхүүний 1 хувьтай тэнцэж байна.



Зураг 28

Өөрийн хөрөнгийн хүрэлцээ, (Анод, Зоос банкуудыг оруулаагүй)

¹⁰ ХШГ-ын тооцоо

Банкны салбарыг эрүүл, хэвийн үйл ажиллагаатай болгохын тулд цогц бүтцийн өөрчлөлтийг хийх, салбарын чанаргүй активыг бууруулах, хадгаламжийн даатгалын сонгодог тогтолцоог нэвтрүүлэх, үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байгаа банкуудад өөрийн хөрөнгийн дутагдлын хэмжээнд нь дахин санхүүжилт хийх, харилцагчдад шинээр зээл олгохыг дэмжих шаардлага үүсээд байна. Банкуудын эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэхийн тулд Монголбанкны Ерөнхийлөгчийн 2009 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 154 дугаар тушаалаар “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, хяналт тавих журам”-д өөрчлөлт оруулж, банкуудын өөрийн хөрөнгийн зохистой харьцааг 12 хувь болгон нэмэгдүүлэв. Цаашид банкуудын эрсдэлийн удирдлагыг сайжруулах, бодит үнэлгээг гаргах үүднээс өөрийн хөрөнгийн хүрэлцээний тооцоонд холбоотой этгээдийн хөрөнгө оруулалт, банк хоорондын санхүүжилтийг харгалзан үзэх хэрэгтэй юм.

Эдийн засгийн боломжит гарц тогтвортой, банкны ашигт ажиллагаа харьцангуй өндөр байсан үед бүрдүүлсэн эрсдэлийн сангийн хөрөнгөө ашиглах бололцоог банкуудад олгон Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2009 оны 3 дугаар сарын 4-ний өдрийн хамтарсан тушаалаар зээлийн эрсдэлийн сангийн хувь хэмжээг бууруулан тогтоосон. Үүнд хэвийн бус зээлд 40 хувиар сан байгуулдаг байсныг 25 хувь, эргэлзээтэй зээлд 75 хувь байсныг 50 хувь болгон өөрчилсөн. Үйл ажиллагаанд нь түр хугацааны хүндрэл үүссэн аж ахуйн нэгжийн хувьд зээлээ банктай уян хатан дахин тохиролцох нөхцлийг бүрдүүлэх үүднээс зээлийн эргэн төлөгдөх хугацааг 2 удаа сунгахыг Төв банкнаас зөвшөөрөв. Борлуулалтын эргэц, мөнгөн урсгал нь богино хугацаагаар удааширсан шалтгаанаар эргэн төлөлт нь саатсан зээлдэгчдэд уян хатан хандан зээлийн нөхцлийг тухайн орчинтой уялдуулан өөрчлөх боломжийг Монголбанкнаас банкуудад олголоо.

Монголбанкны зүгээс орон сууцны санхүүжилтийн анхдагч болон хоёрдогч захыг хөгжүүлэхэд идэвх санаачилгатай ажиллаж ирлээ. Банкуудад мөрдөх ипотекийн анхдагч зээлийн нэгдсэн журмыг батлан мөрдүүлсэн нь ипотекийн анхдагч зээлийг банк бүр ижил төстэй шаардлагын дагуу олгон хоёрдогч захад зориулан зээл багцлах ажлыг хөнгөвчилж нэг жишигт оруулсан. Ипотекийн зээлийн харьцааг зохицуулах гол үндсэн хууль болох “Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай” хууль УИХ-ын 2009 оны хаврын чуулганаар батлагдан гарах бэлтгэл ажилд Монголбанкны төлөөлөл орж ажиллалаа. Германы Сэргээн босголт, хөгжлийн банкны 4.8 сая еврогийн эх үүсвэрийг орон сууцны зээлийн эх үүсвэрт ашиглах асуудал УИХ дээр эцэслэх шатандаа байна. Мөн Монголын Ипотекийн Корпорацийн бондоор дамжуулан орон сууцны санхүүжилтийн нэмэлт 25 тэрбум төгрөгийн эх үүсвэр гаргасан байна.

2.2. Банкны хяналт шалгалтын үйл ажиллагаа

Монголбанк санхүүгийн зах зээл, банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах замаар үндэсний эдийн засгийн тэнцвэртэй хөгжилд дэмжлэг үзүүлэх өөрийн үндсэн зорилтын хүрээнд хадгаламж эзэмшигч, харилцагчийн эрх ашгийг хамгаалах, банкны тогтолцооны найдвартай байдлыг бэхжүүлэх зорилгоор 2009 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна.

Банкны тухай хууль тогтоомж, төрийн мөнгөний бодлого болон Монголбанкны Ерөнхийлөгчийн шийдвэр, түүгээр баталсан журам, зааврыг банкууд хэрхэн биелүүлж

байгаад хяналт тавих ажлын хүрээнд газар дээрх хяналт шалгалтын тоог нэмэгдүүлж, газар дээрх шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг цаг алдалгүй засч, залруулан ажиллаж байгаа бөгөөд 2009 онд давхардсан тоогоор нийт 33 удаагийн газар дээрх шалгалтыг иж бүрэн болон хэсэгчилсэн хэлбэрээр 15 банкинд хийж гүйцэтгэжээ. Тайлант онд хийгдсэн дээрх шалгалтуудаар банкууд актив болон түүнтэй адилтган тооцох хөрөнгийн ангиллыг зохих журмын дагуу ангилаагүй, зээл, активын учирч болзошгүй эрсдэлээс хамгаалах санг дутуу байгуулсан, зээлийн хүүг зохих журмын дагуу хуримтлуулан тооцдоггүй, хууль, тогтоомжид заасан зохистой харьцааны үзүүлэлтүүдийг зөрчсөн, тайлан мэдээ буруу гаргасан, нягтлан бодох бүртгэлийн заавар, олон улсын бүртгэлийн стандартыг зөрчсөн, тэнцлийн гадуурх хүлээж болзошгүй үүргийг зохих журмын дагуу тайлан тэнцэлд бүртгээгүй зэрэг зөрчил дутагдлууд илэрлээ. Эдгээр зөрчил дутагдлуудыг арилгуулах талаар тухайн шалгалтын дүн дээр тулгуурлан Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар тухайн банк өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх төлөвлөгөө боловсруулан Монголбанкаар хянуулсны үндсэн дээр хэрэгжүүлэх, чанаргүй зээл, активыг бууруулах, нэг зээлдэгч болон банкны холбогдох этгээдэд олгох зээлийн хязгаарлалтыг ханган ажиллах, актив хөрөнгө дэх зээлийн өсөлтийг хязгаарлах, ашигт ажиллагааг сайжруулах, гадаад төлбөр тооцооны зарим эрхийг хүчингүй болгох, түдгэлзүүлэх, өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх хүртэл хугацаанд хадгаламжийн хэмжээг нэмэгдүүлэхгүй байх, шинээр хөрөнгө оруулалт хийх, зээл олгох үйл ажиллагааг хязгаарлах зэрэг арга хэмжээг банкуудад авч хэрэгжүүлэн тушаалаар өгөгдсөн үүргийн биелэлтэд тогтмол хяналт тавин ажиллаж байна.

Төлбөрийн чадвар алдагдаж, зээл болон бусад активын чанар муудаж, пассив нь активаас давж өөрийн хөрөнгө хасах болсон, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаагүй, харилцагч, хадгаламж эзэмшигчдийн мөнгөн хөрөнгийг анхны шаардлагаар гарган өгч чадахгүйд хүрсэн тул банкны салбарын тогтвортой байдлыг хангах, иргэдийн банкинд итгэх итгэлийг бууруулахгүйн үүднээс “Банкны тухай” хууль тогтоомжийн дагуу Зоос банкинд албадлагын арга хэмжээ авч Эрх хүлээн авагчийг Монголбанкнаас томилон ажиллуулж байна. Засгийн газраас Зоос банкны сайн активууд дээр тулгуурлан Төрийн банкныг байгуулсан бөгөөд чанар муутай активуудыг Зоос банкинд нь үлдээн өр төлбөрийг барагдуулах талаар холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлж эхэллээ.

Үүнээс гадна Хяналт шалгалтын газраас банкны санхүүгийн тайлан болон бусад холбогдох мэдээллийг сар бүр хүлээн авч, зохистой харьцаа болон шалгуур үзүүлэлтүүдийн хэрхэн хангаж байгаад тогтмол хяналт тавин, шаардлагатай нөхцөлд хууль тогтоомжийн дагуу шат дараалсан арга хэмжээг авч, санхүүгийн зах зээлийн сахилга батыг өндөржүүлэн ажиллаж байна.

Мөн Монголбанкнаас банкуудад тавих хяналт шалгалтын агуулга, хамрах хүрээ, хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор Төв банкны боловсон хүчний нөөц бололцоог дээшлүүлэх, хяналт шалгалтын талаарх хууль, эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр тогтмол анхаарч ажиллаж байна.

Банкны зохистой удирдлагын шилдэг туршлагыг нэвтрүүлэх, удирдлагын ил тод байдлыг хангах, жижиг хувь нийлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах үүднээс зохистой удирдлагын цогц тогтолцоог бий болгож, Монголбанк болон банкуудын удирдлагын зүгээс банкныхаа зохистой удирдлагын үнэлгээг хийх, банкуудыг хооронд нь харьцуулах боломжийг олгох, мөн мэдээллийн технологийн эрсдэлийг бууруулж харилцагчдын төлбөр тооцооны найдвартай байдлыг хангах, мэдээллийн нууцыг баталгаажуулах

зорилгоор банкны зохистой удирдлага болон мэдээллийн технологийн хяналт шалгалтын журам, зөвлөмжийг ойрын хугацаанд батлан гаргахаар төлөвлөн ажиллаж байна.

Монголбанкнаас эдийн засгийн хямралын орчинд банкны салбарын тогтвортой байдлыг хэвээр хадгалан харилцагч, хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийн тууштай хамгаалахад чиглэсэн багц арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр олон улсын хандивлагч хамтын нийгэмлэгтэй тохиролцон хэрэгжүүлж эхлээд байна. Энэ ажлын эхлэл болгон хямралын үеийн банкны салбарын чанаргүй зээлийн багцын бодит хэмжээ, тэнцлийн гадуур хүлээж болзошгүй үүргүүд зэргийг үнэн зөв, бүрэн гүйцэд, хараат бус байдлаар бүртгэж байгаа эсэхийг тодруулах зорилгоор Дэлхийн банкны санхүүжилтээр 4 банкинд Герман улсын Прайсватерхаус Күүперс компаниар тусгай үнэлгээг хийлгүүллээ. Цаашид дэлхийн хамгийн нэр хүнд бүхий 4 компанийн 3-аар Монголын банкуудад 2010 оны 1-р улиралд багтаан тусгай үнэлгээг хийлгүүлэхээр гэрээ, хэлэлцээр байгуулах ажлууд хийгдэж байна.

Банкин дахь мөнгөн хадгаламжинд баталгаа гаргах тухай хуульд 2009 оны 3 дугаар сарын 6-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулан банкин дахь иргэд, хуулийн этгээдийн харилцах дансны үлдэгдэлд мөн адил төрөөс баталгаа гаргасан нь банкны салбарын хувьд эх үүсвэр гадагшлахаас сэргийлсэн чухал арга хэмжээ болсон юм. Гэвч нөгөө талаас банкны татсан хадгаламж, харилцах дансны үлдэгдэл төрөөс 100 хувь баталгаа гаргах нь зарим банкууд болон зээлдэгчдийн хувьд ажлын хариуцлагагүй байдал үүсэх, төрөөс гаргасан баталгааг зүй бусаар ашиглах /moral hazard/ зэрэгт нөлөөлж болзошгүй тул цаашид банкуудаас татсан хадгаламжийнхаа хэмжээгээр шимтгэл төлж эх үүсвэр хуримтлуулдаг банкны хадгаламжийн даатгалын сонгодог тогтолцооны үндсийг тавих шаардлагатай байгаа юм. Ингэснээр төрөөс хадгаламжийн баталгаагаар үүрч болзошгүй зардлын хэмжээг бууруулах бололцоог олгох бөгөөд Монголбанкнаас хадгаламжийн даатгалын байгууллагатай холбоотой судалгааг эхлүүлэн, “Хадгаламжийн даатгалын тухай” хуулийн төслийг боловсруулан батлуулахаар ажиллаж байна.

Сүүлийн жилүүдэд банк, банк бус санхүүгийн байгууллага, даатгал болон үнэт цаасны компани гэх мэт санхүүгийн байгууллагууд охин болон хараат санхүүгийн үйл ажиллагаа эрхэлдэг компаниудыг байгуулж, өөр хоорондоо үйл ажиллагаа, хувь нийлүүлсэн хөрөнгө, бүтцийн хувьд нягт холбоотой болох хандлагатай байна. Энэ нь нэг талаас банк, санхүүгийн байгууллагын хоорондын уялдаа, үр ашгийг дээшлүүлэх давуу талтай боловч нөгөө талаас хямралын үед нэг санхүүгийн зах зээлийн хүндрэл нөгөөд тархаж болзошгүй буюу улмаар нийт санхүүгийн салбарын эрсдэлийг нэмэгдүүлж байгаа юм. Иймд Монголбанкнаас нэгдсэн хяналт шалгалтын тогтолцоог нэвтрүүлж, уг эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч эхлээд байна. Нэгдсэн хяналт шалгалтыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд зохих эрх зүйн тогтолцоог бүрдүүлсэн байх шаардлагатай тул “Банкны тухай” хуулийн шинэчилсэн найруулгад тусган УИХ-аар батлуулахаар өргөн бариад байна.

Банкны мэдээллийн нэгдсэн сангийн үйл ажиллагааг боловсронгуй болгож, төрийн мэдээллийн санд холбогдох мэдээллийг шуурхай дамжуулах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор Зээлийн мэдээллийн сангийн систем болон банкуудын нэгдсэн тайлан бүртгэлийн системүүдийг шинэчлэн боловсруулан ашиглаж эхлээд байна. Уг шинэчлэгдсэн системүүд нь мэдээллийн чанар болоод хүртээмжийн хувьд нэлээд сайжирсан бөгөөд сүүлийн үеийн дэвшилтэд технологид суурилсан юм.

3.1. Удирдлага зохион байгуулалт

Төв банк нь удирдлага, 7 газар, 2 бие даасан алба, орон нутаг дахь Монголбанкны 17 салбар, Лондон дахь төлөөлөгчийн газар бүхий бүтэц зохион байгуулалттайгаар үйл ажиллагаа явуулж байна. Банкны сургалтын төв нь Монголбанкны дэргэд удирдлага зохион байгуулалтаар хангагдан ажиллаж байна.

Тайлант оны байдлаар Монголбанкинд нийт 358 ажилтан, үүнээс 203 буюу 56.7 хувь нь эрэгтэй, 155 буюу 43.3 хувь нь эмэгтэй ажилтнууд байна. Нийт ажилтнуудын 71.5 хувь нь Төв аппаратад ажиллаж байна.

Нийт ажилтнуудын 54.4 хувь нь эдийн засагч (хянан шалгагч), нягтлан бодогч, 45.6 хувь нь эрх зүйч, мэдээллийн технологийн инженер гэх мэт бусад мэргэжлийн ажилтнууд байна. Мэргэжлийн бүтцийг авч үзвэл эдийн засагч, нягтлан бодогч, бизнесийн удирдлага, эрх зүйч гэсэн мэргэжилтэй ажилтан нийт ажилтны 71.4 хувийг эзэлж байгаа нь Монголбанкны үйл ажиллагааны стратеги, алсын хараа, эрхэм зорилгыг хэрэгжүүлэхэд мэргэжлийн түвшний хувьд боломжийн, чадамжтай байгааг харуулж байна. Ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулахад тодорхой бодлого баримталж, гадаад дотоодын сургууль курст суралцаж мэргэжил боловсролоо дээшлүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлэхэд анхаарч байна. Тайлант онд гадаад, дотоодын урт богино хугацааны сургалтад төв аппаратаас 90 гаруй, орон нутгийн салбаруудаас 16 хянан шалгагч оролцсон ба удирдах ажилтнууд хамтын ажиллагаатай олон улсын банк санхүүгийн байгууллагуудын хурал зөвлөлгөөнд тогтмол оролцож ирлээ.

Ажилтнуудын мэргэжил мэдлэгийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн түвшинд хүргэх, сурч боловсрох эрхийг хангаж олон улсын байгууллага, өндөр хөгжилтэй орнуудын Засгийн газрын шугамаар АНУ, Австрали, Япон улсад зохион байгуулагдаж байгаа сургалтад суралцуулж байна. Ажилтнуудын цалин, урамшууллыг ажлын үр бүтээлтэй уялдуулан улирал бүр дүгнэж ажилласан ба цалин хөлсийг нэмэгдүүлэх, ажлын байрны нөхцөлийг сайжруулах, орон байр олгох асуудлыг тухай бүр төсөв хөрөнгөтэй уялдуулан тогтсон эрх зүйн зохицуулалтын хүрээнд шийдвэрлэсэн болно.

Монголбанкны ахмад настанд хүндэтгэл үзүүлэх, нэмэгдэл тэтгэвэр тэтгэмж олгох тухай журмыг шинэчлэн мөрдөж байгаа ба журмын дагуу ахмадууддаа 2 удаа хүндэтгэл үзүүлсэн.

3.2. Дотоод аудит

Монголбанкны Дотоод аудитын газраас 2007-2011 онд хийх аудитын урт хугацааны төлөвлөгөө, 2009 оны аудитын төлөвлөгөөний дагуу Монголбанкны газар, хэлтэс албад, орон нутаг дахь салбар нэгжүүдэд Төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагааг хууль, тогтоомжийн хүрээнд явуулж буй эсэхэд хяналт тавьж шалгалт хийлээ.

Төв, орон нутгийн газар, хэлтэс, алба, салбар нэгжид иж бүрэн, хэсэгчилсэн гэнэтийн болон санал гомдлын мөрөөр шалгалт хийж учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бий болсон эрсдэлийг бууруулах, арилгахад шалгалтыг чиглүүлсэн бөгөөд

илэрсэн зөрчил дутагдлын мөрөөр холбогдох арга хэмжээ авч шийдвэр гаргуулан санал зөвлөмж, үүрэг даалгавар өгч ажиллалаа.

Тайлант хугацаанд “Монголбанкны орон нутаг дахь салбар, төлөөлөгчийн газрын ажлыг шалган үнэлгээ дүгнэлт өгөх журам”-ыг шинэчлэн боловсруулж Монголбанкны Ерөнхийлөгчийн 2009 оны 12-р сарын 25-ны өдрийн 732 тоот тушаалаар батлуулан дараа оны шалгалтын ажилд мөрдөхөд бэлэн болгоод байна.

“ДАГ-ын үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн баримт бичгүүдийг олон улсын стандартад нийцүүлэх судалгаа явуулж, шинэчлэн боловсронгуй болгох” ажлын хүрээнд “Монголбанкны газар, хэлтэс, алба, салбар, нэгжийн хувийн хэрэг хөтлөх заавар”-ыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2009 оны 4-р сарын 218 тоот тушаалаар батлуулсан.

Дотоод аудитын газрын шалгалтын “Мэдээллийн сан”-г үүсгэн програмын асуудлыг бүрэн шийдвэрлэж түүнээс шуурхай, үнэн зөв мэдээллийг авах зорилгоор Монголбанкны газар, хэлтэс, алба, салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагаанд 2006 оноос хойш хийсэн шалгалтын болон бусад мэдээллийг уг санд төвлөрүүлэн, ажиллаж байна.

Хөндлөнгийн аудитын байгууллага, Монголбанкны Хяналтын зөвлөлөөс Монголбанкинд өгсөн зөвлөмж, тогтоолын биелэлт, үр дүнд хяналт тавин ажиллахын зэрэгцээ эдгээр байгууллага болон Захирлуудын Зөвлөлийн гишүүдэд танилцуулж, холбогдох шийдвэрийг гаргууллаа.

Дотоод аудитын газар нь тайлант онд “Эрнст энд Янг” хөндлөнгийн аудитын байгууллагаар Монголбанкны 2008 оны санхүүгийн тайланг баталгаажуулахаар аудит хийлгэх ажлыг зохион байгуулж, Монголбанкинд өгсөн зөвлөмжийн дагуу төлөвлөгөө боловсруулан түүний биелэлтэд хяналт тавин мөрөөр нь холбогдох арга хэмжээ авч ажиллав.

3.3. Төлбөр тооцооны системийн хөгжлийн зорилт, түүний хэрэгжилт

Монголбанк нь 2009 онд Монгол Улсын төлбөр тооцооны системийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох, төлбөр тооцооны системийн үйл ажиллагаанд хяналт тавих, найдвартай, шуурхай байдлыг хангахад шаардлагатай дэвшилтэт технологийг нэвтрүүлэх болон бэлэн бус төлбөр тооцооны хэрэглээг нэмэгдүүлэх зорилт тавьж ажиллав.

Энэхүү зорилтын хүрээнд Банк хоорондын их дүнтэй гүйлгээний төлбөр тооцоог бодит цагийн горимд гүйцэтгэх “Банксүлжээ систем”-ийг нэвтрүүлж, холбогдох журам, зааврыг шинээр болон шинэчлэн гаргаж, системийг 2009 оны 5 дугаар сарын 29-ний өдөр нээснээс хойш ямар нэгэн доголдол сааталгүй ажиллаж байна.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2009 оны 8 дугаар сарын 6-ны өдрийн 440 дүгээр тушаалаар батлагдсан “Төлбөрийн картын журам”-д тавигдсан шаардлагыг хангасан

ХААН банкинд VISA, MASTERCARD, CUP (China Union Pay) төлбөрийн карт, Голомт банкинд VISA, MASTERCARD, CUP (China Union Pay), AMEX (American Express)-ийн төлбөрийн картуудыг өөрийн банкны нэрийн өмнөөс гаргах, хүлээн авах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2009 оны 12 дугаар сарын 31-ний өдөр олгосон. Цаашид Монголбанк нь дээрх журмын дагуу төлбөрийн картыг өөрийн банкны нэрийн өмнөөс гаргах, хүлээн авах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг банкуудад олгож, журмын биелэлтэд хяналт тавьснаар төлбөрийн картын бизнесийг банк, санхүүгийн байгууллагад илүү хурдацтайгаар хөгжлүүлэх нөхцлийг бүрдүүлж ажиллах зорилт тавьж байна.

Төлбөрийн картын гүйлгээг банк хооронд 24 цагаар тасралтгүй дамжуулдаг клирингийн үйлчилгээг нэвтрүүлэх зорилгоор түүний эрх зүйн орчинг бүрдүүлж, “Төлбөрийн картын журам”-ыг баталж, ХААН, Худалдаа хөгжлийн банкуудтай картын төлбөр тооцоог Монголбанкны Төлбөр тооцооны төвөөр дамжуулах туршилтыг хийж байна.

Монгол Улсад бэлэн бус төлбөр тооцоог хөгжүүлэх ажлын хүрээнд “Мобайл банк” сэдэвт олон улсын зөвлөгөөнийг 2009 оны 4 дүгээр сард зохион байгууллаа. Зөвлөгөөнөөс гарсан зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төлбөрийн системийн операторын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох журмыг 2010 онд боловсруулан гаргахаар төлөвлөж байна. Уг журам хэрэгжсэнээр төлбөр тооцооны системд хувийн секторын оролцоог бий болгох, төлбөр тооцооны системийн үйлчилгээний хамрах хүрээг өргөжүүлэх, ялангуяа алслагдсан хөдөө орон нутгийн иргэд банк, санхүүгийн үйлчилгээг гар утсаараа авах боломжийг өргөтгөх ач холбогдолтой болно.

Олон улсын төлбөр тооцооны банкнаас гаргасан зөвлөмжийг удирдлага болгон “Монголбанкнаас төлбөр тооцооны системд хяналт тавих бодлогын баримт бичиг”-ийг шинээр боловсруулан гаргалаа. Энэ нь төлбөр тооцооны системд оролцогчдын төлбөр тооцооны найдвартай, тасралтгүй ажиллагааг хангах, түүнд Монголбанкнаас тавих хяналтыг сайжруулах ач холбогдолтой юм.

Монголбанк нь Монгол Улсын төлбөр тооцооны системийг бүхэлд нь тодорхойлсон “Улаан ном” баримт бичгийн төслийг дараах бүтэцтэйгээр боловсруулаад байна. Үүнд:

- Монгол Улсын төлбөр тооцооны системийн бүтэц, зохион байгуулалт;
- Монгол Улсад хэрэглэгддэг төлбөрийн хэрэгслүүдийн талаарх ерөнхий мэдээлэл;
- Банк хоорондын төлбөр тооцооны систем.

Цаашид Монгол Улсын төлбөрийн системийн “Улаан ном”-ыг англи хэл дээр орчуулж, Олон улсын төлбөр тооцооны банктай хамтран гаргаснаар Монгол Улсын төлбөр тооцооны системийн талаарх мэдээллийг олон улсад нээлттэй, ил тод болгох бөгөөд ингэснээр гадаадын хөрөнгө оруулагчдад хөрөнгө оруулалтын таатай нөхцлийг нэмэгдүүлэхэд тустай болно.

Шигтгээ 3. Бодит цагийн төлбөрийн систем

Монгол Улсын Засгийн газар, Олон улсын хөгжлийн ассоциацийн хооронд байгуулсан “Санхүүгийн чадавхийг хөгжүүлэх төсөл”-ийн хүрээнд Монголбанк нь Банк хоорондын их дүнтэй гүйлгээг бодит цагийн горимд 2009 оны 5 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн шилжүүлж, “Банксүлжээ” нэртэй системийг нэвтрүүллээ.

”Банксүлжээ” систем нь түүний оролцогчдоос илгээсэн гүйлгээ бүрийг тухайн цаг мөчид хүлээн авагч банк руу дамжуулан, үр дүнг бодит цагаар тооцож, банкуудад төлбөр тооцооны эрсдэлийг хянах, өөрийн активыг зохистой удирдах боломжийг олгохын зэрэгцээ төлбөрийн бүх төрлийн систем (үнэт цаас, валютын арилжаа, бага дүнтэй төлбөр тооцоо гэх мэт)-ийг холбох үндсэн системийн үүрэг гүйцэтгэх ач холбогдолтой, дэлхийн 90 гаруй оронд ашиглагдаж буй систем учир энэ системийг нэвтрүүлснээр Монгол Улсын төлбөр тооцооны систем хөгжлийнхөө шинэ шатанд гарлаа.

Монголбанк нь тус системээр 2009 оны сүүлийн хагас жилд нийт 459 мянган ширхэг, 8.7 их наяд төгрөгийн их дүнтэй гүйлгээний төлбөр тооцоог гүйцэтгэж, 1.2 сая ширхэг, 156.6 тэрбум төгрөгийн бага дүнтэй гүйлгээний үр дүнгийн тооцоог тус системд хаасан байна.

Банк хоорондын төлбөр тооцоо

Хүснэгт 4. Банк хоорондын гүйлгээний тоо (сая ширхэг)

	2006	2007	2008	2009
Гүйлгээний тоо	3.2	3.7	3.6	4.1
өсөлт %	-	13.7	-1.1	13.3

Банк хоорондын гүйлгээний тоо 2006-2009 онд 3.2 саяас 4.1 сая ширхэг хүртэл, 2009 оны гүйлгээний тоог өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.5 сая ширхэг буюу 13.3 хувиар тус тус өссөн байна.

Төлбөрийн картын хэрэглээ

Монгол Улсад өргөнөөр ашиглаж буй төлбөрийн картын хэрэглээний тоон үзүүлэлтүүд, түүний өөрчлөлт, өсөлтийг тодорхойлох зорилгоор Монголбанк нь “Төлбөрийн картын хэрэглээ”-ний судалгааг хагас жил тутамд нэгтгэн гаргадаг. Энэ судалгааг картын үйлчилгээ үзүүлэгч 12 банкны 2008-2009 оны тоон үзүүлэлтүүдийг хамруулан хийлээ¹¹.

¹¹ Судалгааны тоо баримтууд давхардсан тоогоор тооцоологдсон болно.

Хүснэгт 5. Карт эзэмшигчид, идэвхтэй карт ашиглагчдын тоо (өссөн дүнгээр)

Д/Д	Карт эзэмшигч/идэвхтэй карт ашиглагч	2008	2009	2008
				2009
1	Эзэмшигчдийн тоо	1,182,526	1,885,103	59.4%
2	Идэвхтэй ашиглагчдын тоо*	470,773	476,230	1.2%

* Идэвхтэй карт ашиглагчид нь сард 5-аас доошгүй удаа гүйлгээ хийдэг карт эзэмшигчид юм.

Тус судалгаагаар 2009 онд карт эзэмшигчийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 702.6 мянга буюу 59.4 хувиар, идэвхтэй карт ашиглагчийн тоо 5.5 мянга буюу 1.2 хувиар тус тус өссөн байна.

Хүснэгт 6. Төхөөрөмжийн тоо (өссөн дүнгээр)

Д/Д	Төхөөрөмжүүд	2008 он	2009 он	2009 он
				2008 он
1	ПОС терминал	3,060	3,754	22.7%
2	ПОБ терминал	1,299	1,186	-8.7%
3	АТМ төхөөрөмж	189	292	54.5%
4	Импринтер төхөөрөмж	470	377	-19.8%
	Нийт:	5,018	5,609	11.8%

Төхөөрөмжийн хувьд 2009 онд ПОС терминалын тоо өмнөх оны мөн үеэс 694 ширхэг буюу 22.7 хувь, АТМ төхөөрөмж 103 ширхэг буюу 54.5 хувиар тус тус өссөн боловч ПОБ терминал 113 ширхэг буюу 8.7 хувь, импринтер төхөөрөмж 93 ширхэг буюу 19.8 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 7. ПОС, ПОБ, АТМ төхөөрөмжөөр хийгдсэн гүйлгээний дүн, тоо

Төхөөрөмжөөр хийгдсэн гүйлгээ		2008 он	2009 он	2009 он
				2008 он
ПОС терминалаар хийгдсэн гүйлгээ	дүн /тэрбум төгрөг/	94.0	100.3	6.6%
	тоо /сая ширхэг/	1.8	1.7	-1.6%
ПОБ терминалаар хийгдсэн гүйлгээ	дүн /тэрбум төгрөг/	473.8	453.5	-4.3%
	тоо /сая ширхэг/	4.1	3.2	-21.8%
АТМ төхөөрөмжөөр хийгдсэн гүйлгээ	дүн /тэрбум төгрөг/	641.1	874.6	36.4%
	тоо /сая ширхэг/	9.1	15.2	67.0%

ПОС терминалаар хийгдсэн гүйлгээний дүн 2009 онд 100.3 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.6 хувиар өсч, гүйлгээний тоо 0.1 сая буюу 1.6 хувиар буурсан, ПОБ терминалаар хийгдсэн гүйлгээний дүн 453.5 тэрбум төгрөгт хүрч 4.3 хувиар, гүйлгээний тоо 0.9 сая буюу 21.8 хувиар тус тус буурсан, АТМ төхөөрөмжөөр хийгдсэн гүйлгээний дүн 874.6 тэрбум төгрөгт хүрч 36.4 хувиар, гүйлгээний тоо 6.1 сая буюу 67 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Энэ нь карт эзэмшигчид картаар төлбөр хийхээс илүүтэй картын данснаасаа бэлэн мөнгө авч, бараа үйлчилгээний төлбөрт хэрэглэх сонирхол нэмэгдэж байгааг харуулж байна.

Шигтгээ 4. Төлбөрийн картын клирингийн үйлчилгээг нэвтрүүлэх

Монголбанк төлбөрийн картын клирингийн үйлчилгээг нэвтрүүлэх нь банк, санхүүгийн байгууллагуудад дараах ач холбогдолтой. Үүнд:

- Төлбөрийн картын банк хоорондын төлбөр тооцоог нэгдсэн системээр дамжуулж, боловсруулах боломжтой болсноор програм, техник хангамж, технологи илүү хөгжинө.
- Карт эзэмшигчид дурын ПОС, ПОБ, АТМ төхөөрөмжөөр үйлчлүүлснээр банк, санхүүгийн байгууллагуудын картын бүтээгдэхүүн, үйлчилгээ харилцагчдад илүү түргэн шуурхай, хүртээмжтэй болно.
- Картаар үйлчлэгч байгууллагууд, карт эзэмшигчдийн тоо нэмэгдсэнээр төлбөрийн картын зах зээл өргөжиж, бэлэн бус төлбөр тооцоо нэмэгдэнэ.

3.4. Бэлэн мөнгөний хангалт

Гүйлгээний эрэлт хэрэгцээ, шаардлага болон дэвсгэртийн зохистой бүтцийг хангах зорилгоор 10000 төгрөгийн цаасан дэвсгэртийг чанар, нууцлалын өндөр түвшинд шинээр хэвлүүлж 2009 онд гүйлгээнд гаргав. Орон нутгийн салбар болон банкуудаар дамжуулан зохистой бүтэц бүхий бэлэн мөнгөөр хангах, муудсан мөнгөн дэвсгэртийг татан авах, гүйлгээнд орсон бэлэн мөнгийг татан авч, ялгаж, тоолж цэгцлэх үйл ажиллагааг тогтмол явуулж ирлээ. Банкуудын захиалгаар 630.5 тэрбум төгрөг бэлнээр олгож, банкуудаас тушаасан 742.6 тэрбум төгрөгийг ялган цэгцэлж, тоолж, шалган дахин гүйлгээнд гаргав. Гүйлгээнээс хасагдаж муудсан 47.3 тэрбум төгрөгийн 31.1 сая ширхэг дэвсгэртийг ялгаж зохих хяналтын дор устгав.

3.5. Мэдээллийн технологи

Монголбанкны Мэдээллийн технологийн газар нь мэдээллийн технологийн бодлого чиглэлийг тодорхойлж, дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх, мэдээллийн системийн найдвартай ажиллагааг хангахын төлөө ажиллаж байна. Монгол Улсын банк хоорондын төлбөр тооцоог үнэн зөв, түргэн шуурхай гүйцэтгэх боломжийг бүрдүүлэх зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд бодит цагт банк хоорондын төлбөр тооцоог гүйцэтгэх Банксүлжээ системийг үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүллээ. Монголбанкны үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй байлгаж, олон нийтийг үнэн зөв мэдээллээр тогтмол хангах ажлын хүрээнд Монголбанкны цахим хуудсыг шинэчлэн хийж, найдвартай ажиллагааг дээшлүүлсэн. Банкны салбар дахь мэдээллийн технологийн эрсдэлийг бууруулах зорилтын хүрээнд банкуудад мэдээллийн технологийн аудит хийх бэлтгэл ажилд оролцож, урьдчилсан шалгалтыг гурван банкинд хийсэн.

Монголбанкны мэдээллийн технологитой холбоотой үйл ажиллагааг зохицуулах бодлогын баримт бичгийг боловсруулж, үйл ажиллагаанд ашиглаж эхэлсэн. Банкны салбарын Зээлийн мэдээллийн сангийн шинэ системийг ашиглалтад оруулж, Тайлан бүртгэлийн системийг үйл ажиллагаанд ашиглаж эхлэх бэлтгэл ажлыг хангаад байна. Монголбанкны мэдээллийн системийн найдвартай байдлыг дээшлүүлэх ажлын хүрээнд серверийн өрөөний агааржуулалтын системийг иж бүрэн шинэчлэн тоноглох,

сүлжээний хамгаалалтыг сайжруулах, салбаруудад сүлжээний шинэ технологи нэвтрүүлэх ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Монголбанкны дотоод үйл ажиллагааг шуурхай, боловсронгуй болгох ажлын хүрээнд ашиглагдаж байгаа програм хангамжуудад шаардлагатай засвар өөрчлөлт оруулах, энэ жил шинээр эхлүүлсэн болон өнгөрсөн жилээс боловсруулж эхэлсэн програм хангамжуудыг үргэлжлүүлэн хөгжүүлэх ажлууд хийсэн бөгөөд програм хангамжийн нийт 30 орчим засвар өөрчлөлтийг хийж гүйцэтгэлээ.

3.6. Банкны хууль тогтоомжийн хөгжил

“Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай” хуульд 2009 оны 3 дугаар сарын 6-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулав. Энэ хуулиар баталгаа нь зөвхөн мөнгөн хадгаламж төдийгүй харилцах дансанд нэгэн адил хамаарах болсон, түүнчлэн баталгаанд үл хамаарах мөнгөн хадгаламжийн талаар тусгасан.

“Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай” хуулийг УИХ-аас 2009 оны 7 дугаар сарын 9-ний өдөр батлав. Уг хуулиар үүргийн гүйцэтгэлийг хангах баталгаа болгож үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой эрхийг барьцаалах, ипотекийн гэрээ байгуулах, үүргийн гүйцэтгэлийг хангуулахтай холбогдсон харилцааг зохицуулсан. Энэ хууль батлагдсантай холбогдуулан “Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт орсон болно. УИХ-аас “Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай” хуулийг 2009 оны 7 дугаар сарын 9-ний өдөр батлав. Энэ хуулиар Монгол Улсын нутаг дэвсгэр дээр бараа, ажил, үйлчилгээний үнийг төгрөгөөр илэрхийлж, төлбөр тооцоог төгрөгөөр гүйцэтгэж байх харилцааг зохицуулсан бөгөөд хууль батлагдсантай холбогдуулан “Валютын зохицуулалтын тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулжээ.

УИХ-аас Эрүүгийн хуулийн “Албан тушаалын тухай гэмт хэрэг” гэсэн бүлэгт байсан “Мөнгө угаах” гэсэн 268¹ дугаар зүйлийг хүчингүй болгож, уг зүйлийн агуулгыг олон улсын стандарт шаардлагад нийцүүлэн шинээр найруулан “Аж ахуйн эсрэг гэмт хэрэг” гэсэн бүлэгт шилжүүлж, 166¹ дүгээр зүйлийг Эрүүгийн хуульд нэмж оруулсныг 2009 оны 12 дугаар сарын 24-ний өдөр батлав.

3.7. Дотоод хамтын ажиллагаа

Ипотекийн захын өнөөгийн төлөв байдал

Хэдийгээр барилгын санхүүжилтийн асуудал Төв банкны үндсэн үүрэгт хамаарахгүй ч гэсэн Монголбанк ипотекийн анхдагч болон хоёрдогч зах зээлийг хөгжүүлэхэд өөрийн хувь нэмрээ идэвхтэй оруулсаар ирлээ.

Төв банкнаас ипотекийн зах зээлийн үйл ажиллагааг дэмжин ажиллаж байгаа нь санхүүгийн захын хөгжлийг тэргүүлж ирсэн уламжлалтай холбоотой төдийгүй, санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, дэд бүтцийг бий болгоход нь түлхэц өгөх, улмаар санхүүгийн зуучлалыг гүнзгийрүүлэн эдийн засгийн өсөлтийг тэтгэхэд чиглэгдэж

байгаа билээ. Ингэснээр ипотекийн зээлийн үр өгөөж дээшилж, санхүүжилтийн хоёрдогч зах хөгжих, ипотекаар баталгаажсан үнэт цаасыг олон улсын зах дээр борлуулах боломж бүрдэх болно.

Үл хөдлөх эд хөрөнгийн барьцаагаар баталгаажсан үнэт цаасны хоёрдогч зах зээлийг бий болгох, идэвхжүүлэх үүднээс 2006 оны 9 дүгээр сарын 4-ний өдөр Монголбанк болон банкууд “Орон Сууцны Санхүүгийн Компани”-ийг үүсгэн байгуулах тухай гэрээнд гарын үсэг зурсан бөгөөд мөн оны 10 дугаар сарын 6-ны өдөр уг ХХК-ийн нэрийг “Монголын Ипотекийн Корпораци” (МИК) болгон өөрчилжээ.

2007 оны 7 дугаар сард орон сууцны үнийн индекс тооцохтой холбогдолтой үзэл баримтлал, аргачлал боловсруулах, нэгдсэн арга зүйгээр хангах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Монголбанк орж ажиллав.

Банкууд Азийн хөгжлийн банк, ОССК болон өөрийн эх үүсвэрээр 10-15 жилийн хугацаатай, жилийн 19.8 хувийн жигнэсэн дундаж хүүтэй ипотекийн зээл олгож байгаа бөгөөд тайлант оны эцсийн байдлаар нийт ипотекийн зээлийн өрийн үлдэгдэл оны эхнээс 3.7 хувиар тус тус өссөн байна. Нийт зээлийн 4.1 хувь буюу 9.3 тэрбум төгрөгийн зээл нь хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн ангилалд багтаж байна.

Тайлант оны 2 дугаар хагаст эдийн засгийн уналт тогтворжиж эхэлсэнтэй холбоотойгоор шинээр олгосон ипотекийн зээлийн хэмжээ 3 дугаар улиралд огцом нэмэгдсэн байна. Үүний үр дүнд ипотекийн зээлийн өрийн үлдэгдэл эрчимтэй өссөөр байна.

Хэдийгээр зээлийн өрийн үлдэгдэл өсч байгаа ч хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн хэмжээ сүүлийн 3 сарын дунджаар нийт дүнд 3.95 хувьтай болж өссөн байна. 2009 оны 12 дугаар сард зээлийн эргэн төлөлт зээл олголтоос өндөр гарснаар хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн нийт ипотекийн зээлд эзлэх хувь ялимгүй буурч 4.11 хувьд, дүнгээрээ 9.3 тэрбум төгрөгт хүрсэн нь оны эхнээс 2.9 нэгж хувиар өндөр байна.

Барилгын салбарт олгосон зээлийн төлөв байдал

Банкны салбараас барилгын салбарт олгосон зээлийн нийт дүн 2009 оны 4 дүгээр улирлын байдлаар 383 тэрбум байгаа нь өмнөх улирлаас 2.4 хувиар, оны эхнээс 0.1 хувиар буурсан байна. Эндээс хэвийн зээл дотор 1 хүртэл жилийн хугацаатай зээл 44.1 хувийг, 1-5 жилийн хугацаатай 52.9 хувийг, 5 ба түүнээс дээш жилийн хугацаатай 3.1 хувийг эзэлж байна. Гэвч өнгөрсөн оны 4 дүгээр улирлын эцэст 16.6 хувь байсан хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь энэ оны мөн үед 37.9 хувь, дүнгээрээ 145.1 тэрбум төгрөг болж огцом өсчээ.

Зураг 32-оос харахад, орон сууцны захыг цаашид нийлүүлэлт талаас нь дэмжих боломж хомс байгаа нь тодорхой байна. Чанаргүй зээлийг цаашид нэмэгдүүлэхгүй байхын тулд Засгийн газраас банкуудын муу активыг худалдан авах, эрэлт талыг түлхүү дэмжих нь зүйтэй юм.



Зураг 29
Ипотекийн захын төлөв байдал



Зураг 30
Ипотекийн зээлийн чанар



Зураг 31
Барилгын салбарт олгосон зээлийн чанар

4000 айлын орон сууцны хөтөлбөрт Монголбанкны оролцоо

Барилгын салбарт үүсээд байгаа санхүүгийн хүндрэлийг шийдвэрлэх, банкуудын хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, төрийн албан хаагчид болон иргэдийг урт хугацаатай орон сууцны зээлээр хангах зорилго бүхий 4000 айлын орон сууцны хөтөлбөрийг Монголбанк санхүүжилт талаас нь дэмжиж ажиллах боломжтой гэдгээ илэрхийлээд байна.

Тус хөтөлбөрийн журмыг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Монголбанк эхнээс нь оролцон зээлд хамруулах шалгуур үзүүлэлт, нөхцлийн талаар тооцоо судалгааг танилцуулж байсан билээ. Тухайлбал, Монголбанкны саналаар ипотекийн зээлийн хугацааг 20 жил байхаар журамд тусгаад байна. Ингэснээр зээлдэгчдийн төлбөрийн дарамтыг дорвитой бууруулах үндэс бүрдсэн юм.

Ипотекийн зах зээлийг хөгжүүлэхэд Монголбанкны оролцоо

Тайлант онд Монголбанк МИК-ийг хөрвөх чадвар сайтай санхүүгийн хэрэгсэлтэй болгоход нь дэмжлэг үзүүлэх үүднээс гадаадын мэргэшсэн байгууллагад (IFC, KfW, EBRD г.м.) хандан зөвлөгөө авах, МИК-д хөрөнгө оруулалт хийх, зээл олгуулах, техник туслалцаа авах талаар хамтарч ажиллав.

Монгол улсын Засгийн газар, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын Хөгжлийн бодлогын хамтын ажиллагааны хэлэлцээрийн үр дүнд ХБНГУ-ын Засгийн газраас Монгол улсад хэрэгжүүлэх “Санхүүгийн салбарыг хөхүүлэн дэмжих-Ипотекийн барьцаат зээлийн системийг дэмжих” төслийн хүрээнд 4.8 сая еврогийн хөнгөлөлттэй зээл, 0.5 сая еврогийн буцалтгүй тусламжийг Монголбанкаар дамжуулан МИК-т олгохоор тохиролцон тайлант онд Германы Сэргээн Босголт Хөгжлийн банк, Монгол улсын Засгийн газар зээлийн гэрээнд гарын үсэг зурав.

Ипотекийн хоёрдогч зах зээлийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, МИК-ийн санхүүгийн чадавхийг нэмэгдүүлэх зорилгоор МИК-ийн бонд гаргалтын асуудлыг Монголбанкны Захирлуудын зөвлөл хэлэлцэн, зарчмын хувьд дэмжиж МИК-ийн бондыг Төв банкны репо хэлцлийн суурь хэрэгсэлд оруулан, түүнийг эзэмшиж буй банкнаас репо нөхцлөөр худалдан авах замаар МИК-ийн үйл ажиллагааг дэмжин ажиллалаа. МИК-ийн бондын эрсдэлийн жинг 35 хувиар тооцохоор шийдвэрлэв. Үүний сацуу МИК-ийн бондоор репо хэлцэл хийсэн нөхцөлд эрсдэлийн хөнгөлөлтийг 30 хувиар тооцохоор болсон билээ. Ингэснээр ипотекеэр баталгаажсан үнэт цаасыг Монголбанк Засгийн газрын үнэт цаасны хэмжээнд хүлээн зөвшөөрч буй хэрэг юм. Үүний үр дүнд банкууд, санхүүгийн хөрөнгө оруулагч байгууллагууд тухайн үнэт цаасыг эзэмших сонирхол нэмэгдэж, арилжаа идэвхжих болно.

Монголбанк Ипотекийн анхдагч зах зээлийн үйл ажиллагаа, бичиг хэргийн бүрдүүлбэрийг стандартчилахад гол үүрэг гүйцэтгэв. Монголбанк, МИК болон банкуудаас бүрдсэн ажлын хэсэг хамтран “Ипотекийн зээлийн үйл ажиллагааны журам”-ыг боловсруулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2008 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 446 тоот тушаалаар батлуулсан. Монголбанкны зүгээс уг журамтай холбоотойгоор олон улсын байгууллагуудтай хамтран сургалт, семинар зохион

байгуулсан нь МИК-ийн үйл ажиллагаанд дэмжлэг болсон төдийгүй ХБНГУ-аас Монгол Улсад хэрэгжүүлэх төслийн үйл ажиллагааг богино хугацаанд эхлүүлэх бололцоо олгосон билээ. Мөн ийнхүү нэгдсэн жишгийг бий болгосноор банкуудын зардал буурч, зээлдэгчдийн хувьд чирэгдэл багасан, ипотекийн зээлийн эрсдэл, улмаар хүүг бууруулахад ач холбогдолтой юм.

Ипотекийн захыг дэмжихдээ Монголбанк хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх тал дээр онцгой ач холбогдол өгдөг билээ. Анхдагч захыг хөгжүүлэхэд Монголбанк Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийг УИХ-аар батлуулахад идэвхтэй оролцов. Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн эрх зүйн зохицуулалтыг бий болгох үүднээс Үл хөдлөх хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгт оролцон ажиллаж байна.

Тайлант онд Монголбанк ипотекийн зах зээлийг хөгжүүлэх, хууль эрх зүйн таатай орчинг бий болгох чиглэлээр олон сургалт, семинар, дугуй ширээний ярилцлага, уулзалтыг банк санхүүгийн болон бусад холбогдох төрийн байгууллагуудад хийв. Эдгээрийн нэг нь МИК-тай хамтран “Ипотекийн зээлийн олон улсын аргачлалыг Монголд нэвтрүүлэх нь” сэдэвт сургалтыг банк, ББСБ-ууд болон зарим Төрийн байгууллагуудын дунд зохион байгуулав.

3.8. Гадаад хамтын ажиллагаа

ЭЗХАОУБ, ОУХОБ (МИБ, МБЭС)

Монголбанк нь Эдийн засгийн хамтын ажиллагааны олон улсын банк (ЭЗХАОУБ), Олон улсын хөрөнгө оруулалтын банк (ОУХОБ)-ны үйл ажиллагаанд Монгол Улсыг төлөөлж оролцдогийн хувьд хоёр банкны үйл ажиллагаанд хяналт тавьж, ОУХОБ, ЭЗХАОУБ-ны Зөвлөлийн ээлжит хуралдаанд Монгол Улсын эрх ашигт нийцсэн байх үндсэн зорилтын хүрээнд бодлого боловсруулж байр сууриа илэрхийлж ирлээ. Ийнхүү гадаад зах зээлээс урт хугацаатай, бага хүүтэй эх үүсвэрийг банкуудад байршуулах боломжийг Монголбанк судалж, ЭЗХАОУБанк, ОУХОБанкинд хүсэлт тавьсны үр дүнд Монголын банкуудад 2009 оны эцсийн байдлаар нийт 11.8 сая ам.долларын хадгаламж байршуулж, Монгол Улсын аж ахуйн нэгж, банкуудад нийт 5.7 сая ам.долларын зээл олгосон байна.

Зүүн Өмнөд Азийн Төв банкуудын Холбооны дэргэдэх Сургалт судалгааны төв (SEACEN)

Тайлант онд Зүүн Өмнөд Азийн Төв банкуудын Холбооны дэргэдэх Сургалт судалгааны төв (SEACEN)-ийн хамтын ажиллагааны хүрээнд төлбөрийн тэнцлийн улирлын гүйцэтгэлийг тус байгууллагын цахим мэдээллийн санд оруулж, Монгол улсын хөрөнгийн урсгалын 2009 оны байдал, 2010 оны чиг хандлагын талаарх судалгааны материал болон дээрх цахим хуудсыг сайжруулахтай холбогдсон асуулгын хариуг тус тус хүргүүлж ажиллав.

Койн Инвест Траст компани (Coin Invest Trust company)

Бээжин 2008 олимпын наадамд амжилттай оролцож алт, мөнгөн медаль хүртсэн Монгол Улсын тамирчдыг Эрдэнэсийн сангийн хуулийн дагуу алдаршуулах зорилгоор тамирчдын нэр, зураг бүхий алт мөнгөн зоосыг Монголбанк олон улсын нэр хүнд бүхий Койн инвест траст компаниар цутгуулж, зоосуудыг хүлээн авснаар Монгол Улсын Эрдэнэсийн санг баяжуулав.

3.9. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх талаар дараах арга ажлыг хийж гүйцэтгэв.

Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар 2009 онд батлагдсан банкинд хяналт шалгалт хийх журмыг 13 банкинд газар дээрх хяналт шалгалт хийж илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авлаа. Банкнаас бусад санхүүгийн байгууллагад зориулсан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс сэргийлэх, харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг СМА-нд мэдээлэх журмыг Санхүүгийн зохицуулах хороогоор батлуулж хэрэгжүүлэх ажлыг эхэлж байна.

Эрүүгийн хуулийн мөнгө угаах тухай зүйлийг шинэчлэн УИХ-аар батлуулж энэ төрлийн гэмт хэргийн хамрах хүрээг өргөтгөн олон улсын стандартад нийцүүлэхэд СМА идэвхитэй оролцов.

СМА-ны үйл ажиллагааг төгөлдөршүүлэх хүрээнд 2009 онд Цагдаагийн Ерөнхий Газрын Эрүүгийн цагдаагийн газар болон Авилгатай тэмцэх газартай Хамтран ажиллах санамж бичиг байгуулан мэдээлэл солилцох чиглэлээр хамтран ажиллаж байна.

СМА нь олон улсын түвшинд мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэж буй Монгол Улсын үйл ажиллагааг таниулах, сурталчлах ажиллагааг явуулсны үр дүнд 2009 онд дэлхийн СМА-дын нэгдсэн байгууллага “Эгмонт бүлэг”-т гишүүнээр элсэн, Афганистан Улс, БНХАУ-ын СМА-дтай хамтран ажиллах болон мэдээлэл солилцох Санамж бичгийг тус тус байгуулан гадаад харилцаагаа өргөжүүлж байна.

3.10. Банкны сургалтын төвийн үйл ажиллагаа

Банкны сургалтын төв нь 2009 онд 25 сэдвээр 31 удаагийн сургалт семинарт нийт 425 хүн хамруулж, 785.5 хүн/өдрийн сургалт зохион байгуулав. Хөдөө орон нутагт, тухайлбал, Дархан-Уул, Хөвсгөл, Завхан аймгуудад 5 аймгийн 64 банкны ажилтнуудыг оролцуулсан сургалт зохион байгуулав.

4.1. Бодит эдийн засгийн хөгжил

Үндэсний статистикийн хороо (ҮСХ)-ны мэдээгээр дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) 2009 онд урьдчилсан байдлаар жилийн 1.6 хувиар буурчээ. Эдийн засгийн өсөлт 2008 онд 8.9 хувь байсан бол тайлант онд 10.5 нэгжээр буурч -1.6 хувь болсон байна. Уул уурхай, олборлох үйлдвэрийн салбар болон нийгэм бие хүнд үзүүлэх бусад салбарын өсөлт нэмэгдсэн хэдий ч бусад бүх салбарын өсөлт саарсан байна. Үүнд хөдөө аж ахуйн салбарын өсөлт 4.3 нэгжээр, бөөний болон жижиглэн худалдааны салбарын өсөлт 42.8 нэгжээр, тээвэр, агуулахын аж ахуйн салбарын өсөлт 8.4 нэгжээр саарсан нь ихээр нөлөөлжээ.

Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуйн салбар (ДНБ-ий 21.2%) өмнөх оныхтой харьцуулснаар 1.5 хувь, уул уурхай, олборлох үйлдвэр (ДНБ-ий 22.5%) 3.7 хувиар, тээвэр, агуулахын аж ахуй, холбоо (ДНБ-ий 11.2%) 12.1 хувиар, үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн бусад үйл ажиллагаа (ДНБ-ий 9.1%) 2.8 хувиар өссөн нь эдийн засгийн өсөлтөнд голлох нөлөө үзүүлсэн. Харин бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн засварлах бараа үйлчилгээний салбар (ДНБ-ий 12.2%) өмнөх оныхтой харьцуулахад 26.6 хувиар, боловсруулах үйлдвэр (ДНБ-ий 5.9%) 11.1 хувиар, санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа (ДНБ-ий 3.0%) 20.4 хувиар, барилгын салбар (ДНБ-ий 1.2%) 48.8 хувиар буурч эдийн засгийн өсөлтийг бууруулахад голчлон нөлөөлжээ.

Тайлант онд нийгэм, бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээний салбар 16.3 хувиар, тээвэр, агуулахын аж ахуй, холбооны салбар 12.1 хувиар өссөн нь хамгийн өндөр үзүүлэлт бөгөөд өмнөх оныхтой харьцуулахад нийгэм, бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээний салбарын өсөлт 1.0 нэгжээр, тээвэр, агуулахын аж ахуй, холбооны салбарын өсөлтийн хурд 8.4 нэгжээр буурчээ. Дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын нөлөөгөөр манай улсын эдийн засгийн үйл ажиллагааны ихэнх салбарын өсөлт буурснаар илэрч байна. Тухайлбал санхүүгийн салбарын шууд бус үйлчилгээний салбарын өсөлт 57.6 нэгжээр, бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээний салбар 42.8, санхүүгийн зуучлалын салбар 40.3, барилгын салбар 36.0, зочид буудал, зоогийн газрынх 29.9, үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн бусад үйл ажиллагааны салбарын өсөлт 16.8 нэгжээр тус тус буурсан байна.

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл (2005 оны үнээр) 3.3 хувиар буурч, өмнөх онтой харьцуулснаар өсөлт нь 5.9 нэгжээр буурсан байна. Үүнд боловсруулах үйлдвэрийн салбарын өсөлт багассан нь илүүтэй нөлөөлсөн бөгөөд түүн дотроо төмрийн үйлдвэрлэл, нэхмэлийн үйлдвэрлэл, хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт болон төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэлийн салбарууд нэлээд буурсан байна.

Хөдөө аж ахуйн салбарын өсөлт 1.5 хувьд хүрсэн нь өмнөх оныхоос 4.3 нэгжээр, 2007 оныхоос 14.3 нэгжээр багассан үзүүлэлт байна. Энэ нь малын тоо толгой 2008 онд 3.0 сая толгой буюу 7.5 хувиар өсч байсан бол 2009 онд 735.4 мянган толгой буюу 1.7 хувиар өсч өсөлт нь саарсантай холбоотой. Харин тайлант онд нэг га талбайгаас 15.5 центнер үр тариа, 111.8 центнер төмс хураасан нь 2008 оныхоос харгалзан 1.7, 2.2 центнерээр тус тус өссөн байна. Хураасан үр тариа 178.8 мянган тонн буюу 84.0 хувь, төмс 16.4 мянган тонн буюу 12.2 хувиар нэмэгдсэн бол хүнсний ногоо 0.6 мянган тонн буюу 0.7 хувиар буурсан байна. 2008 оноос газар тариаланг хөгжүүлэх талаар Атрын

Хүснэгт 8. Дотоодын нийт бүтээгдэхүүн (2005 оны зэрэгцүүлэх үнээр, сая төгрөг)

	2005	2006	2007	2008	2009*
ДНБ	2779578.2	3017425.8	3325892.6	3622670.5	3564278.1
<i>өсөлт (%)</i>	7.3%	8.6%	10.2%	8.9%	-1.6%
Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй, загасны аж ахуй	608335.1	654148.2	757493.6	801203.2	813519.8
<i>өсөлт (%)</i>	11.1%	7.5%	15.8%	5.8%	1.5%
Уул уурхай, олборлох үйлдвэр	608208.9	646310.2	665021.2	645922.7	669827.7
<i>өсөлт (%)</i>	10.9%	6.3%	2.9%	-2.9%	3.7%
Боловсруулах үйлдвэр	101962.9	115585.3	149055.5	154660.4	137525.9
<i>өсөлт (%)</i>	-19.2%	13.4%	29.0%	3.8%	-11.1%
Цахилгаан, дулааны үйлдвэрлэл, усан хангамж	80021.1	83634.8	89875.6	98180.9	101866.4
<i>өсөлт (%)</i>	0.9%	4.5%	7.5%	9.2%	3.8%
Барилга	58835.2	61827.5	67065.5	58450.5	29926.9
<i>өсөлт (%)</i>	15.9%	5.1%	8.5%	-12.8%	-48.8%
Бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ	226961.1	261759.7	279352.9	324726.6	238356.7
<i>өсөлт (%)</i>	2.9%	15.3%	6.7%	16.2%	-26.6%
Зочид буудал, зоогийн газар	19135	21022.1	24391.9	26065.8	20082.4
<i>өсөлт (%)</i>	17.1%	9.9%	16.0%	6.9%	-23.0%
Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	309100	346429.2	438597.9	528554.3	592300
<i>өсөлт (%)</i>	22.9%	12.1%	26.6%	20.5%	12.1%
Санхүүгийн зуучлал	99966.8	96776.1	125955.9	150977.3	120236.5
<i>өсөлт (%)</i>	14.7%	-3.2%	30.2%	19.9%	-20.4%
Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн бусад үйл ажиллагаа	217120.3	228863.4	224947.9	269100.8	276741.2
<i>өсөлт (%)</i>	8.8%	5.4%	-1.7%	19.6%	2.8%
Төрийн удирдлага, баглан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын үйл ажиллагаа	66847.2	67154.5	70205.1	73141.2	76200.1
<i>өсөлт (%)</i>	3.4%	0.5%	4.5%	4.2%	4.2%
Боловсролын салбарын үйл ажиллагаа	84915.7	88685.5	90527.9	97278.1	98909.3
<i>өсөлт (%)</i>	-5.0%	4.4%	2.1%	7.5%	1.7%
Эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	37966.5	41515.4	45953	48628.4	50249.5
<i>өсөлт (%)</i>	3.0%	9.3%	10.7%	5.8%	3.3%
Нийгэм, бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ	28323	30027.1	32336.3	37283	43362.4
<i>өсөлт (%)</i>	4.0%	6.0%	7.7%	15.3%	16.3%
Санхүүгийн байгууллагын шууд бус үйлчилгээ	-79858.5	-109673.2	-144416.9	-171656.9	-105199.9
<i>өсөлт (%)</i>	15.0%	37.3%	31.7%	18.9%	-38.7%
Бараа, үйлчилгээний цэвэр татвар	311737.9	383359.9	409529.3	480154.2	400373.1
<i>өсөлт (%)</i>	1.5%	23.0%	6.8%	17.2%	-16.6%

гурав дахь аяныг хэрэгжүүлж эхэлсний үр дүнд хураасан ургацын хэмжээ эрс нэмэгдсэн байна. Мөн импортоор оруулж ирсэн хөдөө аж ахуйн зориулалттай шинэ трактор, комбайн, машин механизм, гурилын үйлдвэрийн болон усалгааны тоног төхөөрөмж, бордоо, ургамал хамгааллын бодисыг 2011 оны 12 дугаар сарын 31-ийг хүртэл гааль болон нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ)-аас чөлөөлсөн байгаа. Мөн “Атрын III дахь аян” тариалангийн хөгжлийн Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хэд хэдэн аймгуудад төсвийн зээл хэлбэрээр санхүүжилт олгожээ.

Монголбанкнаас авч хэрэгжүүлж буй мөнгөний бодлогын арга хэмжээ болон дэлхийн эдийн засгийн орчны нөлөөллийн дүнд инфляцийн түвшин 2009 оны эхний 9 сард огцом буурч эхэлсэн. ҮСХ-ны мэдээгээр тайлант онд жилийн инфляци улсын хэмжээнд 4.2 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд 1.9 хувьд хүрлээ. Бараа бүтээгдэхүүний ангилал буюу бүлгээр авч үзвэл улсын хэмжээнд согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнийн индекс 20.21 хувиар, бусад бараа үйлчилгээний бүлгийн үнийн индекс 14.06 хувиар, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны бүлгийн үнийн индекс 11.13 хувиар, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнийн индекс 10.86 хувиар өссөн нь хамгийн их өсөлттэй байсан байна. Харин хэрэглээний барааны үнийн индекс (ХҮИ)-д ихээхэн хувийн жин эзэлдэг хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн индекс 0.48 хувиар, орон сууц, ус, түлш, цахилгааны бүлгийн индекс 0.66 хувиар, тээврийн бүлгийн индекс 1.34 хувиар өссөн нь инфляцийн түвшин бага гарахад голчлон нөлөөлсөн байна.

ҮСХ-ны мэдээгээр тайлант онд урьдчилсан гүйцэтгэлээр улсын нэгдсэн төсвийн орлого, тусламжийн нийт дүн 1993.0 тэрбум төгрөг, нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 2321.6 тэрбум төгрөг болж, нийт тэнцэл 328.6 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна. Төсвийн алдагдал өмнөх оныхоос 32.2 тэрбум төгрөгөөр нэмэгдэхэд төсвийн орлогын бууралт зардлынхаас 2.3 нэгжээр өндөр байгаа нь нөлөөлжээ. Төсвийн урсгал орлого 1965.5 тэрбум төгрөг, урсгал зардал 1792.1 тэрбум төгрөг болж, урсгал тэнцэл 173.4 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна. Татварын нийт орлого өмнөх оныхоос 275.6 тэрбум төгрөг буюу 14.6 хувиар буурахад зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын орлого 198.3 тэрбум төгрөг буюу 51.1 хувь, аж ахуйн нэгжийн орлогын албан татварынх 47.9 тэрбум төгрөг буюу 18.9 хувь, нэмэгдсэн өртгийн албан татварынх 42.2 тэрбум төгрөг буюу 11.5 хувь, онцгой албан татварынх 11.7 тэрбум төгрөг буюу 6.6 хувиар буурсан нь голлон нөлөөлжээ. Татварын бус орлого өмнөх оныхоос 90.1 тэрбум төгрөг буюу 34.6 хувиар өсөхөд хувьцааны ногдол ашгийн орлого 75.5 тэрбум төгрөг буюу 3.3 дахин, навигацийн орлого 11.5 тэрбум төг буюу 60.1 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна. Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 2009 оны урьдчилсан гүйцэтгэлээр 2321.6 тэрбум төгрөг болж, өмнөх оныхоос 145.2 тэрбум төгрөг буюу 5.9 хувиар буурчээ. Үүнд цалин, хөлсний зардал 34.4 тэрбум төгрөг буюу 6.3 хувь, татаас, шилжүүлэг 107.2 тэрбум төгрөг буюу 15.6 хувиар өссөн хэдий ч бараа, үйлчилгээний бусад зардал 119.8 тэрбум төгрөг буюу 23.5 хувь, хөрөнгийн зардал 166.5 тэрбум төгрөг буюу 26.7 хувиар буурсан нь голлон нөлөөлжээ.

ҮСХ-ны мэдээгээр манай орны нийт экспорт тайлант онд өмнөх оныхоос 24.9 хувиар буурч 1902.6 сая ам.доллар, нийт импорт 34.3 хувиар буурч 2131.3 сая ам.доллар болжээ. Гадаад худалдааны тэнцэл 228.7 сая ам.долларын алдагдалтай гарсан нь 2008 онтой харьцуулахад 481.4 сая ам.доллар буюу 3.1 дахин багасчээ. Эрдэс бүтээгдэхүүний экспорт (нийт экспортын 65.4%) 18.6 хувиар буурсан нь нийт экспортын бууралтанд голлох нөлөө үзүүлжээ. Мөн үнэт, хагас үнэт чулуу, металл гоёлын зүйлсийн экспорт

(нийт эксортын 17.7%) 44.0 хувиар, нэхмэл, нэхмэл бүтээгдэхүүнийх (нийт эксортын 10.0%) 15.2 хувиар буурсан байна. Эрдэс бүтээгдэхүүний импорт (нийт импортын 26.6%) 41.2 хувиар, машин, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийн импорт (нийт импортын 18.7%) 30.2 хувиар тус тус буурчээ.

Аж үйлдвэр

Үндэсний статистикийн хорооны мэдээгээр 2009 онд аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 65.9 хувийг уул уурхай, олборлох аж үйлдвэр, 24.7 хувийг боловсруулах аж үйлдвэр, 9.4 хувийг цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж тус бүр бүрдүүлжээ. Уул уурхай, олборлох аж үйлдвэрт хамгийн өндөр хувь буюу 73.7 хувийг металлын хүдэр олборлолт, боловсруулах аж үйлдвэрт 45.3 хувийг хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, 25.4 хувийг нэхмэлийн үйлдвэрлэл, 10.6 хувийг төмрийн үйлдвэрлэл, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжид 93.1 хувийг цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл тус тус эзэлж байв.

Тайлант онд аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл өмнөх оныхоос 2005 оны зэрэгцүүлэх үнээр 3.3 хувиар буурсан байхад салбараар нь авч үзвэл уул уурхай, олборлох аж үйлдвэрийн үйлдвэрлэл 2.2 хувь, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж 1.8 хувиар тус бүр нэмэгдэж, харин боловсруулах аж үйлдвэрлэл 14.2 хувиар буурсан байна. Дэд салбаруудыг авч үзвэл, хүнсний бүтээгдэхүүн, ундааны үйлдвэрлэл 41.2 тэрбум төгрөг буюу 22.1 хувь, цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл 4.0 тэрбум төгрөг буюу 2.2 хувиар тус тус өсчээ. Харин нэхмэлийн үйлдвэрлэл 7.1 тэрбум төгрөг буюу 5.3 хувь, төмрийн үйлдвэрлэл 94.4 тэрбум төгрөг буюу 64.1 хувь, металлын хүдэр олборлолт 48.8 тэрбум төгрөг буюу 6.2 хувиар буурсан байна.

Тайлант онд 3099.8 тэрбум төгрөгийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулсан нь өмнөх оныхоос 5.8 хувиар илүү байна. Үүнээс 1882.2 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүнийг гадаадын зах зээлд нийлүүлжээ. Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн борлуулалт нийт борлуулалтын дүнд 65.9 хувь, боловсруулах аж үйлдвэрийнх 24.7 хувь, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн борлуулалт 9.4 хувийг тус тус эзэлж байна. Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн борлуулалтын 83.6 хувь, боловсруулах аж үйлдвэрийн 22.8 хувь нь гадаадын зах зээлд ногдож байна. Үүнд газрын тос олборлолтын салбарт 100 хувь, ашигт малтмал олборлолтын 86.6 хувь, металлын хүдэр олборлолтын бүтээгдэхүүний 83.6 хувь, нэхмэлийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний 75.9 хувь, төмрийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний 47.7 хувийг тус бүр гадаадын зах зээлд борлуулжээ.

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 54.8 хувийг Улаанбаатар хотод, 28.8 хувийг Орхон аймагт борлуулсан байна.

Хөдөө аж ахуй

Тайлант онд 44.0 сая мал, үүнд 19.6 сая ямаа, 19.3 сая хонь, 2.6 сая үхэр, 2.2 сая адуу, 277.1 мянган тэмээ тоологдов. Малын тоо 2008 оныхоос 735.4 мянга буюу 1.7 хувиар

өсөв. Тус өсөлтийг малын төрлөөр нь авч үзвэл хонь 912.4 мянга, үхэр 95.9 мянга, тэмээ 10.6 мянган, адуу 34.4 мянган толгойгоор тус тус өсч, харин ямаа 317.9 мянган толгойгоор хорогдсон байна. Нийт мал сүрэгт ямаа 44.6 хувь, хонь 43.8 хувь, үхэр 5.9 хувь, адуу 5.0 хувь, тэмээ 0.6 хувийг тус тус эзэлж байна.

Хөвсгөл (3924.5 мянга), Өвөрхангай (3620.2 мянга), Архангай (3619.1 мянга), Төв (3464.2 мянга), Завхан (2827.6 мянга) зэрэг аймгууд малын тоогоороо тэргүүлж байна.

Малтай нэг өрхөд дунджаар 192 толгой мал, үүнд 1 тэмээ, 10 адуу, 11 үхэр, 84 хонь, 86 ямаа ногдож байна.

Тайлант онд 15.3 сая эх мал буюу эх малын 82.7 хувь төллөжээ. Төллөлтийн хувь өмнөх оныхоос 0.4 нэгжээр багассан байна. Нийт 13.8 сая төл бойжсон бөгөөд бойжилтын хувь 1.6 нэгжээр буурч, 89.4 хувь болжээ.

Тариалсан нийт талбай 282.2 мянган га болж, өмнөх оноос 89.7 мянган га буюу 46.6 хувиар ихэсч, үүнээс үр тариа тариалсан талбайн хэмжээ 98.4 мянган га буюу 63.9 хувиар (үүнээс буудайны талбай 98.9 мянган га буюу 65.9 хувиар), төмс тариалсан талбай 0.8 мянган га буюу 7.2 хувь, хүнсний ногоон талбай 0.1 мянган га буюу 1.7 хувиар тус тус нэмэгдсэн байна. Харин тэжээлийн ургамлын талбай 2.2 мянган га буюу 40.4 хувиар багассан байна.

Тайлант онд 391.7 мянган тонн үр тариа, 388.1 мянган тонн буудай, 78.0 мянган тонн хүнсний ногоо, 151.2 мянган тонн төмс хурааж, 893.4 мянган тонн өвс хадлан болон 23.1 мянган тонн гар тэжээл бэлтгэсэн нь 2008 оныхоос үр тариа 84.0 хувь, буудай 85.0 хувь, төмс 12.2 хувиар тус тус өсч, хүнсний ногоо 0.7 хувь, өвс хадлан 13.3 хувь, гар тэжээл 32.8 хувиар тус тус багасчээ.

Нэг га талбайгаас хураасан үр тариа дунджаар 15.5 центнер болсон нь өмнөх оныхоос 1.7 центнер буюу 12.3 хувиар их байна. Нэг га талбайгаас авсан төмс 2.2 центнер буюу 0.2 хувиар өсч, 111.8 центнер болжээ.

Барилга

Урьдчилсан гүйцэтгэлээр барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 2009 онд 279.4 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оныхоос 228.8 тэрбум төгрөг буюу 54.9 хувиар бага байна. Нийт барилга угсралт, их засварын ажлын 89.7 хувийг дотоодын барилгын байгууллага хийж гүйцэтгэв.

Нийт барилга угсралт, их засварын ажлын 35.9 хувийг орон сууцны барилга, 24.6 хувийг орон сууцны бус барилга (үйлдвэрийн, худалдаа үйлчилгээний, эмнэлэг, сургууль, соёлын г.м.), 21.7 хувийг инженерийн барилга байгууламж, 12.6 хувийг их засварын ажил тус бүр эзэлж байна. Мөн дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн нийт барилга угсралт, их засварын ажлын 55.3 хувь нь Улаанбаатар хотод ногдож байна.

Тээвэр, холбоо

Тайлант онд тээврийн бүх төрлийн хэрэгслээр 24.7 сая тонн ачаа, давхардсан тоогоор 232.4 сая зорчигч тээвэрлэсэн бөгөөд 2008 оныхоос ачаа тээвэрлэлт 825.3 мянган тонн буюу 3.4 хувь, зорчигч тээвэрлэлт 0.8 сая хүн буюу 0.03 хувиар тус тус өссөн байна.

Тээврийн салбарын нийт орлого 463.6 тэрбум төгрөгт хүрч өмнөх оныхоос 44.4 тэрбум төгрөг буюу 10.6 хувиар нэмэгджээ. Авто тээврийн орлого 28.4 тэрбум төгрөг буюу 28.4 хувь, төмөр замын тээврийн орлого 21.5 тэрбум төгрөг буюу 10.4 хувиар тус тус өссөн бол усан замын тээврийн орлого 2 дахин, агаарын тээврийн орлого 4.7 хувиар буурсан байна.

Авто тээврээр тээсэн ачаа өмнөх оныхтой харьцуулснаар 14.0 хувиар өсч 10.6 сая тонн, зорчигч тээвэрлэлт 0.09 хувиар өсч 229.0 сая зорчигч болов.

Төмөр замын тээврээр тээсэн ачаа 14.1 сая тонн болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 3.4 хувиар буурсан байна. Мөн зорчигч тээвэрлэлт 3.1 сая хүн болж буюу 29.5 хувиар багасчээ.

Агаарын тээврийн ачаа тээвэрлэлт 26.9 хувь, зорчигч тээвэрлэлт 25.0 хувиар тус тус буурчээ.

Авто техникийн улсын үзлэг, тооллогын дүнгээр 2009 онд 224.0 мянган тээврийн хэрэгсэл байгаагаас 153.9 мянган ширхэг буюу 68.7 хувь нь суудлын машин байна. Суудлын машины 65.0 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна.

Шуудан холбооны нийт орлого 362.8 тэрбум төгрөгт хүрч жилийн хугацаанд 19.4 тэрбум төгрөг буюу 5.7 хувиар өсөв. Үүнээс хүн амаас орсон орлого 3.9 хувиар өсч, нийт орлогын 85.4 хувийг бүрдүүлжээ. Үүрэн телефон холбооны орлого 10.7 тэрбум төгрөг буюу 3.8 хувиар өссөн байна.

Тайлант онд үүрэн телефон эзэмшигчдийн тоо 462.8 мянган хүн буюу 26.5 хувиар өсч 2.2 саяд хүрсэн байна. Утасгүй телефоны тоо 10.0 мянга буюу 29.6 хувиар өсч 45.5 мянган ширхэг, суурин телефоны цэг 10.6 мянган цэг буюу 7.0 хувиар буурч 141.0 мянга болжээ. 2009 оны эцсийн байдлаар бүх сум үүрэн телефоны сүлжээнд холбогдсон байна.

Хөдөлмөрийн бүтээмж

ҮСХ-ны мэдээгээр тайлант оны эцэст аж үйлдвэрийн салбарын хөдөлмөрийн бүтээмж өмнөх оныхоос 327.0 мянган төгрөгөөр нэмэгдэж 34.8 сая төгрөгт хүрсэн байна. Хөдөлмөрийн бүтээмжийг тооцохдоо нэмэгдсэн өртгийн хэмжээг жилийн ажиллагчдын дундаж тоонд хувааж тодорхойлдог. Аж үйлдвэрийн салбаруудаас хамгийн өндөр хөдөлмөрийн бүтээмжтэй уул уурхайн салбарын хөдөлмөрийн бүтээмж 71.6 сая төгрөг бөгөөд энэ дотроо газрын тос, хий олборлох үйлдвэрийн хөдөлмөрийн бүтээмж өмнөх оныхоос 36.4 сая төгрөг буюу 16.5 хувиар нэмэгдэж 256.4 сая төгрөг болсон байна. Харин боловсруулах аж үйлдвэрийн хөдөлмөрийн бүтээмж өмнөх оныхоос 10.2 хувиар буурч 23.6 сая төгрөгт хүрчээ. Мөн, цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан

хангамжийн хөдөлмөрийн бүтээмж 2008 оны жилийн эцсийнхээс 1.8 хувиар нэмэгдэж 15.0 сая төгрөг болсон байна.

Ажил эрхлэлт


Монгол улсын хүн амын тоо 2009 онд урьдчилсан гүйцэтгэлээр 2736.8 мянга болж 2008 оныхоос 53.2 мянган хүн буюу 1.98 хувиар өссөн бөгөөд энэ нь 1990 оноос хойш гарч байгаа хамгийн өндөр үзүүлэлт юм. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 2009 оны эцэст 38.0 мянга болж, 2008 оны жилийн эцсийнхээс 27.7 хувиар буюу 8.3 мянган хүнээр өсчээ. Улсын хэмжээгээр 21.0 мянган эмэгтэй ажилгүй гэж бүртгүүлсэн нь нийт бүртгэлтэй ажилгүйчүүдийн 55.3 хувийг эзэлж байна.

Тайлант онд 51.7 мянган хүн ажилд зуучлуулж орсон нь 2008 онтой харьцуулахад 6.7 хувиар буурсан байна. Ажилд орсон хүмүүсийн 13.8 хувь нь төрийн өмчит үйлдвэрийн газар, төсөвт байгууллагад, 86.2 хувь нь компани, хоршоо, бусад байгууллагад оржээ.

ҮСХ-ны мэдээнээс үзэхэд 2009 оны жилийн эцсийн байдлаар нийт бүртгэлтэй ажилгүйчүүдийн дунд 25-34 насны хүмүүс хамгийн их жинг буюу 32.7 хувийг эзэлж байна.

Цалин

ҮСХ-ны мэдээлж байгаагаар аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын 2009 оны 4-р улирлын сарын дундаж цалин 308.1 мянган төгрөгт хүрч, 2008 оныхоос 17.0 мянган төгрөг буюу 5.8 хувиар нэмэгдсэн байна.



Зураг 32

Сарын дундаж цалин, жил бүрийн 4-р улирлын байдлаар

Эрэгтэйчүүдийн сарын дундаж цалин 2009 оны эцсийн байдлаар 332.7 мянган төгрөг байгаа нь эмэгтэйчүүдийнхээс 48.2 мянган төгрөг буюу 16.9 хувиар илүү байна. Харин дундаж цалинг ажил мэргэжлийн ангиллаар авч үзэхэд хууль тогтоогч, төрийн ба төрийн бус байгууллагын удирдах ажилтан, менежер, машин тоног төхөөрөмжийн операторч, угсрагч, мэргэжилтэн болон инженер техникийн ажилтнуудын цалин

улсын дунджаас 13.7-202.5 мянган төгрөгөөр илүү, харин бусад ажил мэргэжлийн ажиллагчдын сарын дундаж цалин улсын дунджаас 44.7-88.7 мянган төгрөгөөр бага байна. Ажил мэргэжлийн хувьд үйлчилгээний ажилчдаас бусад бүх мэргэжлээр эрэгтэй ажиллагчдын цалин эмэгтэйчүүдийнхээс өндөр байна.

Аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалинг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзэхэд ажиллагчдын дундаж цалин санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагааны салбарт 621.1 мянган төгрөг, уул уурхайн олборлох аж үйлдвэрт 402.9 мянган төгрөг, төрийн удирдлага, баглан хамгаалах, нийгмийн даатгалын салбарт 350.1 мянган төгрөг, боловсролын салбарт 296.2 мянган төгрөг, эрүүл мэнд, нийгмийн халамжийн салбарт 292.8 мянган төгрөг, боловсруулах аж үйлдвэрийн салбарт 277.7 мянган төгрөг байна.

Шигтгээ 5. Дэлхийн санхүү эдийн засгийн тойм

Дэлхийн эдийн засгийн уналтын дараа төрийн өргөн хүрээний оролцоогоор эрэлтийг дэмжиж, санхүүгийн зах зээл дээрх тодорхой бус байдал болон салбарын эрсдэлийг бууруулснаар эдийн засгийн өсөлт эргээд эерэг болж байна. Төв банкууд мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлж, зээл олголтыг дэмжихийн тулд зээлийн хүүг их хэмжээгээр бууруулах болон уламжлалт бус бодлогын арга хэрэгслүүдийг хэрэгжүүлж байсан бол Засгийн газрууд чухал ач холбогдолтой төсвийн дэмжлэгийн программуудыг гаргаж байсан. Эдгээр бодлогын арга хэмжээнүүд нь санхүүгийн зах зээл дээрх тодорхой бус байдлыг бууруулж, санхүүгийн нөхцлийг сайжруулахад дэм болж байв. Гэсэн хэдий ч санхүүгийн салбар эмзэг хэвээр, ажилгүйдлийн түвшин өндөр байгаа үед хуримтлалыг нэмэгдүүлэх нь цаг хугацаа их шаардах тул дэлхийн эдийн засгийн сэргэлт удаашрах төлөвтэй байна. Эдийн засгийн өсөлт нь батжиж тогтворжтол макро эдийн засгийг дэмжих, санхүүгийн секторын эрүүл байдлыг сэргээх бодлого хамгийн чухал асуудал болоод байна. Хэдий тийм боловч, бодлого боловсруулагчид төрийн оролцоог дэс дараатай багасгаж эхлэхэд бэлтгэх шаардлагатай байна.

Дэлхийн эдийн засгийн өсөлт 2009 онд 1 орчим хувиар буурах бол 2010 онд 3 орчим хувиар өсөх төлөвтэй байгаа нь хямралын өмнөх үеийнхээс бага өсөлт юм. 2010 онд хөгжингүй орнуудын эдийн засгийн өсөлт сул хэвээр байж, ажилгүйдэл өсөх төлөвтэй байна. Хөгжингүй орнуудын эдийн засгийн өсөлт 2009 онд -3.5, харин 2010 онд 1.25 хувь байх таамаглалыг эдийн засагчид дэвшүүллээ. Харин хөгжиж буй улс орнуудын эдийн засгийн өсөлт 2009 онд 1.75 хувь, 2010 онд 5 хувьд хүрэх төлөвтэй байна. Энэхүү сэргэлт нь Хятад, Энэтхэг болон Азийн хөгжиж буй зарим орнуудын өсөлт дээр тулгуурлах болно.

2010 оноос цааш: Дэлхийн эдийн засгийг дахин тэнцвэржүүлэх нь

Эдийн засгийн тогтвортой, бодит өсөлт дунд хугацаанд бий болох эсэх нь хямралаас үүдэн бий болсон нийлүүлэлтийн уналтыг зогсоож, дэлхийн нийт эрэлтэд үүссэн тэнцвэргүй байдлыг тэнцвэржүүлэх ямар арга замыг сонгож эрхэн хэрэгжүүлэхээс голлон шалтгаалж байна.

Буурсан боломжит өсөлт

Хөрөнгө оруулалт, бүтээмжийн тогтвортой өсөлтийг бий болгохын тулд санхүүгийн байгууллагуудад бүтцийн өөрчлөлт хийж, санхүүгийн зуучлалыг сайжруулж, зах зээлийг эрүүлжүүлэх шаардлага тулгарч байна. Үүний хажуугаар ажил эрхлэлт, нийгмийн халамжийн бүтцийг ч өөрчлөх хэрэгтэй юм.

Эдийн засгийн эрэлтийн талыг тэнцвэржүүлэх

Нийлүүлэлтийн талын өсөлтийг дэмжих үүднээс дэлхийн нийт эрэлтийн хандлагад ч өөрчлөлт оруулах нь чухал юм. Хямралын өмнө маш олон улс орнууд экспортод тулгуурласан эдийн засгийн өсөлтийн бодлогыг баримталж, урсгал дансны илүүдлийг чухалчилж байсан билээ. Харин эдгээр орнууд дотоодын эрэлт болон импортод тулгуурлан эдийн засгаа өсгөх арга замыг хайх хэрэгтэй болж байна.

Бодлогын асуудлууд

Эдийн засгийн сэргэлтийг бататгах бодлогууд нь санхүүгийн салбарыг эрүүлжүүлэх, эдийн засгийн дэмжих бодлогыг үргэлжлүүлэхэд чиглэгдэж байна. Үүний хажуугаар бодлогын шийдвэр гаргагчид нь төрийн хэт ихэссэн зохицуулалтыг шат дараалалтай бууруулахад чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлж эхлэх нь зүйтэй гэдэг дээр санал нэгдэж байна.

Мөнгөний бодлогыг чангаруулах цаг үе

Хямралыг даван туулахад чиглэгдсэн мөнгөний тэлэх бодлогыг хэзээ хумиж эхлэх нь төв банкуудад тулгарч буй асуудал юм. Инфляци тогтвортой бага түвшинд буй хөгжингүй орнууд болон зарим хөгжиж буй орнуудад мөнгөний тэлэх бодлогыг үргэлжлүүлэн явуулах боломж нөхцөл бий. Харин бусад хөгжиж буй орнуудын хувьд мөнгөний хумих бодлогыг эхлүүлэх нь зөв гэж эдийн засагчид үзэж байна. Зарим улсуудад түүхийн эдийн үнийн огцом өсөлт болон хөгжингүй орнуудын хэт тэлэх бодлогыг импортлохоос сэргийлж валютын ханшийн чөлөөтэй хөвөх системийг баримтлах шаардлага тулгарч буй.

Төсвийн дэмжих бодлогыг санхүүгийн тулхтай байдалтай уялдуулах

Дэлхийн эдийн засгийн сэргэлт тогворгүй, эмзэг байдалд байгаа энэ үед олон улс орнуудын төсвийн алдагдал өсч, өрийн дарамт нэмэгдэж буй хэдий ч төсвийн дэмжих бодлогыг үргэлжлүүлэн явуулах шаардлагатай байна. Хэрэгтэй тохиолдолд төсвийн дэмжлэгийг нэмэгдүүлэх арга хэмжээ явуулахад ч бэлэн байх асуудал тулгарч буй бол сэргэлт батажсан үед төсвийн алдагдлыг бууруулах арга хэмжээг авах шаардлагатай.

Хяналт шалгалтын тогтолцооны өөрчлөлтийг санхүүгийн салбарын эрүүлжих явцтай уялдуулах нь

Санхүүгийн байгууллагуудын активын чанар муудсан нь санхүүгийн салбарт тулгарч буй нэн чухал асуудал юм. Иймээс эдгээр байгууллагуудын үйл ажиллагаанд бүтцийн өөрчлөлт хийж, банкуудын тэнцлийг цэвэршүүлэх нь зээл олголтыг сайжруулахад гол үүрэгтэй.

Бүтцийн болон нийгмийн бодлогын асуудлууд

Хөгжингүй улс орнуудад ажилгүйдэл, хөгжиж буй орнуудын хувьд ядуурлын түвшин үргэлжлэн өсөх төлөвтэй байна. Ажилгүйдлийн өсөлтийг зогсооход цалингийн өсөлтийг хязгаарлах, зарим үед ажиллагсдын цалинг бууруулах шаардлага тулгарна. Үүний үр дагаварыг татварын бодлого, нийгмийн халамжийн бодлогоор зөөлөж болох юм. Ядуурлын түвшин өсч буй орнуудын хувьд хөгжингүй улс орнууд, донорын дэмжлэгийг таслалгүй үргэлжлүүлэх нь эдийн засгийн сэргэлтийг бататгах чухал алхам болно.

4.2. Төлбөрийн тэнцэл /2009 оны урьдчилсан гүйцэтгэлээр/

Монгол Улсын төлбөрийн тэнцлийн 2009 оны урьдчилсан гүйцэтгэлээр урсгал тэнцэл 382.0 сая ам.долларын алдагдалтай, хөрөнгө ба санхүүгийн тэнцэл 850.0 сая ам.долларын ашигтай гарч, алдаа ба орхигдуулгын дүн 7.8 сая ам.доллар болж бууран, гадаад валютын цэвэр албан нөөц 475.8 сая ам.доллараар нэмэгджээ.

Урсгал тэнцэл

Урсгал шилжүүлгийн данс 138.3 сая ам.долларын ашигтай гарсан боловч, барааны гадаад худалдааны тэнцэл, үйлчилгээний тэнцэл, цэвэр орлогын данс тус тус 157.1, 128.3, 234.9 сая ам.долларын алдагдалтай гарсан нь урсгал тэнцэл 382.0 сая долларын алдагдалтай гарахад нөлөөлсөн байна.


Гадаад худалдаа

Тайлант хугацаанд гадаад худалдааны эргэлт 2008 оноос 30.3 хувиар буурч, 3962.3 сая ам.долларт хүрчээ.

Хүснэгт 9. Худалдааны тэнцэл (сая ам.доллар)

Үзүүлэлт	2007 он	2008 он	2009 он	Жилийн өөрчлөлт	
				Мөнгөн дүн	хувиар
Экспорт	1 950.7	2 534.5	1 902.6	-631.9	-24.9
Импорт	2 003.1	3 147.0	2 059.7	-1 087.3	-34.6
Худалдааны эргэлт	3 953.8	5 681.5	3 962.3	-1 719.2	-30.3
Худалдааны тэнцэл	-52.4	-612.6	-157.1	455.5	-74.4

Эх сурвалж: Монголбанк



Зураг 33

Урсгал тэнцэл
(сая ам.доллараар)


Эх сурвалж: Монголбанк



Зураг 34

Урсгал тэнцэл
(сая ам.доллараар)

Эх сурвалж: Монголбанк



Зураг 35

Худалдааны тэнцэл
(сая ам.доллар)

Эх сурвалж: Монголбанк

Төлбөрийн тэнцлийн аргачлалаар¹² тооцсон нийт импорт¹³ 2008 онтой харьцуулахад 34.6 хувиар буурч 2059.7 сая ам.доллар, экспортын хэмжээ 24.9 хувиар буурч 1902.6 сая ам.долларт хүрэв. Гадаад худалдааны тэнцэл 2009 оны урьдчилсан байдлаар 157.1 сая ам.долларын алдагдалтай гарлаа. Гадаад худалдааны тэнцэл ийнхүү алдагдалтай гарсан нь алтнаас бусад экспортын гол нэрийн бүтээгдэхүүн болох зэсийн баяжмал, цайрын хүдэр ба баяжмал, чулуун нүүрс, ноос ноолуурын үнэ дэлхийн зах зээл дээр буурсан, түүнчлэн импортын өсөлт нь экспортын өсөлтөөс илүү хурдацтай байсантай холбоотой байна.

Гаалийн ерөнхий газрын статистикийн мэдээгээр валютын төлбөртэй гадаад худалдааны эргэлт 2009 онд 3725.7 сая ам.долларт хүрч 2008 оноос 30.2 хувь буюу 1608.9 сая ам.доллараар буурчээ. Нийт экспорт 2009 онд 24.9 хувиар буурч 1902.6 сая ам.доллар, нийт импорт 34.3 хувиар буурч 2131.3 сая ам.долларт хүрчээ. Валютын төлбөртэй гадаад худалдааны тэнцэл өмнөх онд 409.6 сая ам.долларын алдагдалтай байсан бол 2009 онд 57.3 сая ам.долларын ашигтай байлаа.

Хүснэгт 10. Валютын төлбөртэй гадаад худалдаа (сая ам.доллараар)

Үзүүлэлт	2005	2006	2007	2008	2009	Жилийн өөрчлөлт	
						Мөнгөн дүн	хувиар
Экспорт	962.6	1,447.1	1,865.1	2,462.4	1,891.5	-571.0	-23.2
Импорт	882.1	1,219.6	1,748.7	2,872.1	1,834.2	-1,037.9	-36.1
Худалдааны эргэлт	1844.7	2,666.7	3,613.8	5,334.5	3,725.7	-1,608.9	-30.2
Худалдааны тэнцэл	80.5	227.5	116.4	-409.6	57.3	466.9	-114.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Алтны экспортын биет хэмжээ тайлант онд 2008 оноос 47.1 хувиар буурч 11.7 тонн болжээ. Алтны экспортын орлого 2008 оноос 264.0 сая ам.доллараар буурч, 335.9 сая ам.доллар байна.

Зэсийн баяжмалын үнэ 2008 онтой харьцуулахад 40.4 хувиар буурч дунджаар 855.1 ам.долларт хүрчээ. Экспортолсон зэсийн баяжмалын биет хэмжээ 2009 онд 2008 оноос 0.7 хувиар буурч 586.9 мянган тонн, экспортын орлого 2008 оноос 39.9 хувиар буурч 501.8 сая ам.доллар болжээ.

Алт, зэсийн баяжмалын экспорт валютын төлбөртэй экспортын 18.0, 26.5 хувийг тус тус бүрдүүлж байна.

Монгол Улс 2009 онд 7254.9 тонн ноолуур, 68.2 мянган ширхэг ноолууран бүтээгдэхүүний экспортоос 168.7 сая ам.долларын орлого олсон. Тайлант онд самнасан ба угаасан ноолуур, ноолууран бүтээгдэхүүний экспортын биет хэмжээ 2008 онтой харьцуулахад 53.4 хувиар өссөн боловч зах зээлийн үнийн бууралтаас шалтгаалан экспортын орлого 6.6 хуви ар буурчээ. Ноолуур, ноолууран бүтээгдэхүүний экспорт валютын төлбөртэй экспортын 8.9 хувийг бүрдүүлэв.

¹² ОУВС-гийн төлбөрийн тэнцэл тооцох аргачлал

¹³ Төлбөрийн тэнцлийн шинэчилсэн аргачлалын дагуу Гаалийн ерөнхий газраас авсан импортын үнийн дүнг С.И.Ф нөхцөлөөс Ф.О.Б нөхцөлд шилжүүлж коэффициентийг 11.0 хувиар тооцов. Үүнээс 10 хувь нь тээврийн үйлчилгээ, үлдсэн 1 хувь нь даатгалын үйлчилгээний зардалд ордог болно.

Хүснэгт 11. Алт, зэсийн баяжмалын экспорт, нефтийн бүтээгдэхүүний импорт


	2005	2006	2007	2008	2009	Жилийн өөрчлөлт	
						дүнгээр	хувиар
Үнийн дүнгээр (сая ам.доллараар)							
Алтны экспорт	331.4	270.1	213.6	599.9	335.9	-264.0	-44.0
Зэсийн баяжмалын экспорт	326.2	635.4	742.4	835.6	501.8	-333.8	-39.9
Нефтийн бүтээгдэхүүний импорт	291.8	422.1	551.3	890.5	525.4	-365.1	-41.0
Биет хэмжээгээр (тонноор)							
Алтны экспорт (тонноор)	23.8	15.4	10.7	22.1	11.7	-10.4	-47.1
Зэсийн баяжмалын экспорт (мянган тонн)	587.1	599.5	557.9	582.9	586.9	4.0	0.7
Нефтийн бүтээгдэхүүний импорт (мянган тонн)	561.9	649.2	782.6	845.7	767.0	-78.7	-9.3

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Нефтийн бүтээгдэхүүний импортын биет хэмжээ тайлант онд 2008 оноос 14 хувь буюу 125.0 мянган тонноор буурч 767.0 мянган тоннд хүрсэн байна. Нефтийн бүтээгдэхүүний импорт нийт валютын төлбөртэй импортын 28.6 хувийг бүрдүүлэв.

Үйлчилгээ

Төлбөрийн тэнцлийн үйлчилгээний дансны нийт орлого 2009 онд 444.3 сая ам.доллар, зарлага 572.6 сая ам.доллар болж, үйлчилгээний тэнцэл 128.3 сая ам.долларын алдагдалтай гарав.



Зураг 36

Үйлчилгээний тэнцэл (сая ам.доллараар)

Төлбөрийн тэнцэл дэх аялал жуулчлалын данс¹⁴ 18.1 сая ам.долларын ашигтай гарсан боловч, тээврийн үйлчилгээ 41.4 сая, даатгалын үйлчилгээ 8.2 сая ам.долларын алдагдалтай гарсны зэрэгцээ барилгын, харилцаа холбооны үйлчилгээний зардалд 18.6 сая ам.доллар төлсөн нь үйлчилгээний тэнцэл алдагдалтай гарахад нөлөөлжээ.

Монгол Улсад 2009 онд нийт 282.5 мянган гадаадын жуулчин¹⁵ зочилж, аялал жуулчлалын орлого 189.0 сая ам.долларт хүрэв. Харин 340.1 мянган дотоодын жуулчид¹⁶ гадаадад аялж, 177.9 сая ам.доллар зарцуулсан байна.

¹⁴ Төлбөрийн тэнцлийн аялал жуулчлалын данс нь аялал жуулчлал, албан томилолт, сургалт, эмчилгээний зорилгоор гадаадад зарцуулсан зардлыг нийтэд нь хамруулдаг.

¹⁵ Монгол улсад ирсэн гадаадын жуулчдын тоог Хил хамгаалах ерөнхий газраас авсан.

¹⁶ Гадаадад зорчсон Монгол жуулчдын тоог Хил хамгаалах ерөнхий газраас авсан болно.

Хүснэгт 12. Жуулчлалын нийт орлого, зарлага (сая ам.доллар)

	2007	2008	2009	Жилийн өөрчлөлт	
				тоон дүн	хувиар
Жуулчлалын салбарын нийт орлого	287.0	229.5	189.0	-40.5	-18%
Гадаадын жуулчдын тоо/мянга/	432.7	342.3	282.5	-59.8	-17%
Жуулчлалын салбарын нийт зардал	166.6	169.0	177.9	8.9	5%
Гадаадад жуулчилсан Монгол иргэдийн тоо/мянга/	321.4	315.1	340.1	25.0	8%
Жуулчлалын цэвэр орлого	120.4	60.5	11.1	-49.4	-82%

Эх сурвалж: Монголбанк

Бусад үйлчилгээний тэнцэл¹⁷ 2009 онд 42.0 сая ам.долларын алдагдалтай гарав.

Цэвэр орлого

2009 онд хамтарсан үйлдвэрүүдээс гадаадын хөрөнгө оруулагчдад шилжүүлсэн ногдол ашгийн хэмжээ 142.4 сая ам.долларт хүрсэн. Засгийн газар, хувийн хэвшил нийтдээ гадаадын зээл, хадгаламж, харилцахын хүүд 89.5 сая ам.доллар төлж, 9.1 сая ам.долларын хүүний орлого олжээ. Мөн харьяат бус ажиллагсдад олгосон цалин хөлсний хэмжээ 12.1 сая ам.долларт хүрсэн нь цэвэр орлогын данс 234.9 сая ам.долларын алдагдалтай гарахад нөлөөлсөн байна.

Урсгал шилжүүлэг

2009 онд Монгол иргэдийн эх орон руугаа гуйвуулсан валютын хэмжээ 191.1 сая, гадагш шилжүүлсэн валютын хэмжээ 70.6 сая ам.долларт хүрч, цэвэр урсгал шилжүүлэг 138.3 сая ам.долларын ашигтай гарав.

Хүснэгт 13. Ажиллагсдын гуйвуулга (сая ам.доллар)

	2007	2008	2009	Жилийн өөрчлөлт	
				тоон дүн	хувиар
Ажилчдын гуйвуулга (цэвэр)	84.0	100.0	120.5	20.5	20.5%
Гаднаас орж ирсэн	174	214.8	191.1	-23.7	-11.0%
Гадагш шилжүүлсэн	90.3	114.8	70.6	-44.2	-38.5%

Эх сурвалж: Монголбанк

Хөрөнгө ба санхүүгийн тэнцэл

Төлбөрийн тэнцлийн 2009 оны урьдчилсан гүйцэтгэлээр хөрөнгө ба санхүүгийн тэнцэл 850.0¹⁸ сая ам.долларын ашигтай гарсан нь 2008 онтой харьцуулахад 12.0 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь 2008 онтой харьцуулахад:

- i) гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ 58.1 сая ам.доллар буюу 10 хувиар,
- ii) бусад хөрөнгө оруулалтын хэмжээ 187.2 сая ам.доллар буюу 47.0 хувиар тус тус буурсантай холбоотой.

¹⁷ Төлбөрийн тэнцлийн бусад үйлчилгээний хэсэгт санхүүгийн үйлчилгээ, компьютер, мэдээллийн үйлчилгээ, патент тэмдэгт, лицензийн хураамж, бусад бизнесийн үйлчилгээ, боловсрол соёлын үйлчилгээ, засгийн газрын үйлчилгээ зэрэг орно.


¹⁸ Хандивлагч орон, олон улсын санхүүгийн байгууллагаас авсан тусламжийн дүнг ОУВС-гийн стандарт аргачлалын дагуу урсгал дансанд бус хөрөнгийн дансанд тусгасан болно.



Эх сурвалж: Монголбанк

Зураг 37


Хөрөнгө ба санхүүгийн тэнцэл (сая ам.доллараар)



Эх сурвалж: Монголбанк

Зураг 38

Монгол улсад орсон шууд хөрөнгө оруулалт (улс орноор)



Эх сурвалж: Монголбанк

Зураг 39

Монгол улсад орсон шууд хөрөнгө оруулалт (салбараар)

Дэлхийн санхүү, эдийн засгийн хямралтай холбоотойгоор Монгол улсад оруулсан гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ 2008 онтой харьцуулахад 26.9 хувиар буурч, 467.2 сая ам.долларт хүрсэн.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг (ГШХО) улс орноор ангилан үзвэл, БНХАУ нийт хөрөнгө оруулалтын 27.9 хувь, ОХУ 24.0 хувь, Хонг Конг 13.9 хувь, Их Британи 8.6 хувийг тус тус эзэлж байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг үйлдвэрлэл, үйлчилгээний салбаруудаар авч үзвэл геологи хайгуул, уул уурхай, газрын тосны салбарт хамгийн их буюу нийт хөрөнгө оруулалтын 46.2 хувь, барилгын салбарт 14.8 хувь, банк санхүүгийн салбарт 5.1 хувь, үлдэх 33.9 хувь нь бусад салбарт ногдож байна.

Монгол Улсын Засгийн газрын шугамаар олон улсын банк, санхүүгийн байгууллага, хандивлагч орнуудаас 2009 онд нийт 365.8 сая ам.долларын урт хугацааны зээл авснаас ОУВС, Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк, Япон Улсын Засгийн газраас авсан зээл нийт зээлийн 92.8 хувийг эзэлж байна.

Тайлант онд 61.4 сая ам.долларын үндсэн өрийн төлбөр, 18.7 сая ам.долларын хүүний төлбөр, нийт 80.1 сая ам.долларыг гадаад өрийн үйлчилгээний төлбөрт төлснөөр урьдчилсан гүйцэтгэлээр Монгол Улсын Засгийн газрын шугамаар авсан гадаад зээлийн үлдэгдэл 1808.9 сая ам.доллар боллоо.

Монгол Улсын эдийн засгийн харьяат банк, аж ахуйн нэгж байгууллагууд нь тайлант онд 300.6 сая ам.долларын урт хугацаат, 131.9 сая ам.долларын богино хугацаат зээлийн эх үүсвэрийг авч, улмаар нийт 201.0 сая ам.долларын өрийг эргүүлэн төлж барагдуулснаар хувийн хэвшлийн салбар дахь гадаад зээлийн үлдэгдэл 701.2 ам.долларт хүрэв.

Монгол улсын төлбөрийн тэнцлийн төсөөлөл

Монголбанкны 2010 оны 2 дугаар сард хийсэн төсөөллөөр энэ онд төлбөрийн тэнцлийн урсгал данс 1031.2 сая ам.долларын алдагдалтай, хөрөнгө санхүүгийн данс 1102.8 сая ам.долларын ашигтай, нийт төлбөрийн тэнцэл 71.6 сая ам.долларын ашигтай гарахаар байна.

Мөн тайлант онд чулуун нүүрс, түүхий нефть зэрэг зарим нэр төрлийн эрдэс, түүхий эд, бүтээгдэхүүний олборлолт өсөхөөс шалтгаалан экспортын орлого 12.4 хувиар нэмэгдэх төлөвтэй байна. Эдийн засаг харьцангуй сэргэх, Оюу толгой төслийн хөрөнгө оруулалт нэмэгдэхтэй уялдан нийт импортын хэмжээ мэдэгдэхүйц өсөхөөр байгаа нь урсгал тэнцлийг алдагдлыг нэмэгдүүлэхэд зонхилох нөлөө үзүүлнэ. Хэдий тийм ч импортын өсөлтөд валютын төлбөргүй буюу хөрөнгө оруулалтын зориулалттай импорт дийлэнх хувийг эзлэх тул энэ нь нийт төлбөрийн тэнцэлд төдийлөн дарамт учруулахааргүй юм.

Хүснэгт 14. Төлбөрийн тэнцлийн 2010 оны төсөөлөл (сая ам.доллараар)

Үзүүлэлтүүд	2007	2008	2009					2010F				
			Q1	Q2	Q3	Q4	Жилийн	Q1	Q2	Q3	Q4	Жилийн
Урсгал тэнцэл	171.8	-721.9	-94.1	-132.4	-18.3	-137.7	-382.5	-205.0	-290.7	-333.5	-202.1	-1031.2
Худалдааны тэнцэл	-52.4	-612.6	-48.4	-39.4	-53.7	-14.9	-156.4	-179.4	-248.7	-259.0	-159.3	-846.4
Экспорт	1950.7	2534.5	322.3	440.6	530.9	608.8	1902.6	317.4	597.0	616.4	607.9	2138.8
Импорт	2003.1	3147.0	370.7	480.0	584.6	623.7	2059.0	496.8	845.7	875.4	767.2	2985.2
Хоронго ба санхүүгийн тэнцэл	328.7	966.2	65.9	168.7	252.0	362.5	849.2	173.2	342.5	379.2	207.9	1102.8
Нийт төлбөрийн тэнцэл	288.0	-351.3	-27.9	126.5	148.2	229.1	475.8	-31.8	51.8	45.7	5.8	71.6

Эх сурвалж: Монголбанк

4.3. ҮНЭ

Хэрэглээний үнийн ерөнхий индексээр тооцсон үнийн түвшин 2009 оны жилийн эцэст өмнөх оны мөн үеэс 1.9 хувиар өссөн байна. Үүний дотор согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 22.1 хувь, бусад бараа, үйлчилгээнийх 15.9 хувь, эм, тариа, эмнэлгийн үйлчилгээнийх 14.2 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрных 12 хувь, боловсролын үйлчилгээнийх 9 хувь, холбооны үйлчилгээнийх 7 хувь, гэр ахуйн бараа, тавилгынх 6.5 хувь, гутал, бөс барааных 3.7 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээнийх 1.9 хувиар тус тус өссөн байна. Харин хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 0.5 хувь, тээврийнх 0.8 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшнийх 3.9 хувиар тус тус буурчээ.


Хэрэглээний үнийн улсын индекс 2008 оны жилийн эцэст өмнөх оныхоос 23.2 хувь өссөн бол 2009 оны жилийн эцэст өмнөх оны мөн үеэс 1.9 хувиар өсч, өсөлтийн хурдац 21.3 нэгжээр багасчээ. Хэрэглээний бараа, үйлчилгээний сарын индекс дүнгээрээ 2009 оны 6 дугаар сараас эхлэн 10 дугаар сарыг дуустал дараалан 0.1-1.4 хувиар сар бүр буурч, эдгээрээс бусад саруудад 0.1-2.2 хувь өссөн дүнтэй байна. Сарын дундаж өсөлт 2009 оны эхний 5 сард 1.1 хувь байсан бол сүүлийн хагаст ихэнхдээ бууралттай байлаа.

Хүснэгт 15. Хэрэглээний үнийн улсын индекс (бүлгээр, хувиар)

	Хувийн жин	2009-12	Өсөлтөд эзлэх хувь
		2008-12	
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	41.1	-0.5	-8.7
Согтууруулах ундаа, тамхи	2.3	22.1	23.9
Хувцас, бөс бараа, гутал	12.4	3.7	21.4
Орон сууц, ус, цахилгаан, түлш	13.4	-3.9	-24.6
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	4.3	6.5	13.2
Эм тариа, эмнэлэгийн үйлчилгээ	1.6	14.2	11.0
Тээвэр	8.7	-0.8	-3.3
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.0	7.0	13.8
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	3.3	1.9	3.0
Боловсролын үйлчилгээ	4.1	9	17.8
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	1.7	12	9.8
Бусад бараа үйлчилгээ	3.0	15.9	22.7
Ерөнхий индекс	100	1.9	100

Эх үүсвэр: УСХ, Статистикийн сарын бюллетень

Зураг 40
Инфляци (сарын өөрчлөлт)



Зураг 41
Банк хоорондын зах дээр хийгдсэн нийт арилжааны дүн, илүүдэл нөөц



Зураг 42
Банк хоорондын захын ЖДХ, банкуудын илүүдэл нөөц



Хэрэглээний үнийн индексээр тооцсон жилийн инфляци ийнхүү буурсан нь төгрөгийн гадаад валюттай харьцах ханш чангарч харьцангуй тогтворжсон, хүнсний бүтээгдэхүүний үнэ алгуур буурч, эдийн засгийн уналтыг даган өрхийн хэрэглээ нэмэгдээгүйгээс эрэлтээс шалтгаалсан инфляци бий болоогүй байна.

4.4. Банк хоорондын мөнгөний зах

Банк хоорондын мөнгөний зах дээр банкуудын хооронд овернайт зээл, репо санхүүжилт, Төв банкны үнэт цаасны арилжаа, банк хоорондын зээл, хадгаламж зэрэг арилжаа хийгддэг. Тайлант оны сүүлийн хагаст банк хоорондын мөнгөний захын идэвх суларч оны эхэнд нийт арилжааны дүн 139.5 тэрбум төгрөг байсан бол 8 дугаар сард энэ дүн 43.6 хувиар буурч 78.7 тэрбум төгрөг болсон байна.

Банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү 2009 оны 1 дүгээр улирлын эцэст 17.9 хувьтай байсан банк хоорондын захын хүү нь 2 дугаар улирлын эцэст 15.1 хувь, 3 дугаар улирлын эцэст 11.5 хувь, оны эцэст 8.6 хувь болж буурсан байна. Банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү нь зах зээлийн эрэлт, нийлүүлэлтээр тогтоогддог бөгөөд тайлант онд банк хоорондын захын идэвх суларч, хүү буурсан нь банк хоорондын зах дээр итгэлцэл буурч, сегментчлэл үүссэнийг илтгэж байгаа юм.

4.5. Засгийн газрын санхүү

Монгол улсын нэгдсэн төсвийн орлого ба тусламжийн дүн 1993.0 тэрбум төгрөг (ДНБ-ий 32.9 хувь), нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 2321.6 тэрбум төгрөг (ДНБ-ий 38.3 хувь) болж, нийт тэнцэл 328.6 тэрбум төгрөгийн (ДНБ-ий 5.4 хувь) алдагдалтай гарчээ. Урсгал тэнцэл 0.1 тэрбум төгрөгийн (ДНБ-ий 2.8 хувь) ашигтай гарсан байна.

Хүснэгт 16. 2009 оны улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл (сая төгрөгөөр)

	2008		2009			2009/2008 (гүйц), %	Төлөвлөгөөний биелэлт, %
	Гүйцэтгэл	Хувийн жин	Төлөвлөлт	Гүйцэтгэл	Хувийн жин		
Нийт орлого ба тусламж	2,156,382.6	100.00	2,088,246.3	1,992,985.8	100.0	92.4	95.4
Урсгал орлого	2,136,092.1	99.06	2,060,816.0	1,965,510.3	99.1	115.1	95.4
Татварын орлого	1,888,925.2	88.43	1,719,312.2	1,615,251.2	87.6	125.7	93.9
Орлогын албан татвар	758,232.3	40.14	463,937.9	520,006.4	35.2	116.9	112.1
Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	223,270.6	11.82	252,088.1	257,339.2	10.4	139.1	102.1
Өмчийн татвар	8,987.1	0.48	10,838.5	10,979.8	0.4	108.8	101.3
Дотоодын бараа, үйлчилгээний татвар	550,975.3	29.17	630,281.0	508,656.9	25.6	133.8	80.7
Гадаад худалдааны орлого	150,838.7	7.99	163,193.4	115,987.5	7.0	147.2	71.1
Бусад татвар	196,621.1	10.41	198,973.4	202,281.3	9.1	115.1	101.7
Татварын бус орлого	247,166.9	11.57	341,503.8	350,259.1	11.5	69.9	102.6
Хөрөнгийн орлого	4,440.1	0.21	5,430.3	2,958.2	0.2	176.1	54.5
Тусламжийн орлого	15,850.4	0.74	22,000.0	24,517.3	0.7	72.0	111.4
Нийт зарлага ба цэвэр зээл	2,462,046.6	100.00	2,481,313.22	2,321,599.6	100.0	94.3	93.6
Урсгал зардал	1,749,518.5	71.06	1,864,603.9	1,792,065.7	77.2	102.4	96.1
Бараа ба үйлчилгээний зардал	1,030,660.9	58.91	976,478.1	969,549.4	41.8	94.1	99.3
Зээлийн үйлчилгээний төлбөр	19,840.4	1.13	41,440.6	28,965.6	1.2	146.0	69.9
Татаас ба урсгал шилжүүлэг	699,017.2	39.95	846,685.2	793,550.8	34.2	113.5	93.7
Хөрөнгийн зардал	624,898.8	25.38	512,431.0	457,923.9	19.7	73.3	89.4
Эргэж төлөгдөх цэвэр зээл	87,629.3	3.56	104,278.3	71,610.0	3.1	81.7	68.7
Урсгал тэнцэл	386,573.6		196,212.1	173,444.6		44.9	88.4
Нийт тэнцэл	(305,664.0)		(393,066.9)	(328,613.8)		107.5	83.6
Алдагдлыгсанхүүжүүлсэн эх үүсвэр	305,664.0		393,066.9	328,613.8		107.5	83.6
Гадаад, цэвэр	43,042.4		249,615.6	443,283.1		1029.9	177.6
Дотоод, цэвэр	262,621.6		143,451.3	(114,669.3)		-43.7	-79.9

Төсвийн орлого

Нийт орлого ба тусламжийн дүн 1993.0 тэрбум төгрөг хүрсэн нь төлөвлөсөн хэмжээнээс 4.6 хувь буюу 95.3 тэрбум төгрөг, өмнөх оны мөн үеэс 7.6 хувь буюу 163.4 тэрбум төгрөгөөр бага байна. Төсвийн нийт орлого ба тусламжийн 98.6 хувийг бүрдүүлдэг урсгал орлого өмнөх оны мөн үеэс 8.0 хувь буюу 170.6 тэрбум төгрөгөөр буурсан нь нийт орлого ба тусламжийн дүн буурахад голлон нөлөөлжээ.

Урсгал орлогын 82.2 хувийг бүрдүүлсэн татварын орлого өмнөх оны мөн үеэс 14.5 хувь буюу 273.7 тэрбум төгрөгөөр буурсан нь аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 18.9 хувь буюу 47.9 тэрбум төгрөг, зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар 52.0 хувь буюу 202.2 тэрбум төгрөгөөр буурсанаас шалтгаалжээ. Татварын орлогын 31.5 хувийг бүрдүүлдэг дотоодын бараа, үйлчилгээний татвар 7.7 хувь буюу 42.3 тэрбум төгрөгөөр буурчээ.

Дотоодын бараа, үйлчилгээний татварын орлогын 64.1 хувийг бүрдүүлсэн нэмэгдсэн өртгийн албан татварын орлого 29.2 тэрбум төгрөг буюу 8.2 хувь, онцгой албан татварын орлого (дотоодын бараа, үйлчилгээний татварын орлогын 32.9 хувь) 11.7 тэрбум төгрөг буюу 6.6 хувиар буурчээ. Тайлант онд импорт буурсан нь нэмэгдсэн өртгийн албан татварын орлого буурахад хүргэв. Харин онцгой албан татварын орлогын ихэнх хувийг бүрдүүлдэг дотоодын архины онцгой албан татвар 5.5 хувь, автобензин, дизелийн түлшний онцгой албан татвар 66.8 хувь, суудлын автомашины онцгой албан татвар 62.2 хувиар тус тус буурсан нь онцгой албан татварын нийт орлогыг бууруулжээ.


Гадаад худалдааны орлого 34.8 тэрбум төгрөг буюу 23.1 хувиар буурсанаас импортын барааны гаалийн албан татварын орлого (гадаад худалдааны орлогын 95.9 хувийг бүрдүүлсэн) 30.8 тэрбум төгрөг буюу 21.7 хувиар багасчээ. Харин бусад татварын орлогод ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр (16.5 хувийн жинтэй) 5.7 тэрбум төгрөг буюу 20.7 хувиар өсчээ.

Төсвийн зарлага

Төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 2321.6 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 5.7 хувь буюу 140.4 тэрбум төгрөг, төлөвлөсөн хэмжээнээс 159.7 тэрбум төгрөг буюу 6.4 хувиар бага байна.


Тайлант онд урсгал зардал өмнөх оны мөн үеэс 2.4 хувь буюу 42.5 тэрбум төгрөгөөр өсч 1792.1 тэрбум төгрөгт, хөрөнгийн зардал 26.7 хувь буюу 167.0 тэрбум төгрөгөөр буурч 457.9 тэрбум төгрөгт, эргэж төлөгдөх цэвэр зээл 18.3 хувь буюу 16.0 тэрбум төгрөгөөр буурч 71.6 тэрбум төгрөгт тус тус хүрчээ.

Урсгал зардлыг бүрэлдэхүүн тус бүрээр нь авч үзвэл, бараа үйлчилгээний зардал (урсгал зардлын 54.2 хувь) өмнөх оны мөн үеэс 61.1 тэрбум төгрөгөөр буурсан бол, зээлийн үйлчилгээний төлбөр (урсгал зардлын 1.6 хувь) 9.1 тэрбум тэрбум, татаас ба шилжүүлэг (урсгал зардлын 44.2 хувь) 94.5 тэрбум төгрөгөөр тус тус өсчээ.




Зураг 43

Төсвийн ашиг алдагдал (ДНБ-д эзлэх хувиар)



Зураг 44

Нийт орлого ба тусламж



Зураг 45

Нийт зардал ба цэвэр зээл

4.6. Хөрөнгийн зах зээлийн хөгжил

Монголын Хөрөнгийн Биржид 2009 онд үнэт цаасны 255 удаагийн арилжаа явагдаж 131 компанийн 89.9 сая ширхэг хувьцаа арилжигдаж, нийт 23.2 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдсэн байна. Хувьцаа арилжааны хэмжээ өнгөрсөн онтой харьцуулахад 37.2 тэрбум төгрөг буюу 61.6 хувиар буурчээ. Анхдагч зах зээл дээр 25.7 сая ширхэг хувьцаа 2.6 тэрбум төгрөгөөр, хоёрдогч зах зээл дээр 64.2 сая ширхэг хувьцаа 20.6 тэрбум төгрөгөөр арилжаалагджээ. Гүйлгээний үнийн дүндээр анхдагч зах зээлийн арилжаа 11.2 хувь, хоёрдогч зах зээлийн арилжаа 88.8 хувь эзэлж байна. Нийт зах зээлийн үнэлгээ 620.7 тэрбум төгрөгт хүрсэн нь ДНБ-ийн 10.2 хувь байна. Багануур, Таван толгой, МЦХ, АПУ, Шивээ овоо, Говь, Туул сонгино усны нөөц зэрэг нь хамгийн өндөр зах зээлийн үнэлгээтэй компаниудад орж байна.

Хөрөнгийн зах зээлд шинээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулахаар Гүүд сек ХХК, Лондон Азия капитал Монголиа ХХК, Тэнгри секюритиес ХХК эрх авснаар, МХБ-ийн гишүүн, брокер дилерийн компанийн тоо 45-д хүрэв. Эдгээрээс 13 нь гадаадын хөрөнгө оруулалттай компани байна. Тайлант онд бүртгэлтэй 358 ХК-аас 126 компани хувь нийлүүлэгчдийн хурлаа зарлан хуралдуулсан бөгөөд 26 компани хувьцаа эзэмшигчиддээ 2008 оны ногдол ашиг хуваарилжээ.

Хүснэгт 17. Арилжааны гүйлгээ /сая төгрөг/

	Арилжааны үнийн дүн		Өөрчлөлт	
	2008	2009	Үнийн дүнгээр	Хувиар
ЗГ-ын бонд	1,494.7		-1,494.7	-100
Компанийн бонд	502.0		-502.0	-100
Хувьцаа	60,349.3	23,181.5	-37,167.8	-61.6

ТОП-20 үнийн индексийн үзүүлэлт тайлант оны эцэст 6189.91 болсон нь өмнөх оныхоос 606.69 нэгжээр буюу 10.9 хувиар нэмэгдсэн байна. ТОП-20 үнийн индексийн 2009 оны дундаж 5551 байв. ТОП-20 үнийн индекс 2008 оны 9-10 саруудад хамгийн өндөр буюу тухайн саруудын дундаж 7224.17 байсан бол хамгийн бага нь 2 дугаар сард дунджаар 4747 байв.

Зураг 46
2009 оны
ТОП 20 индекс



Хувьцаа арилжааны өдрийн дундаж нь хувьцааны тоо ширхгээр 352.6 мянга, үнийн дүнгээр 90.9 сая төгрөг болж байна.

МОНГОЛБАНКНААС 2009 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДЛОГЫН БА ТЕХНИКИЙН ШИНЖ ЧАНАРТАЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУРААНГУЙ

5

Монголбанкнаас 2009 онд хэрэгжүүлсэн бодлогын ба техникийн шинж чанартай арга хэмжээний хураангуй				
Д/д	Огноо	Дугаар	Нэр	Агуулга
1.	2009.01.06	6	Журам хэрэгжүүлэх тухай	МУ-ыг хөгжүүлэх сангийн мөнгөн хөрөнгийг санхүүгийн зах зээл дээр байршуулах журмыг Монголбанк үйл ажиллагаандаа хэрэгжүүлэхээр батлав.
2.	2009.01.15	13	Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	МБ-наас банкинд олгох барьцаат зээлийн журамд Хяналт шалгалтын газар зээлдэгч банкны төлбөрийн чадварын талаар дүгнэлт гаргаж Мөнгөний бодлого судалгааны газарт ирүүлж байхыг зохицуулав.
3.	2009.03.04	125/50	Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журамд Зээлийн гэрээний хугацаа 1 удаа сунгагдсан бол зээлийн ангиллыг хэвээр үлдээх талаар зохицуулав.
4.	2009.03.10	138	Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Төв банкны үнэт цаасны журамд Хүүгээр өрсөлдөх арилжааны хувьд, Монголбанк хүүний дээд хязгаар тогтоов.
5.	2009.03.16	149	Журам батлах тухай	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкуудад хяналт шалгалт хийх журам. Банкуудын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа ажилд газар дээр хяналт шалгалт хийхийг журамлав.
6.	2009.03.17	154	Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай	Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, хяналт тавих журамд нэгдүгээр зэргийн өөрийн хөрөнгийн хувь хэмжээ тогтоожээ.
7.	2009.03.19	160	Хүүний бүтэц батлах тухай	Монголбанкны мөнгөний бодлогын хүүний бүтцийг шинэчлэн тогтоов.
8.	2009.03.19	162	Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай	Монголбанк банкны заавал байлгах нөөцийн хэмжээнд хүү төлөх, тайлан ирүүлэх талаар зохицуулалт оруулав.
9.	2009.03.20	164	Гадаад валютын дуудлага худалдааны журам, Гадаад валютын дуудлага худалдаа явуулах заавар батлах тухай	Дотоодын банк хоорондын гадаад валютын захад Монголбанкнаас оролцох үйл ажиллагааг журамлав.
10.	2009.03.27	172	Санхүүгийн мэдээллийн албаны аюулгүй ажиллагааны журам батлах тухай	Санхүүгийн мэдээллийн албаны дотоод зохион байгуулалтын аюулгүй ажиллагаа, хамгаалалтыг тусгасан журам. Мэдээллийн сангийн хамгаалалт, түлхүүр бүртгэл, ажилтнуудын аюулгүй байдал, сэйф ашиглалт гэх асуудлыг тусгажээ.
11.	2009.03.27	177	Төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг тооцох, зарлах тухай	Төгрөгийн ам.доллар болон бусад гадаад валюттай харьцах Монголбанкны албан ханшийг банк хоорондын зах дээр өмнөх өдөр хийгдсэн жигнэсэн дундаж ханшийг мэдээлж байхыг Валют, эдийн засгийн газарт даалгав.

12.	2009.04.03 2009.03.20	15/191	Журам загвар батлах тухай	Сонгуулийн зардлын сангийн данс нээх, хаах, бүртгэл тайланг хөтлөх журам, Нам /хамтарсан нам/-ын сонгуулийн зардлын сангийн тайлангийн загвар, Нам /хамтарсан нам/-ын хандивын тайлангийн загвар батлав.
13.	2009.04.06	203	Зааварт өөрчлөлт оруулах тухай	Гадаад валютын дуудлага худалдаа явуулах зааварт төрийн байгууллагууд болон Монголбанкинд харилцах данстай Олон улсын байгууллагууд Монголбанкны тухай өдрийн зарласан ханшийг валютын арилжааны хэлцэлд ашиглах асуудлыг зохицуулав.
14.	2009.05.20	286	Мэдээ авах тухай	Банкны мөнгөн урсгалын таамаглалын тайлан, Банкны томоохон харилцагч, хадгаламж эзэмшигчдийн тайлан, Банкны чанаргүй болон шинээр олгосон зээлийн тайлан, Банкны тэнцлийн гадуурх дансдын тайлан мэдээ авч байх харилцааг журамлав.
15.	2009.05.22	293	Журам батлах тухай	Монголбанкнаас мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх, банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг богино хугацаанд хангах зорилгоор банкинд репо санхүүжилт олгох харилцааг зохицуулсан Төв банкны репо санхүүжилтийн журмыг баталжээ.
16.	2009.05.26	296	Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай	Монголбанкнаас олгох овернайт зээлийн журамд овернайт зээл олгох хоёр тохиолдолдлыг журамлав.
17.	2009.08.06	440	Журам батлах тухай	Төлбөрийн картын журмаар төлбөрийн картын талаарх үйл ажиллагааны зарчмуудыг тогтоох, картын үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, төлбөрийн картын үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхойлох, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавих харилцааг зохицуулав.
18.	2009.12.10	701	Журам батлах тухай	Дурсгалын зоосны тухай журам. Монголбанкны нэр, бэлэгдэлтэйгээр үнэт металлаар үйлдвэрлэх, зөвшөөрөл олгох, зоосыг бүртгэх, хадгалах, хамгаалах, үзэсгэлэн гаргах, хяналт тавих харилцааг зохицуулжээ.
19.	2009.12.22	723	Журам батлах тухай	Банк, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн гадаад зээлийг бүртгэх харилцааг журамлав.

Захирлуудын зөвлөлийн хариуцлагын талаарх мэдэгдэл

Санхүүгийн тайланг бэлтгэх нь Захирлуудын Зөвлөлийн үүрэг байна.

Монголбанкны санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бэлтгэсэн болно. Захирлуудын Зөвлөл нь 2009 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны үйл ажиллагаа, тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үр дүн ба мөнгөн гүйлгээг энэхүү санхүүгийн тайланд үнэн зөвөөр илэрхийлэхийг баталгаажуулах үүрэгтэй.

Захирлуудын Зөвлөл нь Банкны санхүүгийн байдлыг үнэн зөв илэрхийлэх, нягтлан бодох бүртгэлийг зөв зохистой хөтөлж явуулдаг бөгөөд санхүүгийн тайлан нь Тодруулга 2-т тусгагдсан шаардлагуудад нийцэж байгаа гэдгийг баталгаажуулах үүрэгтэй.

Мөн Банкны хөрөнгийг хамгаалах, залилан, бусад зөрчил, дутагдлаас сэргийлэх, илрүүлэх арга хэмжээг авах нь Захирлуудын Зөвлөлийн үүрэг байдаг.


Санхүүгийн тайланг (4-57 дугаар хуудсанд үзүүлсэн) бэлтгэхдээ зохих бодлогыг баримталж, үндэслэлтэй бөгөөд зохистой шийдэл, тооцооллыг ашиглаж, нягтлан бодох бүртгэлийн бүхий л холбогдох стандартуудыг дагаж мөрдсөн гэж Захирлуудын Зөвлөл үзэж байна.

Захирлуудын Зөвлөлийн шийдвэрийн дагуу гарын үсэг зурсан:



Л.ПҮРЭВДОРЖ
Монголбанкны Ерөнхийлөгч

Улаанбаатар
2010 оны 5 дугаар сарын 24



ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

Монголбанкны гишүүдэд

Бид Монголбанкны 2009 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн дараах санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ

Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор Банкны захирлуудын хүлээх үүрэг

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх ба үнэн зөв толилуулах нь Банкны захирлуудын хариуцлага байдаг. Энэхүү хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгон авч хэрэглэх мөн нөхцөл байдалд уялдсан нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудыг хийх замаар залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, толилуулах үйл явцад холбоотой дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх, тогтмол хэрэглэж байх хариуцлага орно.

Аудиторын хариуцлага

Хийж гүйцэтгэсэн аудит дээрээ үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар дүгнэлт гаргах нь бидний үүрэг юм. Бид аудитаа Аудитын олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Тэдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагуудад нийцэж ажиллах мөн санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаагүй эсэх талаар зохистой баталгаажуулалтыг олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэх ажил багтана. Сонгон авах горимууд нь залилан болон алдааны улмаас санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдсэнээс үүсэх эрсдэлийн үнэлгээ зэргийг багтаасан аудиторын мэргэжлийн үнэлэмжүүдээс хамаарна. Тэдгээр эрсдэлийн үнэлгээнүүдийг хийхдээ аудитор нь байгууллагын дотоод хяналтын үр нөлөөтэй эсэх талаар дүгнэлт гаргах зорилгоор биш зөвхөн тухайн нөхцөл байдалд зохистой аудитын горимуудыг зохиох үүднээс байгууллагын санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, тэдгээрийг үнэн зөв толилуулах үйл явцад холбоотой дотоод хяналтыг харгалзаж үздэг. Мөн аудитын ажилд хэрэглэгдэж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын таарамж, удирдлагын хийсэн нягтлан бодох бүртгэлтэй холбоотой тооцооллуудын бодитой эсэхийг үнэлж үзэх ажил орно.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадсан гэдэгт бид итгэлтэй байна.



Ernst & Young Mongolia Audit LLC

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ (үргэлжлэл)

Хязгаарлалттай дүгнэлт гаргах болсон үндэслэл

Санхүүгийн тайлангийн Тодруулга 17-ын (iii)-д үзүүлсэн, дотоодын банкуудад олгосон зээлийн 2009 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх үлдэгдлийн дүнд Монголбанк эрхийг нь хүлээн авсан дотоодын арилжааны банкны төлөх 127.6 тэрбум төгрөг (2008 онд 84.7 тэрбум төгрөг)-ийн зээл багтсан ба энэ нь 18.7 тэрбум төгрөг (2008 онд 18.7 тэрбум төгрөг)-ийн үнэ цэнэ бууралтын алдагдлын санг хассан цэвэр дүн болно. Их хурлаас 2008 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр баталсан “Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай” хууль болон 2009 оны 5 дугаар сарын 20-ны өдөр Сангийн яамтай гарын үсэг зурсан ойлголцлын санамж бичиг дээр үндэслэн, Монголбанкны захирлууд зээлийн үлдэгдэл болох 127.6 тэрбум төгрөг (2008 онд 66 тэрбум төгрөг байсан)-ийг Монгол Улсын Засгийн газраас авна гэсэн дүгнэлттэй байна. Гэсэн хэдий ч, төлбөрийг хэрхэн барагдуулах талаар өөр мэдээлэл байхгүй байгаа учраас, бид энэхүү 127.6 тэрбум төгрөг (2008 онд 66.0 тэрбум төгрөг)-ийн зээлийн эргэн төлөлт ба 18.3 тэрбум төгрөг (2008 онд 18.7 тэрбум төгрөг)-ийн дүнтэй үнэ цэнийн бууралтыг баталгаажуулах өөр сонголтод аудитын горимуудыг гүйцэтгэх боломжгүй байсан. Бид 2008 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайланд мөн адил шалтгаанаар хязгаарлалттай дүгнэлт өгсөн.

Хязгаарлалттай дүгнэлт

Бидний дүгнэлтээр, хэрэв “Хязгаарлалттай дүгнэлт гаргах болсон үндэслэл”-д тодорхойлсон асуудлууд шаардлага хангахуйцаар шийдэгдсэн бол хийх шаардлагатай гэж тодорхойлогдож болох байсан тэдгээр залруулгууд (хэрэв байгаа бол)-ын нөлөөллийг эс тооцвол, эдгээр санхүүгийн тайлангууд нь 2009 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу үнэн зөв, бодитой үзүүлсэн байна.

Бусад асуудлууд

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, зөвхөн Банкны гишүүдэд зориулан гаргасан болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Ernst & Young Mongolia Audit LLC

ЭРНСТ ЭНД ЯНГ МОНГОЛИЯ АУДИТ ХХК

Мэргэшсэн нягтлан бодогчид

ЧУНГ СИНГ ПЕТР ЁНГ

Захирал

Улаанбаатар хот, Монгол Улс

2009 оны 8 дугаар сарын 27

МОНГОЛБАНК

2009 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

	Тодруулга	2009 сая төгрөг	2008 сая төгрөг
Хүүний орлого	3	16,114	29,559
Хүүний зардал	4	(31,268)	(11,864)
Хүүний цэвэр (зардал)/орлого		(15,154)	17,695
Алт, үнэт металлын арилжааны цэвэр ашиг	5	31,197	41,221
Валютын ханшийн зөрүүний цэвэр ашиг	6	60,029	7,875
Үйл ажиллагааны бусад орлого		4,401	2,169
Үйл ажиллагааны нийт орлого		80,473	68,960
Үнэ цэнийн бууралтын зардал	7	(23,417)	(21,868)
Үйл ажиллагааны цэвэр орлого		57,056	47,092
Үйл ажиллагааны зардал	8	(13,571)	(6,995)
Үйл ажиллагааны бусад зардал	10	(4,686)	(10,683)
Банкны өөрийн хөрөнгө эзэмшигчдэд ногдох тайлант жилийн ашиг		38,799	29,414
Бусад дэлгэрэнгүй орлогууд			
Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгийн цэвэр (гарз)/олз		(3,680)	2,438
Барилга, байшингийн дахин үнэлгээ		-	5,320
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого	11	(3,680)	7,758
Банкны өөрийн хөрөнгө эзэмшигчдэд ногдох, тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого		35,119	37,172

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

МОНГОЛБАНК

2009 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

	Тодруулга	2009 сая төгрөг	2008 сая төгрөг
АКТИВ			
Бэлэн мөнгө		47,749	39,589
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө, хадгаламж	12	1,271,630	212,898
Санхүүгийн хөрөнгө оруулалт - Борлуулахад бэлэн	13	421,759	324,635
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	14	469,933	237,278
Алт ба үнэт металл	15	63,388	137,432
Засгийн газрын үнэт цаас	16	170,000	-
Дотоодын банкуудад олгосон зээл	17	166,988	224,354
Сангийн яаманд олгосон зээл	18	262,755	25,564
Үндсэн хөрөнгө	19	23,966	23,514
Бусад авлага	20	1,149	316
НИЙТ АКТИВ		2,899,317	1,225,580
ПАССИВ			
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө		371,832	407,210
Гаргасан үнэт цаас	21	392,512	119,786
Засгийн газрын байгууллагуудын харилцах, хадгаламж	22	698,227	210,696
Дотоодын банкуудын харилцах, хадгаламж	23	541,638	226,526
Гадаад өр төлбөр	24	737,056	145,272
Бусад пассив	25	49,548	42,705
НИЙТ ПАССИВ		2,790,813	1,152,195
ДҮРМИЙН САН БА НӨӨЦ			
Дүрмийн сан	26	5,000	5,000
Хуримтлагдсан ашиг		-	25,914
Ерөнхий нөөцийн сан	27	29,961	20,834
Бусад нөөц	28	73,543	21,637
НИЙТ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		108,504	73,385
НИЙТ ПАССИВ БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		2,899,317	1,225,580

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

МОНГОЛБАНК

2009 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

	←-----Хуваарилагдахгүй-----→		Хуваарилагдах		
	Дүрмийн сан сая төгрөг	Ерөнхий нөөц (Тодруулга 27) сая төгрөг	Бусад нөөц (Тодруулга 28) сая төгрөг	Хуримтлагдсан ашиг сая төгрөг	Нийт сая төгрөг
2008 оны 1 дүгээр сарын 1-нээр	5,000	15,704	13,879	5,130	39,713
Нийт дэлгэрэнгүй орлого	-	-	7,758	29,414	37,172
Нийгмийн хөгжлийн санд шилжүүлсэн	-	-	-	(3,500)	(3,500)
Ерөнхий нөөцөд шилжүүлсэн хуримтлагдсан ашиг	-	5,130	-	(5,130)	-
2008 оны 12 дугаар сарын 31-нээр	5,000	20,834	21,637	25,914	73,385
Нийт дэлгэрэнгүй орлого	-	-	(3,680)	38,799	35,119
Ерөнхий нөөцөд шилжүүлсэн хуримтлагдсан ашиг	-	9,127	55,586	(64,713)	-
2009 оны 12 дугаар сарын 31-нээр	5,000	29,961	73,543	-	108,504

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

МОНГОЛБАНК

2009 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Тодруулга	2009 сая төгрөг	2008 сая төгрөг
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Тайлант жилийн ашиг	38,799	29,414
<i>Тохируулга :-</i>		
Алтны дахин үнэлгээний бодит бус ашиг	(557)	(11,693)
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	(45,301)	(5,093)
Үндсэн хөрөнгийн элэгдэл	1,157	944
Данснаас хассан үндсэн хөрөнгө	50	4
Гаргасан аккредитивт байгуулсан сан	2,199	-
Дотоодын арилжааны банкуудад олгосон зээлийн үнэ цэнийн бууралтын сан	13,161	18,723
Бусад активын болзошгүй алдагдлын сан	8,057	3,145
Нийгмийн хөгжлийн санд хуваарилсан хөрөнгө	4,000	-
Ажлын капиталын өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны ашиг	21,565	35,444
<i>Үйл ажиллагааны хөрөнгийн өөрчлөлтүүд:-</i>		
Мөнгөжсөн алт ба үнэт металл	74,601	239,556
Санхүүгийн хөрөнгө оруулалт - Борлуулахад бэлэн	(100,803)	(206,449)
Урвуу буцаан худалдан авах хэлцлүүд	(232,655)	(172,696)
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө, хадгаламж	(351,085)	(4,962)
Дотоодын банкуудад олгосон зээл	44,205	(223,785)
Сангийн яаманд олгосон зээл	(237,191)	4,040
Засгийн газрын үнэт цаас	(170,000)	-
Бусад хөрөнгө	(8,890)	(1,045)
Шүүхийн шийдвэрээр байршуулсан хөрөнгө	(127)	(427)
<i>Үйл ажиллагааны пассивын өөрчлөлтүүд:-</i>		
Төв банкны үнэ цаас	272,726	16,361
Гадаад өр төлбөр	351,738	5,463
Засгийн газрын байгууллагуудын харилцах, хадгаламж	487,531	(392,636)
Дотоодын банкуудын харилцах, хадгаламж	315,112	55,499
Бусад пассив	644	(114)
Үйл ажиллагаанд зарцуулсан цэвэр мөнгөн гүйлгээ	467,371	(645,751)
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	1,069	512
Үндсэн хөрөнгийн худалдан авалт	(2,728)	(1,561)
Хөрөнгө оруулалтад ашигласан цэвэр мөнгөн гүйлгээ	(1,659)	(1,049)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Гүйлгээнд гаргасан мөнгөний (бууралт)/өсөлт	(35,378)	43,136
Зээллэгийн эргэн төлөлт	(2,934)	(9,693)
Стэндбай хөтөлбөрийн зээлийн татан авалт	242,980	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	204,668	33,443
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт	670,380	(613,357)
Валютын ханшийн зөрүүний нөлөө	45,301	5,093
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	154,493	762,757
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	29 870,174	154,493

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2009 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

1. БАНКНЫ ТУХАЙ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монголбанк нь Монгол Улсын Засгийн газрын 1924 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн тогтоолоор Монгол Улсын Төв Банк (цаашид Банк гэх) болон байгуулагдсан ба байршил нь: Монгол Улс, Улаанбаатар 46, Бага тойруу 9.

Банк нь бүхий л үйл ажиллагаагаа Монгол Улсад явуулдаг бөгөөд Англи Улсын Лондон хот дахь төлөөлөгчийн газраас өөр хилийн чанадад үйл ажиллагаа явуулдаг салбаргүй болно.

“Банк нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн байгууллага. Банкны үндсэн зорилго нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөгийн тогтвортой байдлыг баталгаажуулах ба санхүүгийн зах зээл, банкны системийн тогтвортой байдлыг хангах замаар тэнцвэртэй, тогтвортой үндэсний эдийн засгийн хөгжлийг дэмжих явдал юм. Монголбанк нь эдгээр зорилгоо биелүүлэхийн тулд дараахь үйл ажиллагаануудыг явуулдаг. Үүнд:

- Төрийн мөнгөний бодлогыг боловсруулж, хэрэгжүүлнэ
- Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүрэг гүйцэтгэх
- Банкны үйл ажиллагаанд хяналт тавих
- Банк хоорондын төлбөр тооцоог зохион байгуулах
- Гадаад валютын улсын нөөцийг эзэмших, зохицуулах
- Гүйлгээнд мөнгөн тэмдэгт гаргах

Банкны 2009 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайлангуудыг гаргахыг Захирлуудын Зөвлөлийн 2010 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн шийдвэрээр зөвшөөрсөн.

2. НИЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД

2.1 ТАЙЛАН БЭЛТГЭХ ҮНДЭСЛЭЛ

Банк нь өөрийн санхүүгийн тайлангуудыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл (НББОУСЗ)-өөс гаргасан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд (СТОУС)-ын дагуу бэлтгэдэг болно.

Банк нь өөрийн санхүүгийн байдлын тайланг хөрвөх чадварын дараалалаар толилуулдаг. Санхүүгийн байдлын тайлангийн өдрийн дараахь 12 сарын хугацаанд (эргэлтийн) ба түүнээс дээш хугацаанд (эргэлтийн бус) эргэн төлөгдөх эсвэл барагдуулах төлбөрүүдийн талаарх шинжилгээг Тодруулга 32-т толилуулсан болно.

Бодит үнэ цэнээрээ хэмжигдэх барилгууд, “Борлуулахад бэлэн” санхүүгийн хөрөнгө оруулалтуудыг эс тооцвол санхүүгийн тайлангуудыг түүхэн өртгийн зарчмаар бэлтгэсэн болно. Санхүүгийн тайлан дахь дүнгүүдийг тодруулгад өөрөөр зааснаас бусад тохиолдолд саяын орноор, Монгол төгрөгөөр тайлагнасан.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2009 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО

(а) Хүүний болон түүнтэй адилтгах орлого ба зардал

“Арилжаалах зорилгоор эзэмшиж байгаа” эсвэл “Бодит үнийн өсөлт бууралт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдэх” гэж ангилагдсан санхүүгийн хэрэглүүрүүдээс бусад бүх хүүтэй санхүүгийн хэрэгслүүдийн хүүний орлого, зардлыг холбогдох санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөрийн үр ашигт хүүний хувийг хэрэглэн дэлгэрэнгүй орлогын тайланд “Хүүний орлого” ба “Хүүний зардал” гэж хүлээн зөвшөөрнө. Үнэ цэнийн бууралтад орсон зээл, урьдчилгааны хүүний орлогоос бусад хүүний орлогыг аккруэл сууриар дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө. Үнэ цэнийн бууралтад орсон санхүүгийн хөрөнгийн хүүний орлогыг үнэ цэнийн бууралтад орсон бүртгэлийн дүнд хэрэглэсэн анхны үр ашигт хүүний хувь хэмжээгээр тооцож хүлээн зөвшөөрнө.

(б) Шимтгэлийн орлого

Банкны шимтгэлийн орлого нь ихэвчлэн банк хоорондын төлбөр тооцоо, гадаад банкуудын төлбөр тооцооны шимтгэлээс бүрддэг. Хураамж ба шимтгэлийн орлогыг ихэвчлэн үйлчилгээ үзүүлсэн хугацаанд нь аккруэл сууриар хүлээн зөвшөөрдөг.

(в) Гадаад валютын хөрвүүлэг

Банк нь санхүүгийн тайлангаа өөрийн үйл ажиллагааны болон тайлагналын мөнгөн нэгж болох Монгол төгрөгөөр гаргадаг. Гадаад валютын гүйлгээг анх бүртгэхдээ гүйлгээ хийгдсэн өдрийн ханшаар үйл ажиллагааны мөнгөн нэгж рүү хөрвүүлж бүртгэнэ. Гадаад валютаар бүртгэгдсэн мөнгөн хөрөнгө ба өр төлбөрүүдийг тайлан тэнцлийн өдрийн ханшаар хөрвүүлдэг. Банк нь гадаад валютаар илэрхийлэгдсэн өөрийн мөнгөн хөрөнгө ба өр төлбөрийг өдөр бүр дахин үнэлж байх бодлого барьдаг. Ханшийн бүх зөрүүг дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

Түүхэн өртөг нь гадаад валютаар хэмжигдэх мөнгөн бус зүйлүүдийг анхны гүйлгээний өдрийн ханшаар хөрвүүлнэ. Бодит үнэ цэнэ нь гадаад валютаар хэмжигдэх мөнгөн бус зүйлүүдийг бодит үнэ цэнэ тодорхойлогдсон өдрийн ханшаар хөрвүүлнэ.

(г) Алт ба үнэт металл

Алтыг бодит үнэлгээгээр нь санхүүгийн байдлын тайланд тусгадаг бөгөөд дахин үнэлгээг өдөр бүр хийдэг. Алтны бодит үнийг тогтоохдоо алтны зах зээлийн үнийг харгалзан үздэг. Дахин үнэлгээний олз, гарзыг дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

Алт, мөнгө, зоос болон түүх соёлын үнэт зүйлсийг өртөг, цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар нь бүртгэдэг.

(д) Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн гүйлгээний тайлангийн зорилгоор мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд касс дахь төгрөг, гадаад валют, богино хугацаат хадгаламж, хугацаагүй хадгаламж орно.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2009 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

(e) **Санхүүгийн хэрэглүүр - анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт**

(i) *Хүлээн зөвшөөрөх өдөр*

Санхүүгийн хөрөнгө худалдан авах, худалдахад холбогдох хөрөнгийг нь зах зээлийн журам, хэлцлээр тогтоосон хугацаанд зайлшгүй шилжүүлэхийг шаарддаг эдгээр худалдан авалт, борлуулалтыг арилжаа хийгдсэн өдөр нь хүлээн зөвшөөрдөг. Өөрөөр хэлбэл банк хөрөнгийг худалдах, худалдан авахыг амласан өдөр хүлээн зөвшөөрнө. Үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүдийг арилжааны өдрөөр хүлээн зөвшөөрнө.

(ii) *Санхүүгийн хэрэглүүрийн анхны хүлээн зөвшөөрөлт*

Анх хүлээн зөвшөөрч буй санхүүгийн хэрэглүүрүүдийн ангилал нь тэдгээрийн зориулалт, шинж чанараас шалтгаална. Санхүүгийн хэрэглүүрүүдийг анхлан бодит үнээр нь хэмжих ба харин бодит үнийн өөрчлөлт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдэхгүй санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн хувьд бодит үнэ дээр тэдгээртэй шууд холбоотой худалдан авалтын эсвэл гаргалтын ахиу зардлуудыг нэмсэн дүнгээр бүртгэнэ.

(iii) *Бодит үнийн өөрчлөлтийг нь орлого, зардлын дансанд бүртгэдэг үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүд*

Үүсмэл санхүүгийн хэрэглүүрт алтны опцион, валютын ханшны форвард гэрээ хэлцлүүд, гадаад валютын опцион зэрэг багтана. Үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүдийг бодит үнэ цэнээр нь бүртгэдэг ба бодит үнэ цэнэ нь эерэг байгаа үед хөрөнгө, харин сөрөг байгаа үед өр төлбөр гэж бүртгэнэ. Арилжаалах зорилгоор эзэмшиж буй үүсмэл санхүүгийн хэрэглүүдийн бодит үнийн өөрчлөлтийг “Арилжааны цэвэр орлого”-д бүртгэдэг.

Хөрвөх бондод агуулагдсан үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүд гэх мэт өөр бусад санхүүгийн хэрэглүүрт агуулагдсан үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүдийг салгаж авч үзэх ёстой ба агуулагдсан болон агуулагч гэрээнүүдийн эдийн засгийн үзүүлэлтүүд болон эрсдлүүд нь нягт хамааралгүй, мөн агуулагч гэрээг нь арилжаалах зорилгоор эзэмшээгүй ба анхны хүлээн зөвшөөрөлтөөр “Бодит үнийн өөрчлөлт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдэх”-д ангилаагүй байвал тэдгээрийг бодит үнээр нь бүртгэнэ. Агуулагч гэрээнээс нь салгасан үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүдийг арилжааны багц дахь бодит үнэ цэнийн өөрчлөлтөөр нь бүртгэх ба уг өөрчлөлтийг нь орлого, зарлагын дансанд бүртгэнэ.

(iv) *Арилжаалах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөр*

“Арилжаалах зорилгоор эзэмшиж буй” санхүүгийн хэрэглүүдийг (үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүд үүнд орохгүй) багтаасан “Арилжаалах зорилгоор эзэмшиж буй” санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөрүүдийг тайлан тэнцэлд бодит үнээр нь бүртгэнэ. “Арилжааны цэвэр орлого”-д бодит үнийн өөрчлөлтийг тусгана.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2009 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

(e) Санхүүгийн хэрэглүүр- анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт (үргэлжлэл)

(iv) *Арилжаалах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөр (үргэлжлэл)*

Хүүний болон ногдол ашгийн орлого эсвэл зардлыг гэрээний нөхцлийн дагуу эсвэл төлбөрийн эрх үүссэн үед нь “Хүүний орлого” эсвэл “Хүүний зардал” дансанд бүртгэнэ. Энэ бүлэгт ойрын хугацаанд борлуулах эсвэл эргүүлэн худалдан авах зорилгоор олж авсан өрийн бичгүүд, энгийн хувьцаа, үнэт цаасууд орсон.

(v) *Бодит үнийн өөрчлөлт нь орлого, зардлын дансанд бүртгэгддэг санхүүгийн хөрөнгө болон өр төлбөр*

Дараах нөхцлүүд хангагдсан үед санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийг анхлан хүлээн зөвшөөрөхдөө энэ ангилалд оруулахаар шийдвэрлэж болно. Үүнд:

- энэхүү шийдвэр нь активыг хэмжих эсвэл активаас үүсэх олз гарзыг ялгаатай сууриар орлого, зардалд хүлээн зөвшөөрсөнөөс бий болох тууштай бус байдлыг арилгах эсвэл дорвитойгоор бууруулах эсвэл;
- эдгээр санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр нь санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн бүлгийн нэг хэсэг эсвэл аль аль нь бөгөөд тэдгээрийг хүчин төгөлдөр эрсдэлийн удирдлагын бодлого эсвэл хөрөнгө оруулалтын стратегийн дагуу удирдаж, гүйцэтгэлийг нь бодит үнэ дээр нь суурилан хэмждэг; эсвэл
- санхүүгийн хэрэглүүрт агуулагдсан үүсмэл санхүүгийн хэрэгсэл багтаж байгаа бол (гэхдээ агуулагдсан үүсмэл санхүүгийн хэрэглүүр нь мөнгөн урсгалыг нь ихээхэн хэмжээгээр өөрчлөхгүй нь, эсвэл бага хэмжээний судалгааны үндсэн дээр эсвэл огт судалгаагүйгээр уг хэрэглүүр тусдаа бүртгэгдэхгүй нь тодорхой байгаагаас бусад тохиолдолд).

Бодит үнийн өөрчлөлт нь орлого, зардлын дансанд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг санхүүгийн байдлын тайланд бодит үнээр нь тусгана. Бодит үнийн өөрчлөлтийг “Валютын ханшийн зөрүүний цэвэр ашиг” дансанд бүртгэнэ. Орж ирэх эсвэл төлөх хүүг гэрээний нөхцлийн дагуу хүүний орлого, зардалд хуримтлуулж, ногдол ашгийн орлогыг тус ногдол ашгийг хүртэх эрх үүссэн үед нь “Үйл ажиллагааны бусад орлого”-д бүртгэнэ.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2009 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

(e) Санхүүгийн хэрэглүүр- анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт (үргэлжлэл)

(vi) *‘Анхны өдөр’-ийн ашиг*

Идэвхигүй зах зээл дээрх арилжааны үнэ нь ижил хэрэглүүрийн хувьд зах зээл дээр ажиглаж болохуйц одоогийн зах зээлийн бодит үнээс зөрүүтэй эсвэл зөвхөн зах зээл дээр ажиглаж болохуйц өгөгдлийг багтаасан хувьсагчтай үнэлгээний загварт үндэслэн тогтоосон бодит үнээс зөрүүтэй байвал уг зөрүүг (энэ нь бодит үнэ ба арилжааны үнийн зөрүү буюу анхны өдрийн ашиг юм) Банк дэлгэрэнгүй орлогын тайлангийн “Валютын ханшийн зөрүүний цэвэр ашиг”-д шууд хүлээн зөвшөөрнө. Ажиглах боломжгүй өгөгдлийг ашигласан тохиолдолд арилжааны үнийн зөрүү ба загварын үнийн зөрүүг дэлгэрэнгүй орлогын тайланд өгөгдлүүд нь ажиглах үед болохуйц болох үед эсвэл тухайн хэрэгслийг үл хүлээн зөвшөөрөх үед л хүлээн зөвшөөрнө.

(vii) *Дуусгавар хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө оруулалт*

Банк нь дуусгавар хугацаа хүртэл эзэмших зорилго, чадвартай, тогтмол эсвэл тодорхойлж болохуйц төлбөртэй ба тогтоосон хугацаатай санхүүгийн хэрэглүүрүүдийг дуусгавар хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө оруулалт гэнэ. Эхний хэмжилтийн дараа дуусгавар хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө оруулалтыг үр ашигт хүүний арга ашиглаж тооцсон хорогдуулсан өртгөөс үнэ цэнийн бууралтын санг хассан дүнгээр хэмжинэ. Хорогдуулсан өртгийг үр ашигт хүүний салшгүй хэсэг болох худалдан авалтын урамшуулал, хөнгөлөлт болон шимтгэлийг оролцуулан тооцдог. Хорогдуулалт нь дэлгэрэнгүй орлогын тайлангийн “Хүү болон түүнтэй адилтгах орлого”-д багтана. Уг хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтаас үүссэн алдагдлыг дэлгэрэнгүй орлогын тайлангийн “Санхүүгийн хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтын алдагдал” хэсэгт хүлээн зөвшөөрнө.

(viii) *Банкуудад байршуулсан харилцах, хадгаламж ба зээл, урьдчилгаа*

Бусад банкуудад байршуулсан харилцах, хадгаламж ба зээл, урьдчилгаа нь идэвхтэй зах зээл дээр бүртгэлгүй, тогтмол эсвэл тодорхойлох боломжтой төлбөрүүдтэй, тогтсон дуусгавар хугацаатай, “Зээл ба авлага” гэж ангилагдах санхүүгийн хэрэглүүрүүд юм. Анх хэмжсэний дараа бусад банкуудад байршуулсан харилцах, хадгаламж ба зээл, урьдчилгааг үр ашигт хүүгийн аргыг хэрэглэн хорогдуулсан өртгөөс үнэ цэнэ бууралтын санг хассан дүнгээр бүртгэнэ. Хорогдуулсан өртгийг үр ашигт хүүгийн салшгүй хэсэг болох худалдан авалтын урамшуулал, хөнгөлөлт болон шимтгэлийг оролцуулан тооцно. Хорогдуулалт нь дэлгэрэнгүй орлогын тайлангийн “Хүү болон түүнтэй адилтгах орлого”-д багтана. Уг хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтаас үүссэн алдагдалыг дэлгэрэнгүй орлогын тайлангийн “Үнэ цэнийн бууралтын алдагдлын зардал” хэсэгт хүлээн зөвшөөрнө.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2009 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

- (е) Санхүүгийн хэрэглүүр- анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт (үргэлжлэл)

(ix) Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалт (үргэлжлэл)

Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалт гэж анхны хүлээн зөвшөөрөлтөөр ийнхүү ангилагдсан эсвэл бодит үнийн өөрчлөлт нь орлого, зардлын дансанд бүртгэгддэг, дуусгавар хугацаа хүртэл эзэмшиж эсвэл зээл ба урьдчилгаа гэсэн ангилалд багтаагүй санхүүгийн хөрөнгийг хэлнэ. Эдгээрт өөрийн хөрөнгийн хэрэгсэл, хамтын санд оруулсан хөрөнгө оруулалтууд, мөнгөний зах зээлийн болон өрийн хэрэглүүрүүд багтдаг.

Анх хүлээн зөвшөөрсний дараа борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтыг бодит үнээр нь хэмждэг. Хэрэгжээгүй ашиг алдагдлыг өөрийн хөрөнгийн “Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын нөөц”-д бүртгэдэг. Хөрөнгө оруулалтыг борлуулахад, өмнө хүлээн зөвшөөрсөн хуримтлагдсан ашиг эсвэл алдагдлыг дэлгэрэнгүй орлогын тайланд “Валютын ханшийн зөрүүний цэвэр ашиг”-аар хүлээн зөвшөөрнө. Банк нь нэг төрлийн үнэт цаасанд нэгээс илүү удаа хөрөнгө оруулсан бол тэдгээрийг “эхэлж авснаа эхэлж зарлагдах” зарчмыг баримтлан борлуулсан гэж үзнэ.

Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтыг эзэмшиж байх хугацаанд олсон хүүг үр ашигт хүүний аргаар тооцон, хүүний орлого гэж тайлагнадаг. Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтыг эзэмшиж байх хугацаанд олсон ногдол ашгийг төлбөрийн эрх нь тогтоогдсон үед дэлгэрэнгүй орлогын тайланд “Үйл ажиллагааны бусад орлого”-д хүлээн зөвшөөрдөг. Ийнхүү хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтаас үүссэн алдагдлыг дэлгэрэнгүй орлогын тайлангийн “Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын алдагдал”-д хүлээн зөвшөөрч, борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын нөөцөөс хасч өгнө.

(x) Төв Банкны үнэт цаас ба гадаад өр төлбөр

Гэрээт зохицуулалтын агуулга нь өөрийн тодорхой тооны хувьцааны оронд бэлэн мөнгө эсвэл өөр ямар нэг санхүүгийн хөрөнгийг өгөх үүргийг Банкнд үүсгэж байгаа үед, Банкнаас гаргасан бөгөөд “Бодит үнийн өөрчлөлт нь орлого, зардлын дансанд бүртгэгдэх” гэж ангилагдаагүй санхүүгийн хэрэглүүрүүд эсвэл тэдгээрийн бүрдэл хэсгүүдийг “Төв банкны үнэт цаас ба гадаад өр төлбөр” гэсэн нэрээр өр төлбөрийн хэсэгт ангилна. Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн аль алиных нь элементийг агуулсан нийлмэл санхүүгийн хэрэглүүрүүдийн бүрэлдэхүүн хэсгүүдийг салгаж тус тусад нь бүртгэх бөгөөд өөрийн хөрөнгийн бүрэлдэхүүн хэсгийн дүн нь нийт дүнгээс өр төлбөрийн хэсгийн бодит үнэ (уг өр төлбөр үүссэн өдрийн бодит үнэ)-ийг хассан дүн байна.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2009 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

(ө) Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт

Анх хүлээн зөвшөөрсний дараа буюу дараагийн тайлант хугацаанд Төв Банкны үнэт цаас ба гадаад өр төлбөрийг үр ашигт хүүний аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ. Хорогдуулсан өртгийг тооцохдоо эдгээрийг гаргах эсвэл үүсгэх үеийн хөнгөлөлт эсвэл урамшуулал, үр ашигт хүүг бүрдүүлж буй зардлуудыг авч үзнэ.

(i) Санхүүгийн хөрөнгө

Дараах тохиолдолд санхүүгийн хөрөнгийг (хэрэглэх боломжтой бол, санхүүгийн хөрөнгийн нэг хэсгийг эсвэл хоорондоо төсөөтэй нэг бүлэг санхүүгийн хөрөнгүүдийг) үл хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Тухайн хөрөнгөөс мөнгөн урсгал хүлээн авах эрх нь дууссан; эсвэл
- Банк тухайн хөрөнгөөс мөнгөн урсгал авах эрхээ шилжүүлсэн эсвэл “дамжуулан өнгөрөөх” хэлцлийн дагуу хүлээн авсан мөнгөө нийт дүнгээр нь удаан хугацаагаар саатуулалгүйгээр гуравдагч талд төлөх үүрэг хүлээсэн бол
- Банк хөрөнгийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг шилжүүлсэн эсвэл Банк тухайн хөрөнгөтэй холбоотой эрсдэл ба өгөөжийг их хэмжээгээр шилжүүлээгүй мөн авч үлдээгүй боловч хөрөнгийн хяналтыг шилжүүлсэн

Банк хөрөнгөөс мөнгө хүлээн авах эрхээ шилжүүлсэн эсвэл “дамжуулан өнгөрөөх” хэлцэл хийсэн боловч хөрөнгөтэй холбоотой ихэнх эрсдэл ба өгөөжийг болон хяналтыг шилжүүлээгүй мөн авч үлдээгүй тохиолдолд хөрөнгийг Банкны уг хөрөнгөд үргэлжлүүлэн оролцсоор байх хэмжээгээр нь хүлээн зөвшөөрнө. Энэхүү үргэлжилсэн оролцоо нь шилжүүлсэн хөрөнгийн баталгаа хэлбэртэй байвал оролцоог тус хөрөнгийн анхны бүртгэлийн дүн ба Банкны төлөх шаардлагатай болох хамгийн их дүнгийн аль багаар хэмжинэ.

Шилжүүлсэн хөрөнгөтэй холбоотой үргэлжилсэн оролцоо нь борлуулсан ба/эсвэл худалдан авсан опцион (үүнд бэлэн мөнгөөр төлбөр хийгддэг опцион эсвэл ижил төрлийн хэлэлцээр багтсан) хэлбэртэй байвал тус оролцооны дүн нь Банкны буцаан худалдан авч болзошгүй шилжүүлсэн хөрөнгийн дүн юм. Гэсэн хэдий ч, бодит үнэ цэнээр хэмжигддэг хөрөнгийг худалдах опционтой үед Банкны үргэлжлүүлэн оролцсоор байх хэмжээ нь шилжүүлсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ болон опцион хэрэгжих үнийн аль багаар нь хязгаарлагдана.

(ii) Санхүүгийн өр төлбөр

Санхүүгийн өр төлбөрийг төлөхөөс чөлөөлөгдсөн, өр төлбөр цуцлагдсан эсвэл хугацаа нь дууссан бол үл хүлээн зөвшөөрдөг. Хэрэв одоо оршин байгаа санхүүгийн өр төлбөрийн зээлдүүлэгч нь хэвээрээ боловч ялгаатай нөхцөлтэй зээлийн гэрээгээр орлуулсан эсвэл одоо байгаа зээлийн нөхцөл эрс өөрчлөгдсөн бол эдгээр өөрчлөлт шинэчлэлтийн дагуу өмнөх санхүүгийн өр төлбөрийг үл хүлээн зөвшөөрөх ба шинэ өр төлбөрийг хүлээн зөвшөөрч, тус тусынх нь дансны үнийн зөрүүг дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2009 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

(ж) Бодит үнэ цэнийн тодорхойлолт

Идэвхтэй зах зээл дээр арилжаалагдаж буй санхүүгийн хэрэглүүрүүдийн тайлан тэнцлийн өдрийн бодит үнэ нь аливаа гүйлгээний зардлыг хасаагүй биржийн ханш болон диллерийн үнэ (урт позицийн хувьд авах үнэ, богино позицийн хувьд зарах үнэ) дээр үндэслэнэ. Идэвхтэй зах зээл дээр бүртгэлгүй санхүүгийн хэрэглүүрүүдийн хувьд бодит үнийг нь тохиромжтой үнэлгээний аргуудыг ашиглан тодорхойлно. Эдгээр аргуудад цэвэр өнөөгийн үнэ цэнийн арга, ажиглаж болохуйц зах зээлийн үнэтэй, төсөөтэй өөр бусад санхүүгийн хэрэглүүрүүдтэй харьцуулах арга, опционы үнэлгээний загвар, холбогдох бусад үнэлгээний загварууд багтана.

Санхүүгийн хэрэглүүрүүдийн бодит үнэ цэнийн шинжилгээ ба тэдгээрийг хэрхэн хэмждэг талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 31-д өгсөн.

(з) Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Банк нь санхүүгийн хөрөнгө эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгүүд нь үнэ цэнийн бууралтад орсныг нотлох бодит нотолгоо байгаа эсэхийг санхүүгийн байдлын тайлангийн өдөр бүр үнэлж үзнэ. Хэрэв хөрөнгийг анхлан хүлээн зөвшөөрсний дараа нэг буюу түүнээс олон тооны “Алдагдлын тохиолдол”-ын улмаас үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо бий болсон ба уг “Алдагдлын тохиолдол” нь санхүүгийн хөрөнгө эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийн бодитойгоор тооцоолох боломжтой ирээдүйн мөнгөн урсгалд нөлөөлж байгаа үед санхүүгийн хөрөнгийг эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийг үнэ цэнийн бууралтад орсон гэж үзнэ. Үнэ цэнийн бууралтын нотолгоонд зээлдэгч эсвэл бүлэг зээлдэгчид нь санхүүгийн томоохон хүндрэлд орсон, зээлийн хүү болон үндсэн төлбөр зөрчилд орсон, дампуурал эсвэл санхүүгийн өөр бусад дахин зохион байгуулалтанд орох магадлалтай болсон, зөрчилтэй холбоотой эдийн засгийн нөхцөл байдалд гарсан өөрчлөлт гэх мэт тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалд хэмжиж болохуйц бууралт байгааг харуулсан бодит өгөгдөл бий болох зэрэг орно.

(i) Бусад банкуудад байршуулсан харилцах, хадгаламж ба олгосон зээл, урьдчилгаа

Хорогдуулсан өртгөөр бүртгэгддэг, бусад банкуудад байршуулсан харилцах, хадгаламж ба олгосон зээл, урьдчилгааны дүнгүүдийн хувьд Банк нь эхлээд дангаараа чухал ач холбогдолтой санхүүгийн хөрөнгө тус бүрийн хувьд үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байгаа эсэхийг нэг бүрчлэн (тусгайлан), дараа нь чухал ач холбогдолгүй санхүүгийн хөрөнгүүдийг нийлүүлэн (бүлгээр нь) үнэлнэ.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2009 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

(3) Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)

(i) Бусад банкуудад байршуулсан харилцах, хадгаламж ба олгосон зээл, урьдчилгаа (үргэлжлэл)

Хэрэв Банк нь нэг бүрчлэн үнэлэгдсэн санхүүгийн хөрөнгийн үнэлгээний хувьд (чухал ач холбогдолтой, холбогдолгүй эсэхийг үл харгалзан) үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байхгүй гэж үзвэл ойролцоо зээлийн эрсдлийн шинж чанар бүхий санхүүгийн хөрөнгийн бүлэгт оруулан үнэ цэнийн бууралтыг нь нэгдсэн байдлаар үнэлдэг. Үнэ цэнийн бууралтын нэг бүрчилсэн үнэлгээ хийгдсэн, үнэ цэнийн бууралтын алдагдал нь хүлээн зөвшөөрөгдсөн, эсвэл үргэлжилж буй хөрөнгийг бүлгийн үнэ цэнийн бууралтын үнэлгээнд оруулахгүй.

Үнэ цэнийн бууралтын алдагдал гарсан талаар бодит нотолгоо байгаа бол алдагдлыг тухайн хөрөнгийн бүртгэлийн дүн ба ирээдүйд орж ирэхээр тооцоолсон мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийн (бодитоор тохиолдоогүй ирээдүйд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг оруулахгүй) зөрүүгээр хэмжинэ. Хөрөнгийн бүртгэлийн дүнг эрсдлийн сангийн дансаар бууруулах ба алдагдлын дүнг орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрнө. Хүүний орлогыг хөрөнгийн анхны, үр ашигт хүүний хувиар бууруулсан хөрөнгийн бүртгэлийн дүнгээс үргэлжлүүлэн тооцно. Цаашид эргэн төлөгдөх ямар нэг бодит чиг хандлага байхгүй ба барьцаа хөрөнгө нь бүрэн ашиглагдсан эсвэл банкинд бүрэн шилжсэн үед зээлийг холбогдох зээлийн эрсдлийн сангийн хамт данснаас хасна. Хэрэв дараагийн жил нь үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрсний дараах үйл явдлын улмаас тооцоолсон үнэ цэнийн бууралтын алдагдал өсөх эсвэл буурвал эрсдэлийн санг тохируулах замаар үнэ цэнийн бууралтын алдагдлыг өсгөж эсвэл бууруулж болно. Хэрэв өмнө данснаас хассан байсан зээл эргэн төлөгдвөл тус төлөлтийг “Зээлийн алдагдлын зардал” дансны кредит талд бичнэ.

Орж ирнэ гэж тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийг санхүүгийн хөрөнгийн анхны, үр ашигт хүүний хувиар бууруулан тооцдог. Зээлийн хүүний хувь нь хөвөгч байх нөхцөлд үнэ цэнийн бууралтын алдагдлыг хэмжих хөнгөлөлтийн хувь нь өнөөгийн үр ашигт хүүний хувьтай тэнцүү байна. Барьцаатай санхүүгийн хөрөнгийн ирээдүйд орж ирэхээр тооцоолсон мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийн тооцоо нь барьцааг хураан авах нь боломжтой эсэхээс үл хамааран тус барьцааг хураан авч, албадан борлуулахад гарах зардлыг хассаны дараах мөнгөн урсгалыг харуулдаг.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2009 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

(з) Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)

- (i) Бусад банкуудад байршуулсан харилцах, хадгаламж ба олгосон зээл, урьдчилгаа (үргэлжлэл)

Үнэ цэнийн бууралтыг нэгдсэн байдлаар үнэлэхийн тулд санхүүгийн хөрөнгийн төрөл, хамаарах салбар, газар зүйн байрлал, барьцаа хөрөнгийн төрөл, хугацаа хэтрэлтийн байдал болон бусад гол хүчин зүйлс зэрэг зээлийн эрсдлийн шинж чанарыг агуулсан банкны дотоод зээллэгийн ангиллын системд үндэслэн тэдгээрийг бүлэглэнэ.

Үнэ цэнийн бууралтын бүлгийн үнэлгээнд хамрагдсан бүлэг санхүүгийн хөрөнгийн ирээдүйн мөнгөн урсгалыг ойролцоолон тооцохдоо бүлэгт багтаж буй хөрөнгүүдийн зээлийн эрсдэлийн шинж чанартай холбоотойгоор гарч байсан түүхэн алдагдалын хувь хэмжээг ашиглана. Өнөө үед үгүй болсон түүхэн нөхцөл байдлын нөлөөг арилгах, түүхэн алдагдлын суурилж буй жилүүдэд хамааралгүй өнөөгийн нөхцөл байдлын нөлөөг харуулах үүднээс түүхэн алдагдлын мэдээнд өнөө үед ажиглагдахуйц өгөгдлүүдэд үндэслэн тохиргоо хийнэ. Ирээдүйд орж ирэх мөнгөн урсгалын өөрчлөлтийн тооцоолол нь жил жилийн ажиглаж болохуйц холбогдох өгөгдлүүдийн өөрчлөлтүүдийг тусгасан. (Үүнд: ажилгүйдлийн түвшин, эд хөрөнгийн үнэ, өргөн хэрэглээний барааны үнэ, төлбөрийн чадавхи, алдагдлыг илэрхийлэх хүчин зүйлс бүлгээр болон ач холбогдлоор нь). Ирээдүйд орж ирэх мөнгөн урсгалыг тооцоолоход ашигласан аргачлал, таамаглалуудыг тооцоолсон алдагдал, бодитоор хүлээсэн алдагдлын хоорондын зөрүүг багасгах зорилгоор тогтмол хянана.

(ii) Дуусгавар хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө оруулалт

Банк нь дуусгавар хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт нэг бүр дээр үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байгаа эсэхийг үнэлж үзнэ. Үнэ цэнэ бууралтын алдагдал гарсан талаар бодит нотолгоо байгаа бол алдагдлыг тухайн хөрөнгийн бүртгэлийн дүн ба тооцоолсон ирээдүйд орж ирэх мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнэ хоёрын зөрүүгээр хэмжинэ. Хөрөнгийн бүртгэлийн дүнг бууруулж, алдагдалын дүнг дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

Хэрэв дараагийн тайлант жилд тооцоолж байсан үнэ цэнийн бууралтын алдагдлын хэмжээ нь уг үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрсний дараа тохиолдсон үйл явдлын улмаас буурвал өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын алдагдлыг “Санхүүгийн хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтын алдагдал” дансны кредитэд бүртгэнэ.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2009 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

(3) Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)

(iii) Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалт

Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтын хувьд, Банк нь хөрөнгө оруулалт эсвэл бүлэг хөрөнгө оруулалт нь үнэ цэнийн бууралтад орсныг нотлох бодит нотолгоо байгаа эсэхийг санхүүгийн байдлын тайлангийн өдөр бүр үнэлж үзнэ.

“Борлуулахад бэлэн” гэж ангилагдсан өөрийн хөрөнгийн хөрөнгө оруулалтын хувьд үнэ цэнийн бууралтын бодит нотолгоонд бодит үнэ цэнэ нь тус хэрэглүүрийн өртгөөс их хэмжээгээр эсвэл тогтмол буурч байх явдал ордог. Үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байгаа тохиолдолд хуримтлагдсан алдагдал (худалдан авалт ба өнөөгийн бодит үнэ цэнэ хоёрын зөрүүнээс дэлгэрэнгүй орлогын тайланд өмнө нь хүлээн зөвшөөрсөн байсан тухайн хөрөнгө оруулалттай холбоотой үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр хэмжигдэх)-ыг өөрийн хөрөнгөөс хасч дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө. Өөрийн хөрөнгийн хөрөнгө оруулалтын үнэ цэнэ бууралтын алдагдлын буцаалтыг дэлгэрэнгүй орлогын тайлангаар дамжуулдаггүй, үнэ цэнийн бууралтын дараах бодит үнийн өсөлтийг өөрийн хөрөнгөд тусгана.

“Борлуулахад бэлэн” гэж ангилагдсан өрийн хөрөнгийн хэрэгслийн хувьд түүний үнэ цэнийн бууралтыг хорогдуулсан өртгөөр бүртгэгдэх санхүүгийн хөрөнгүүдтэй адил шалгуур үзүүлэлтүүд дээр суурилан үнэлнэ. Зээлийн бууруулсан бүртгэлийн дүнгээс анхны үр ашигт хүүний хувь хэмжээгээр тооцон, хүүг үргэлжлүүлэн хуримтлуулах ба “Хүүний ба түүнтэй адилтгах орлого”-ын нэг хэсэг болгон бүртгэнэ. Хэрэв дараагийн тайлант жилд өрийн хэрэгслийн бодит үнэ цэнэ нь өссөн ба уг өсөлт нь үнэ цэнэ бууралтын алдагдлыг дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрсний дараа тохиолдсон үйл явдалтай уялдаатай болох нь тогтоогдсон бол, үнэ цэнэ бууралтын алдагдлыг дэлгэрэнгүй орлогын тайлангаар дамжуулан буцаана.

(iv) Зээлийн шинэчилсэн гэрээ

Банк нь барьцаа хөрөнгийг хурааж өөрийн болгохоос илүүтэйгээр аль болох гэрээг шинэчлэн байгуулах боломжийг хайж байдаг. Үүнд зээлийн эргэн төлөлтийн хуваарийг сунгах, зээлийн шинэ нөхцлийг санал болгох зэрэг ойлголтыг хамруулж болох юм. Зээлийн гэрээг нэгэнт шинэчлэн байгуулсан бол зээлийг хугацаа хэтэрсэн гэж үзэхгүй. Гэрээнд заасан зээлийн шалгуур нөхцөлүүд биелж буй эсэх, ирээдүйн зээл төлөлт хийгдэх баталгаа байгаа эсэхийг баталгаажуулах үүднээс зээлийн шинэчилсэн гэрээнд удирдлагын зүгээс байнгын хяналт тавин ажилладаг. Эдгээр зээл нь зээлийн анхны үр ашигт хүүний хувиар тооцоологддог нэг бүрчилсэн болон нийлмэл үнэ цэнийн бууралтын үнэлгээнд хамрагдсаар байх юм.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2009 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

(и) Санхүүгийн хэрэглүүрүүдийг цэвэршүүлэх

Хэрэв байгууллага нь хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг цэвэршүүлэх хуулиар олгогдсон эрхтэй, тооцоог цэвэр дүнгээр нь барагдуулах, эсвэл хөрөнгийг борлуулж өр төлбөрийг нь барагдуулах ажлыг нэгэн зэрэг хийхээр зэхэж байгаа л бол санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрүүдийг хооронд нь цэвэршүүлэн, цэвэр дүнгээр санхүүгийн байдлын тайланд толилуулах эрхтэй. Мастер цэвэршүүлэлт гэрээнүүдийн хувьд энэ нь хэрэгждэггүй ба холбогдох хөрөнгө болон өр төлбөрийг нийт дүнгээр нь санхүүгийн байдлын тайланд тус тусад нь толилуулдаг.

(й) Үндсэн хөрөнгө

Бүх үндсэн хөрөнгийг өртгөөр нь анх бүртгэдэг. Дараагийн тайлант хугацаанд гарсан зардлыг тухайн зардалтай холбогдсон ирээдүйн эдийн засгийн үр өгөөжийг Банк хүртэх магадлалтай ба өртгийг нь найдвартайгаар хэмжих боломжтой тохиолдолд л хөрөнгийн бүртгэлийн дүнд нэмж эсвэл тусдаа хөрөнгө болгох хоёрын аль таарамжтай гэж үзсэнээр нь хүлээн зөвшөөрдөг. Аливаа сольсон хэсгийн бүртгэлийн дүнг үл хүлээн зөвшөөрнө. Бүх урсгал засварыг тэдгээрийн гарсан тайлангийн хугацаанд дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг.

Хүлээн зөвшөөрсний дараахь үед барилга байшинг дахин үнэлсэн дүн (дахин үнэлгээний өдрийн бодит үнээс хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүн)-гээр илэрхийлдэг. Бодит үнийг мэргэжлийн үнэлгээчийн хийсэн үнэлгээгээр гаргаж ирсэн зах зээлд суурилсан нотолгоогоор тодорхойлно. Дахин үнэлэгдсэн хөрөнгүүдийн бодит үнэ цэнийг тэдгээр хөрөнгүүдийн бүртгэлийн дүнгээс их зөрүүтэй байлгахгүй байх үүднээс таван жил тутамд нэг удаа үндсэн хөрөнгүүдийг дахин үнэлнэ. Дахин үнэлгээний аливаа нэмэгдлийг өөрийн хөрөнгө доторх дахин үнэлгээний санд бүртгэнэ. Дахин үнэлгээний аливаа нэг нэмэгдлээс эхлээд тухайн хөрөнгө дээр өмнө нь үүсч, орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрсөн дахин үнэлгээний бууралтыг буцааж (энэ тохиолдолд өсөлтийг өмнө хүлээн зөвшөөрсөн бууралтын хэмжээгээр орлого, үр дүнгийн тайланд орлогоор хүлээн зөвшөөрнө), үлдэх дүнг өөрийн хөрөнгийн дахин үнэлгээний санд нэмж бүртгэнэ. Дахин үнэлгээний бууралтыг эхлээд тухайн хөрөнгө дээр өмнө нь хүлээн зөвшөөрсөн, хэрэглэгдээгүй дахин үнэлгээний нэмэгдлээс суутгах бөгөөд үүний дараа үлдэх дүнг орлого үр дүнгийн тайланд зардлаар хүлээн зөвшөөрнө. Хөрөнгийг борлуулах эсвэл данснаас хасах үед тодорхой нэг хөрөнгөтэй холбоотой аливаа нэг дахин үнэлгээний санг хуримтлагдсан ашигт шууд шилжүүлнэ.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2009 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

(й) Үндсэн хөрөнгө (үргэлжлэл)

Хүлээн зөвшөөрсний дараах үед барилга байшингаас бусад үндсэн хөрөнгийг хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан өртгөөр илэрхийлдэг.

Дуусаагүй барилгад элэгдэл байгуулдаггүй. Үндсэн хөрөнгийн элэгдлийг үндсэн хөрөнгийн төрөл бүрээр, дараах ашиглалтын жилийг үндэслэн шулуун шугамын аргаар байгуулдаг. Үүнд:

Барилга, байшин	25 - 60 жил
Тавилга, тоног төхөөрөмж	8 - 10 жил
Компьютер	5 - 8 жил
Тээврийн хэрэгсэл	6 - 8 жил

Үндсэн хөрөнгийн дүн, элэгдүүлэх хугацаа, арга нь өмнө хийгдсэн тооцоолол ба үндсэн хөрөнгөд агуулагдаж буй ирээдүйн эдийн засгийн өгөөжийн хүлээгдэж буй хэрэглээний хэв загварт нийцэж байгаа гэдгийг баталгаажуулах үүднээс үндсэн хөрөнгийн үлдэх өртөг, ашиглалтын хугацаа, элэгдлийн аргыг санхүүгийн жилийн эцэс бүрт хянаж үздэг.

Үндсэн хөрөнгийг худалдан борлуулах үед эсвэл тэдгээрийн ашиглалтаас ирээдүйд эдийн засгийн үр өгөөж орж ирэхгүй гэж үзсэн үед бүртгэлээс хасна. Үндсэн хөрөнгийн борлуулалтын цэвэр орлого (хэрэв байгаа бол), дансны цэвэр дүн хоёрын зөрүүг дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг ба тухайн хөрөнгийн дахин үнэлгээний хэрэглэгдээгүй хэсгийг хуримтлагдсан ашигт шууд хуваарилна.

(к) Орлогын албан татвар

Монгол Улсын “Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын тухай хууль”-д заасны дагуу Банк нь орлогын албан татвараас чөлөөлөгддөг.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2009 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

(л) Санхүүгийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Хөрөнгө нь үнэ цэнийн бууралтад орсон байж болох шинж тэмдэг байгаа эсэхийг Банк тайлант хугацаа тутамд шалгаж үздэг. Хэрэв тийм шинж тэмдэг илэрсэн эсвэл жилд нэг удаа хийдэг хөрөнгийн үнэ цэнийн бууралтын тестийг хийж гүйцэтгэх шаардлагатай үед Банк нь хөрөнгөөс цуглуулан авах боломжтой дүнг тооцож үздэг. Цуглуулан авах дүн нь хөрөнгийн эсвэл бэлэн мөнгө бий болгогч нэгжийн бодит үнэ цэнэ (борлуулалтын зардлыг хасаж тооцсон) ба ашиглалтын өртөг хоёрын аль өндөр нь байна. Хөрөнгийн дансны дүн нь цуглуулан авах дүнгээс илүү байгаа үед хөрөнгийг үнэ цэнийн бууралтад орсон гэж үзэн цуглуулан авах дүнгээр нь бууруулан бүртгэнэ. Ашиглалтын үнийг үнэлэхдээ, тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалыг мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ ба хөрөнгөд харгалзах эрсдлүүдийн талаарх өнөөгийн зах зээлийн үнэлгээнүүдийг тусгасан татварын өмнөх хөнгөлөлтийн хувь хэмжээгээр бууруулан өнөөгийн үнэ цэнийг олно. Тайлан тэнцлийн өдөр бүр өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын алдагдал арилсан эсвэл буурсан эсэх талаар ямар нэгэн шинж тэмдэг байгаа эсэх талаар үнэлгээг хийдэг.

Хэрэв тийм шинж тэмдэг илэрвэл нөхөн төлөгдөх дүнг ойролцоолон тооцож үзнэ. Хамгийн сүүлд үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрснөөс хойш хөрөнгийн цуглуулан авах дүнг тодорхойлоход ашигласан тооцооллуудад өөрчлөлт гарсан тохиолдолд л өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтыг буцаана. Хэрэв тийм бол хөрөнгийн бүртгэлийн дүнг цуглуулан авах дүн хүртэл нь өсгөж бүртгэнэ. Энэ өссөн дүн нь хэрэв өмнөх жилүүдэд хөрөнгөд үнэ цэнийн алдагдлыг хүлээн зөвшөөрөөгүй байсан бол байх ёстой байсан бүртгэлийн цэвэр дүнгээс (элэгдлийг хассан цэвэр дүнгээс) хэтрэхгүй байна. Ийм буцаалтуудыг дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө. Ийм буцаалтыг хийсний дараа, хөрөнгийн шинэ бүртгэлийн дүн (үлдэгдэл өртгийг хассан дүн)-г түүний ашиглалтын хугацаанд системтэйгээр хуваарилах үүднээс элэгдлийн зардалд залруулга хийнэ.

(м) Буцаан худалдан авах, урвуу буцаан худалдан авах хэлцлүүд

Ирээдүйд тодорхой заасан хугацаанд буцаан худалдан авах нөхцөлтэй хэлцэл ('репо')-ийн дор худалдсан үнэт цааснуудыг тайлан тэнцлээс үл хүлээн зөвшөөрдөггүй. Хүлээн авсан холбогдох бэлэн мөнгөө хуримтлуулсан хүүний хамт тайлан тэнцэлд 'Зээлдүүлсэн үнэт цаас ба буцаан худалдан авах хэлцлүүдийн бэлэн мөнгөөрх барьцаа' гэж тусгагдах ба энэ нь Банкинд олгосон зээл гэсэн эдийн засгийн утга агуулгыг илэрхийлдэг байна. Борлуулсан ба ирээдүйд буцаан худалдан авах үнийн зөрүүг хүүний зардал гэж үзэж үр ашигт хүүний аргыг ашиглан гэрээний хугацааны турш хуримтлуулна. Харин хөрөнгө хүлээн авагч нь тус хөрөнгийг борлуулах эсвэл барьцаанд тавих эрхтэй үед тус хөрөнгийг 'Барьцаанд тавьсан арилжаалах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хөрөнгө' гэж тайлан тэнцэлд бүртгэнэ.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2009 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (ҮРГЭЛЖЛЭЛ)

(м) Буцаан худалдан авах, урвуу буцаан худалдан авах хэлцлүүд (үргэлжлэл)

Харин буцаан худалдах хэлцэл ('урвуу репо')-ийн дор худалдан авсан үнэт цааснуудыг тайлан тэнцэлд хүлээн зөвшөөрдөггүй. Төлсөн мөнгө хуримтлуулсан хүүгийн хамт тайлан тэнцэлд 'Зээлсэн үнэт цаас ба урвуу буцаан худалдан авах хэлцлүүдийн бэлэн мөнгөөрх барьцаа' гэж тусгагдана. Худалдан авсан ба буцаан худалдах үнийн зөрүүг хүүгийн орлого гэж үзэж үр ашигт хүүгийн аргыг ашиглан гэрээний хугацааны турш хуримтлуулна.

(н) Санхүүгийн баталгаа

Банк бизнесийн хэвийн нөхцөлд голдуу тендерийн баталгаа болон аккредитивээс бүрдэх санхүүгийн баталгаануудыг гаргадаг. Санхүүгийн баталгааг санхүүгийн тайланд анхлан бүртгэхдээ бодит үнээр нь буюу хүлээн авсан урамшууллын дүнгээр "Бусад өр төлбөр"-т хүлээн зөвшөөрдөг. Ийнхүү анхлан хүлээн зөвшөөрсний дараа, баталгаа бүрт Банкны хүлээх хариуцлагыг хорогдуулсан урамшуулал ба уг баталгааны улмаас үүсэх аливаа нэг санхүүгийн үүргийг биелүүлэхэд шаардлагатай зардлын хамгийн сайн тооцоолсон дүн хоёрын аль ихээр нь хэмжинэ.

Санхүүгийн баталгааны холбогдох өр төлбөрийн аливаа өсөлтийг орлого, үр дүнгийн тайлангийн "Үнэ цэнийн бууралтын алдагдалын сан" дансанд бүртгэнэ. Хүлээн авсан урамшууллыг санхүүгийн баталгааны хүчинтэй байх хугацааны туршид нь шулуун шугамын аргаар тооцож дэлгэрэнгүй орлогын тайлангийн "Үйл ажиллагааны бусад орлого" дансанд хүлээн зөвшөөрнө.

(о) Ажиллагсдын тэтгэмж

(i) *Богино хугацаат тэтгэмж*

Цалин ба түүнтэй холбогдох бусад зардлуудыг Банкны ажилчдаас холбогдох үйлчилгээг үзүүлсэн тухайн жилд нь зардалд тусгана. Ажилтнуудад ээлжийн амралт зэрэг богино хугацааны чөлөөтэй үед нөхөн олговрыг ажилласан жилийг нь харгалзан олгодог бөгөөд өвчтэй байх хугацааны нөхөн олговрыг цаг тухайд нь олгодог.

(ii) *Заавал төлөх даатгалын шимтгэлүүд*

Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд нь Монгол Улсын эрүүл мэнд, нийгмийн даатгалын санд шимтгэл төлнө. Эдгээр шимтгэлийг гарсан хугацаанд нь дэлгэрэнгүй орлогын тайланд зардлаар хүлээн зөвшөөрнө.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2009 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

2.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУДАД ОРСОН ӨӨРЧЛӨЛТҮҮД

Банк нь дараах шинэ болон нэмэлт өөрчлөлт хийгдсэн НББОУС, СТОУС-ууд ба Санхүүгийн тайлагналын олон улсын тайлбарын хороо (“СТОУТХ”)-ноос гаргасан тайлбаруудыг тайлант хугацаанд дагаж мөрдсөн.

- * СТОУС 1 (Шинэчилсэн) СТОУС-ийг анхлан нэвтрүүлэх - Охин компани, хамтын хяналттай компани, хараат компани оруулсан хөрөнгө оруулалтын өртөг
- * СТОУС 2 (Нэмэлт өөрчлөлт) - Хувьцаанд суурилсан төлбөрүүд - Хэрэгжүүлэх нөхцөл болон цуцлалт
- * СТОУС 7 Санхүүгийн хэрэглүүр: Тодруулга (Нэмэлт өөрчлөлт)
- * СТОУС 8 Үйл ажиллагааны сегмент
- * НББОУС 1 (Шинэчилсэн) - Санхүүгийн тайлангийн толилуулга
- * НББОУС 23 (Шинэчилсэн) - Зээлийн зардал
- * НББОУС 27 (Нэмэлт өөрчлөлт) - Нэгтгэсэн ба салангид санхүүгийн тайлангууд - Охин, хамтын хяналттай, хараат компаниудад оруулсан хөрөнгө оруулалтын өртөг
- * НББОУС 32 (Нэмэлт өөрчлөлт) - Санхүүгийн хэрэглүүрүүд: Толилуулга ба НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга - Буцаан өгөх боломжтой санхүүгийн хэрэглүүрүүд ба дампуурлын улмаас үүссэн өр төлбөрүүд
- * СТОУТХ 9 (Нэмэлт өөрчлөлт) - Агуулагдсан үүсмэл хэрэглүүрийн дахин үнэлгээ ба НББОУС 39 Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт - Агуулагдсан үүсмэл хэрэглүүр
- * СТОУТХ 13 Харилцагчдад чиглэсэн хөтөлбөр
- * СТОУТХ 15 Үл хөдлөх хөрөнгийн барилгын ажлын гэрээ
- * СТОУТХ 16 Гадаад үйл ажиллагааны цэвэр хөрөнгө оруулалтын хеджи
- * СТОУТХ 18 Харилцагчаас хөрөнгө шилжих

Сайжруулсан СТОУС-ууд:

- * НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга
- * НББОУС 8 НББ-ийн бодлого, НББ-ийн тооцооллын өөрчлөлт, алдаа
- * НББОУС 10 Тайлант хугацааны дараахь үйл явдлууд
- * НББОУС 16 Үндсэн хөрөнгө
- * НББОУС 18 Орлого
- * НББОУС 19 Ажиллагсдын тэтгэмж
- * НББОУС 20 Засгийн газрын буцалтгүй тусламж ба туслалцааны толилуулга
- * НББОУС 23 Зээлийн зардал
- * НББОУС 27 Нэгтгэсэн санхүүгийн тайлан ба салангид санхүүгийн тайлан
- * НББОУС 28 Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт
- * НББОУС 29 Хэт инфляцитай эдийн засаг дахь санхүүгийн тайлагнал
- * НББОУС 31 Хамтарсан компани дахь хувь оролцоо
- * НББОУС 34 Санхүүгийн хэрэглүүрүүд: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт
- * НББОУС 36 Хөрөнгийн үнэ цэнийн бууралт
- * НББОУС 38 Биет бус хөрөнгө
- * НББОУС 39 Санхүүгийн хэрэглүүрүүд: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт
- * НББОУС 41 Хөдөө аж ахуй
- * СТОУС 7 Санхүүгийн хэрэглүүрүүд: Тодруулга

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2009 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

2.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУДАД ОРСОН ӨӨРЧЛӨЛТҮҮД (ҮРГЭЛЖЛЭЛ)

Дээр дурьдсан шинэ болон нэмэлт өөрчлөлт хийгдсэн стандарт, тайлбарууд нь дор дурьдсанаас бусад талаар НББ-ийн бодлого, санхүүгийн үр дүн болон банкны байдалд нөлөө үзүүлээгүй болно.

НББОУС 1 - Санхүүгийн тайлангийн толилуулга (шинэчилсэн)

Энэхүү стандарт нь байгууллагаас эзэмшигчдийн болон эзэмшигчдийн бус өмчийн бүх өөрчлөлтүүдийг “Дэлгэрэнгүй орлогын тайлан” гэсэн нэг тайлангаар эсвэл “Орлого, үр дүнгийн тайлан” ба “Дэлгэрэнгүй орлогын тайлан” гэсэн хоёр тусдаа тайлангаар толилуулахыг шаарддаг. Мөн энэхүү стандарт нь дэлгэрэнгүй орлогын бүрэлдэхүүн хэсэг нэг бүрийн орлогын албан татварын нөлөөллийг тодруулахыг шаарддаг. Үүнээс гадна энэ стандарт нь, байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн бодлогыг өмнөх хугацаануудад буцаан хэрэглэх бол (өнгөрсөн хугацааны санхүүгийн тайлангуудад залруулга эсвэл дахин ангилал хийх), хамгийн өмнөх тайлант жилийн эхэнд санхүүгийн байдлын тайланг харьцуулсан үзүүлэлтээр гаргахыг байгууллагаас шаарддаг.

Банк нь дэлгэрэнгүй орлогоо нэг тайлангаар толилуулах хувилбарыг сонгосон. Дэлгэрэнгүй орлогын бүрэлдэхүүн хэсэг нэг бүрийн, мөн түүнчлэн тэдгээрийн татварын нөлөөллийн талаарх мэдээллийг дэлгэрэнгүй орлогын тайланд тодруулж өгсөн. Банк нь буцаан хэрэглэх ямар нэгэн нягтлан бодох бүртгэлийг шинээр авч хэрэгжүүлээгүй учраас хамгийн өмнөх жилийн санхүүгийн байдлын тайлангийн харьцуулсан үзүүлэлтүүдийг засаж толилуулах шаардлага гараагүй.

СТОУС 7 - Санхүүгийн хэрэглүүр: Толилуулга - Санхүүгийн хэрэглүүрийн талаар хийх тодруулгуудыг сайжруулах (нэмэлт өөрчлөлт)

Санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ ба хөрвөх чадварын талаар хийх тодруулгыг сайжруулах зорилгоор 2009 оны 3 дугаар сард СТОУС 7-д нэмэлт өөрчлөлт хийсэн.

Бодит үнэ цэнийн тал дээр хийгдсэн нэмэлт өөрчлөлтүүд нь бодит үнэ цэнээрээ бүртгэгддэг бүх санхүүгийн хэрэглүүрүүдийн ангилал бүр дээр гурван түвшний тодруулгыг хийхийг, мөн түвшин ахисан, буурсан хэрэглүүрийн талаар тусдаа тодруулга хийхийг, 3 дугаар түвшний хэрэглүүрүүдийн талаар дэлгэрэнгүй тодруулга хийхийг шаардаж байгаа. Үүнээс гадна, хөрвөх чадварыг удирдахад хэрэглэдэг үүсмэл гүйлгээ, хөрөнгүүдийн хөрвөх чадварын шаардлагатай тодруулгуудад нэмэлт өөрчлөлт хийсэн.

Харьцуулсан мэдээллүүдийг засаж өөрчилсөн хэдий ч, энэхүү нэмэлт өөрчлөлтийн шилжилтийн заалтын дагуу бол энэ нь зайлшгүй шаардлагатай биш юм.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2009 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

2.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУДАД ОРСОН ӨӨРЧЛӨЛТҮҮД (ҮРГЭЛЖЛЭЛ)

Эдгээр санхүүгийн тайлангуудыг батлах өдрийн байдлаар дараахь стандарт, нэмэлт өөрчлөлт, тайлбарууд нь батлагдах шатандаа байсан ба хэрэгжиж эхлээгүй байсан болно. Үүнд:

- * СТОУС 1 (нэмэлт өөрчлөлт) СТОУС-ийг анхлан нэвтрүүлэх - Анхлан хэрэгжүүлэгч нарт үзүүлэх нэмэлт хөнгөлөлтүүд
- * СТОУС 2 Группийн бэлэн мөнгөөр хийгдэх, хувьцаанд суурилсан төлбөрийн зохицуулалтууд
- * СТОУС 3 (Шинэчилсэн) - Бизнесийн нэгдэл
- * СТОУС 5 Борлуулахаар эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө ба зогссон үйл ажиллагаа
- * НББОУС 27 (Нэмэлт өөрчлөлт) - Нэгдсэн ба бие даасан санхүүгийн тайлангууд
- * НББОУС 39 (Шинэчилсэн) - Санхүүгийн хэрэглүүрүүд: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

Шаардлага хангасан хэджинг хийгдсэн зүйлс

- * СТОУТХ 17 Мөнгөн бус хөрөнгийг эзэмшигчдэд хуваарилах
- * СТОУТХ 19 Санхүүгийн өр төлбөрийг өөрийн хөрөнгийн хэрэглүүрээр барагдуулах

Сайжруулсан СТОУС-ууд:

- * НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга
- * НББОУС 36 Хөрөнгийн үнэ цэнийн бууралт
- * НББОУС 38 Биет бус хөрөнгө
- * НББОУС 39 Санхүүгийн хэрэглүүрүүд: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт
- * СТОУС 2 Хувьцаанд суурилсан төлбөр
- * СТОУС 5 Борлуулахаар эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө ба зогссон үйл ажиллагаа
- * СТОУС 8 Үйл ажиллагааны сегмент
- * НББОУС 7 Мөнгөн гүйлгээний тайлан
- * НББОУС 17 Түрээс
- * НББОУС 18 Орлого
- * СТОУТХ 9 Агуулагдсан үүсмэл хэрэглүүрүүдийн дахин үнэлгээ
- * СТОУТХ 16 Гадаад үйл ажиллагааны цэвэр хөрөнгө оруулалтын хэджи

Банкны захирлууд нь НББОУС 39 “Санхүүгийн хэрэглүүрүүд: Хүлээн зөвшөөрөлт ба Хэмжилт” ба СТОУС 9-өөс бусад стандарт, нэмэлт өөрчлөлт, тайлбаруудыг ирээдүйд дагаж мөрдөхөд банкны санхүүгийн тайланд материаллаг нөлөөлөл үзүүлэхгүй гэсэн таамаглалтай байна. Энэ хоёр стандартын нөлөөллийг дор хэлэлцэв.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2009 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

2.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУДАД ОРСОН ӨӨРЧЛӨЛТҮҮД (ҮРГЭЛЖЛЭЛ)

СТОУС 9: Санхүүгийн хэрэглүүрүүд

Нягтлан бодох бүртгэлийн стандартын зөвлөл (НББОУСЗ)-өөс НББОУС 39 “Санхүүгийн хэрэглүүрүүд: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт”-ийг өөрчлөх өөрийн төслийн эхний алхам болгож СТОУС 9 “Санхүүгийн хэрэглүүрүүд”-ийг 2009 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр батлаж гаргасан. СТОУС 9 нь санхүүгийн хөрөнгийг ангилах, хэмжихэд тавигдах шинэ шаардлагуудыг танилцуулж байгаа юм. Эдгээр шаардлагууд 2013 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжих эхлэх ба дараахь гол өөрчлөлтүүдийг энэ өдрөөс өмнө хэрэгжүүлэхийг зөвшөөрсөн. Үүнд:

- (а) СТОУС 9 нь одоогийн НББОУС 39-ийн хамраж буй бүх санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг, “Хорогдуулсан өртгөөр нь бүртгэх”, “Бодит үнэ цэнээрээ бүртгэх” гэсэн хоёр бүлэгт хувааж байгаа юм. Энэ ангиллыг санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үед буюу байгууллага нь тухайн хэрэглүүрийн гэрээт заалтуудад оролцогч тал болсон үед хийнэ. НББОУС 39-д одоо байгаа “Борлуулахад бэлэн” ба “Дуусгавар хугацаа хүртэл эзэмших” гэсэн ангилалуудыг хассан.
- (б) СТОУС 9-ийн хамрах бүх хувьцааны хөрөнгө оруулалтууд (байгууллага бодит үнэ цэнийн зөрүүг нь “Бусад дэлгэрэнгүй орлого”-оор тайлагнахаар сонгон авсан хувьцааны хөрөнгө оруулалтаас бусад)-ыг санхүүгийн байдлын тайланд бодит үнэ цэнээр нь хэмжиж, бодит үнэ цэнийн зөрүүг олз эсвэл гарзаар хүлээн зөвшөөрнө. Хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй хувьцаанд “өртгийн хөнгөлөлт” байдаггүй.
- (в) “Бизнес загварын тест” ба “Мөнгөн гүйлгээний шинж чанарын тест”-ийн шаардлагыг хангаж байгаа өрийн хэрэглүүрийг хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ. Бусад бүх өрийн хэрэглүүрийг бодит үнэ цэнээр нь хэмжиж, зөрүүг олз эсвэл гарзаар хүлээн зөвшөөрнө. Хэрэглүүр нь дээрх хоёр төстийн шаардлагыг хангасан хэдий ч, СТОУС 9 нь санхүүгийн хөрөнгийг “Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, зардлын дансанд бүртгэгдэх” гэж ангилах (хэрэв ингэж ангилах нь бүртгэлийн тууштай биш байдлыг ихээхэн хэмжээгээр бууруулж байвал) хувилбарыг агуулдаг.
- (г) НББОУС 39-д байдаг агуулагдсан үүсмэл хэрэглүүрийн тухай ойлголт СТОУС 9-д байхгүй. Үүний улмаас НББОУС 39-ийн дагуу “Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, зардлын дансанд бүртгэгдэх” гэж тусдаа бүртгэгдэх байсан агуулагдсан үүсмэл хэрэглүүрийг салгаж бүртгэх шаардлагагүй болсон. Харин түүний оронд тухайн санхүүгийн хөрөнгийн гэрээт мөнгөн урсгалыг нийтэд нь үнэлэх ба хэрэв түүний мөнгөн урсгалын аль нэг нь үндсэн болон хүүний төлбөрийг илэрхийлэхгүй байгаа бол хөрөнгийг бодит үнэ цэнээр нь хэмжиж, бодит үнэ цэнийг зөрүүг олз эсвэл гарзаар хүлээн зөвшөөрнө.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2009 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

2.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУДАД ОРСОН ӨӨРЧЛӨЛТҮҮД (ҮРГЭЛЖЛЭЛ)

НББОУС 39 “Санхүүгийн хэрэглүүрүүд: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт”-д орсон нэмэлт өөрчлөлтүүд

НББОУС 39-д орсон нэмэлт өөрчлөлтүүд нь зээлийн эргэн төлөлттэй холбоотой торгуулийг агуулагдсан үүсмэл хэрэглүүр гэж үнэлэх талаар танилцуулсан. Хэрэгжих үнэ нь үндсэн гэрээний үлдсэн хугацаанд алдах хүүний өнөөгийн үнэ цэнийг зээлдэгчид нөхөж өгч байгаа тохиолдолд урьдчилгаа төлбөрийн обционыг үндсэн гэрээтэйгээ нягт холбоотой гэж үзнэ.

Банк энэ шинэ СТОУС-ыг анх хэрэглэхэд үзүүлэх нөлөөллийг үнэлэх ажлыг хийж байна.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2009 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

2.4 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТОМООХОН ҮНЭЛЭЛТ БА ТООЦООЛЛУУД

Дараагийн санхүүгийн тайлант жилд хөрөнгө, өр төлбөрийн бүртгэлийн дүнд материаллаг залруулга хийхэд хүргэж болзошгүй, тайлан тэнцлийн өдөр хийгдсэн ирээдүйн талаарх гол таамаглалууд ба ойролцоолсон тооцооллын тодорхойгүй байдлын талаарх бусад гол эх үүсвэрүүдийг дор тодруулсан болно. Үүнд:

Зээл ба урьдчилгааны болзошгүй алдагдлын сан

Банк нь үнэ цэнийн бууралтын алдагдлын санг орлого, үр дүнгийн тайланд бүртгэх шаардлагатай эсэхийг үнэлэх үүднээс тайлагналын өдөр бүр асуудалтай зээл, урьдчилгаануудыг хянаж үздэг. Тухайлбал, шаардлагатай сангийн түвшинг тодорхойлох үед ирээдүйн мөнгөн урсгалын дүн, хугацааг ойролцоолон тооцоолоход удирдлагын үнэлэмж шаардагддаг. Ийм тооцоолол нь олон тооны хүчин зүйлүүдийн талаарх таамаглалууд дээр үндэслэдэг ба бодит үр дүнгээс өөр байж болох бөгөөд энэ нь ирээдүйд сангийн хэмжээнд өөрчлөлт оруулахад хүргэж болно.

3. ХҮҮНИЙ ОРЛОГО

	2009 сая төгрөг	2008 сая төгрөг
Санхүүгийн хөрөнгө оруулалт - Борлуулахад бэлэн	7,789	10,006
Урвуу буцаан худалдан авах хэлцлүүд	371	4,208
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө, хадгаламж	1,257	10,415
Сангийн яам, дотоодын банкуудад олгосон зээл	6,697	4,930
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, зардлын дансанд бүртгэгддэггүй санхүүгийн хөрөнгийн хүүний нийт орлого	16,114	29,559

4. ХҮҮНИЙ ЗАРДАЛ

	2009 сая төгрөг	2008 сая төгрөг
Гаргасан үнэт цаас	26,824	7,827
Гадаад өр төлбөр	1,866	340
Засгийн газрын байгууллагуудын хадгаламж	313	3,004
Дотоодын санхүүгийн байгууллагуудын хадгаламж	1,787	350
Буцаан худалдан авах гэрээнүүд	478	343
